Монголын хил судлалын академи, ДХИС-ийн Хилийн албаны сургууль,
Хилийн аюулгүй байдал судлалын төв

ХИЛ СУДЛАЛ

ШИНЖЛЭХ УХААН, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУРГАЛТ, АРГА ЗҮЙ, ТАНИН МЭДЭХҮЙН УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛ



2025

03

СЭТГҮҮЛИЙН РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

Сэтгүүлийн эрхлэгч:

Доктор, профессор Ц.Ганболд — ОУМА-ийн академич

Сэтгүүлийн ерөнхий редактор:

Докторант, хурандаа Г.Галбадрах — Хилийн албаны сургуулийн захирал, хилийн цэргийн 0345 дугаар ангийн захирагч

Хариуцлагатай нарийн бичгийн дарга:

Докторант,
Хошууч Т.Баяр-Эрдэнэ — Хилийн албаны сургуулийн Инженер техникийн тэнхимийн профессор

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ:

ОУМА-ийн академич, доктор, тэргүүлэх профессор, хурандаа Г.Дагважамц

РЕДАКЦЫН ГИШҮҮД:

Доктор, дэд профессор, хурандаа М.Баярсайхан

Доктор, хурандаа Х.Асхар

Доктор, хурандаа Ц.Одонгэрэл

Доктор, дэд хурандаа Б.Мөнхбат

Докторант, дэд хурандаа М.Баттулга

Докторант, хурандаа М.Мөнхбаяр

Докторант, дэд хурандаа Г.Одон-Ертөнц

ГАДААД ГИШҮҮД

Шинжлэх ухааны доктор, профессор Филиппов Станислав Александрович

Доктор, профессор Жулак И

Доктор, профессор Жеймс Б.Паттисон

Доктор, дэд профессор Хармаев Юрий Владимирович

Дугаарыг эрхэлсэн:
Докторант,
Хошууч Т.Баяр-Эрдэнэ

Хэвлэлийн хуудас:

Хянан тохиолдуулсан:
Доктор, профессор, хурандаа Ц.Ганболд

Редакцын хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, VIII хороо, Хилчний гудамж, ДХИС-ийн хичээлийн III байр, 518 тоот

Утас: 976 86008998

Цахим шуудан: hilsudlal@gmail.com

Эрхлэх байгууллага: Монголын Хил Судлалын Академи, ДХИС-ийн Хилийн албаны сургууль, Хилийн аюулгүй байдал судлалын төв

ХИЛ СУДЛАЛ

МОНГОЛЫН ХИЛ СУДЛАЛЫН АКАДЕМИ, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХИЛИЙН АЛБАНЫ СУРГУУЛЬ, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ СУДЛАЛЫН ТӨВИЙН ОНОЛ-МЭДЭЭЛЛИЙН СЭТГҮҮЛ

27 ДАХЬ ЖИЛДЭЭ **УЛИРАЛД НЭГ УДАА**

№03

2025 он

АГУУЛГА

ХИЛ СУДЛАЛ-ОНОЛ ПРАКТИК

Ц.Ганболд: Монгол Улсын баатар П.Чогдон Чөлөөлөх дайнд Халхын голын отрядыг удирдан оролцсон нь

Б.Баттүвшин: Олон улсын хилийн аюулгүй байдлын шинэ хандлага

Г.Сайнбаяр: Нисгэгчгүй нисэх хэрэгслийн үүсэл ба цаашдын чиг хандлага

Ш.Ундарга: Хил хамгаалалтын техник хэрэгслийн нэр томьёо

Т.Ариунсүх: Хил хамгаалах байгууллагын алба хаагчийн сэтгэл зүйн өнөөгийн байдал, түүнийг удирдахуйн асуудал

ХИЛИЙН ЭРХ ЗҮЙ

Х.Асхар: Монгол Улсын хил халдашгүй, дархан байх зарчим үндсэн хуулийн суурь ойлголт болох нь

Н.Сайнбаяр: Хил орчмын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах онцлог

П.Батбаатар: Шалган нэвтрүүлэх алба ба хүн худалдаалах гэмт хэрэг

С.Энхчимэг:Хилийн шалган нэвтрүүлэх албаны эрх зүйн орчин, тулгамдаж буй зарим асуудал

ХИЛИЙН ТҮҮХ

Ц.Ганболд: Жанчхүүгийн даваанд жанжин тугаа цэнгүүлсэн аян замын тэмдэглэл- №30

М.Мөнхтамир: Монгол Улсын Дотоодын цэргийн байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт

Г.Одбилэг: Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилтийг хангахад ёс зүйн дэд хорооны гүйцэтгэх үүрэг

МОНГОЛ УЛСЫН БААТАР П.ЧОГДОН ЧӨЛӨӨЛӨХ ДАЙНД ХАЛХЫН ГОЛЫН ОТРЯДЫГ УДИРДАН ОРОЛЦСОН НЬ

“Өнгөрсөн бүхэн удмынхны нь зүрх сэтгэлд оршин, байнга сэргээгдэж байдаг юм”. Л.Гумилев


Ц.ГАНБОЛД
ДХИС-ийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Хилийн аюулгүй байдал судлалын төвийн ахлах судлаач, доктор (Ph.D), профессор, хурандаа

Хураангуй: Чөлөөлөх дайнд Халхын голын Хилийн 24-р отрядын дарга П.Чогдонгийн удирдсан Отряд болон түүнээс томилогдсон хөдөлгөөнт группүүд хэрхэн байлдааны даалгавар биелүүлсэн талаар өгүүлнэ.

Түлхүүр үг: Чөлөөлөх дайн, Халхын голын 24-р отряд, Монгол Улсын баатар П.Чогдон, хөдөлгөөнт отряд/групп, Хайлаар хот, Вангийн сүм.

Агуулга: Дэлхийн II дайны төгсгөлд Монгол Ардын Хувьсгалт Цэрэг, Зөвлөлтийн улаан армийн хамт Зүүн хойд Хятад, Өвөр Монголыг чөлөөлсөн нь дэлхий дахины энх тайванд үнэтэй хувь нэмэр оруулсан XX зууны Монголын түүхийн маш том үйл явдал болсон юм.

Манжуурт хийсэн Зөвлөлтийн цэргийн ажиллагаа (ажиллагаа)



“Японы империализмыг бут цохиход БНМАУ оролцсон нь” (1945 он). “Монго
Арми 50 жил”. Баримт, гэрэл зургууд.

1945 оны Чөлөөлөх дайны ялалт нь зөвхөн Монгол Улсын төдийгүй бүс нутгийн мартагдашгүй ач холбогдолтой үйл явдал байсан гэж үздэг. Энэ дайны ялалтаар 1945 онд Төв, Зүүн, Зүүн өмнөд Азийн 5 орон тусгаар тогтнолоо зарлаж байлаа. Энэ дайны ялалтын үр дүнд Монгол Улсын тусгаар тогтнолыг олон улсын тавцанд баталгаажуулж, Монгол Улс дэлхийн хамтын нийгэмлэгт гишүүнээр элсэх үүд хаалгыг нээсэн түүхэн чухал үйл явдал болсон юм.

БНМАУ-ын ДЯЯ-ны сайд “Хувьсгалт цэргийн байлдаж буй анги нэгтгэлүүдийн ар талд журам зарчмыг зохион хангах, ар талыг хамгаалах хөдөлгөөнт отрядуудыг байгуулах тухай” 1945 оны наймдугаар сард 301 тоот тушаал гаргасан юм.

Энэ тушаалд байлдаанд орсон цэргийн анги, нэгтгэлүүдийн ар талд журам дэглэм сахиулж, ар талыг хамгаалахын хамт японы тагнуул, хорлон сүйтгэгч, монгол оргодлуудыг илрүүлэн, баривчлах үүрэгтэй зохих тооны хөдөлгөөнт отрядуудыг байгуулах, тэдгээрийн удирдлага, бүрэлдэхүүн, зэвсэглэл, холбоо харилцаа, машин уналга зэрэг хүч хэрэгслийг тодорхойлон дурьджээ.

Мөн тушаалд чөлөөлөгдсөн ард түмэнд БНМАУ-ын төрийн бодлогыг ойлгуулах үүргийг отрядуудад өгсөн байна.

Чөлөөлөх дайнд Хилийн цэрэг, хилчдийн оролцооны талаар хилийн цэргийн ганц нэг хүн л ярихаас манай цэргийн түүхчид ор дурсдаггүй билээ. 9 хилийн отрядоос 9 тусгай групп дээрх үүргүүдийг нэр төртэй гүйцэтгэсэн билээ.

Халхын голын Хилийн 24-р отряд дайн эхлэхэд Монголын зүүн өмнөд хил Соёлз уул, Халзангийн даваанаас зүүн тийшээ Шилийн худаг хүртэл 210 км хилийн хэсгийг хилийн шугамын 3 суман, 9 застав, бэлтгэл суман бүхий хамгаалж байв.

Отрядын төв хилийн шугамаас 100 км зайтай Баянбүрдэд байрлаж байжээ. Үүнээс гадна Зөвлөлтийн тусгай хороо Хамар даваанд төвлөрөөд, 5 застав, 10 посттойгоор манай хилчидтэй хамтран хил хамгаалж байжээ.

1945 оны 7 дугаар сарын туршид 24-р отряд бүхэлдээ байлдааны бэлэн байдалд орсон бөгөөд хамгаалж байсан хилийн зурвас нь 1939 оны Халхын голын дайн болсон гол газар юм.

Гадаад цагийн байдлын хувьд: Японchууд Халуун рашааны бэхлэлт барих ажлыг 1941-1943 оны турш хийж, энэ ажилд 8000 гаруй хятад иргэдийг дайчлан ажиллуулсан бөгөөд ажлаа дуусгуулаад бүгдийг нь хядаж устгасан байсан. Чөлөөлөх дайн эхлэхэд Халуун рашааны төвд явган дивиз-1, морин хороо-1, их буу, холбоо, тагнуулын анги салбарууд зэрэг ихээхэн хүч хуримтлуулсан байсан.

Мөн манай хил дээр болон Өвөр Монголын нутгийн гүнд тагнуул явуулах, тагнуулын байгууллагуудыг нэгтгэн удирдах Тагнуулын төв газар байрлаж байв. Хилийн 24-р отрядын хамгаалж байсан хэсгээр Япон-Манжгогийн

зүгээс жилд 200-300 удаа хилийн зөрчил, будилаан гаргаж, 100 гаруй тагнуулыг баривчлан, үүргээ нэр төртэй гүйцэтгэж байжээ.

Хилийн /Баянбүрдийн/ 24



дүгээр отрядын дарга, хошууч Пунцагийн Чогдон, улс төрийн орлогч, хошууч С.Балжинням нарын удирдсан 2 групп Баргын Халуун рашаан, Хайлаар, Солон хотын чиглэлд байлдааны ажиллагаа явуулав.

ЗСБНХУ-ын Засгийн газар Японд дайн зарласан анхны өдөр Улаан армийн тэргүүний ангиуд тус отрядын хамгаалж байгаа хилийн хэсгээр улсын хил нэвтрэх болсон учир Зөвлөлтийн дивизийн удирдлага, генерал Палчановын хүсэлтээр Халхын голыг гатлахад тус отрядынхан тусалж, дайнд эхлэн оролцсон байна.

С.Балжинням, О.Банди, П.Дэмиддагва /тус отрядад дадлага хийж байсан/ нарын офицерууд, бага дарга, цэргүүдийн хамт голыг гатлан газарчилж, улмаар толгойн сэргийлэхийн үүрэг гүйцэтгэн Зөвлөлтийн цэргийн хамт давшиж, Японы цэргийн эсэргүүцэлтэй анх тулгарч дайсны заставын 22 хүнийг устгажээ. Ийнхүү П.Чогдонгийн удирдсан отрядын хөдөлгөөнт бүлэг хилчдээс анх удаа байлдааны үүрэг авч, байлдааны даалгавраа нэр төртэй гүйцэтгэж, анх жинхэнэ байлдаанд /боевое крещение/ орсон юм.

Манай хилчид Халуун рашаанд байрласан японы цэрэг-тагнуулын хүчинд цохилт өгөхөд Зөвлөлтийнхөнтэй хамт оролцож 2 хоногийн дараа буцаж ирэхэд тус бүрдээ 100-175 хүнтэй хөдөлгөөнт 2 групп зохион байгуулагдсан байв.

Эдгээр групп Халуун рашаан, тэр хавийн төмөр замын дагуух газрууд, Хянганы нурууны ар талын буриад, баргын нутагт хүрэв. Тэндээс П.Чогдонгийн групп Хайлаар хот, С.Балжиннямын групп 5 хэсэгт хуваагдаж Л.Чулуунбаатарын удирдсан өмнөд чиглэлийн хэсэг Вангийн сүм хүртэл байлдааны үүрэг гүйцэтгэж, японы цэргийн үлдэгдлийг илрүүлэн олж цохилт өгөх, тагнуул, хорлон сүйтгэгчдийг баривчлахын зэрэгцээ дарлагдан зовж байсан бага буурай үндэстний жирийн хөдөлмөрчдийн хурлыг зохион байгуулж, орон нутгийн түр захиргааг сонгож байгуулах, дайны хөлд өртсөн аж ахуйгаа эмхлэхэд нь тусалсан юм.

Японы эзэмшилд олон жилийн турш амьдарч байснаас тэдний нөлөөнд автсан сүм хийдийн олон зуун лам, сүсэгтний дунд онцгой болгоомж, хүлээцтэй хандаж, өөрийн чөлөөлөх зорилгыг зөв ойлгуулах, Японы түрэмгийлэгчдийн үнэн нүүр царай, хор уршгийг илчлэн харуулах явдлыг сайн зохион байгуулсан нь байлдааны замд тохиолдол бэрхшээлийг нэлээд хөнгөвчилсөн ажээ.


Хилийн отрядууд Чөлөөлөх дайнд оролцсон нь

П.Чогдон, С.Балжинням нарын удирдсан 2 группийн хилчид эх орны даалгаврыг нэр төртэй биелүүлж, Манжуурын зарим нутагт орогнож байсан дайсны дунд офицер, бага дарга тус бүр 6, цэрэг 30, хилийн цагдаа 89, хошууны цагдаа 25, бүгд 156 хүнийг цэрэг дайны гэмтний хувьд баривчлан авч ирсэн байна.

Тус отрядынханд ологдогсдын дотор японы тагнуулын байгууллагын албан хаагчид, японы цэрэг-тагнуулын газруудад олон жилийн турш үйлчлэн тусалж байсан Оросын цагаантны офицерууд, эх орноосоо урваж японы талд идэвхтэй туслагчид зэрэг гэмт хэрэгтнүүд байжээ.

Тус отрядынхан Японы цэргийн дарангуйлалд байсан янз бүрийн ястан үндэстний ард иргэдээс улс төр, аж ахуйн үйл ажиллагааг шинээр зохион байгуулахад нь төлөөлөгчийн ёсоор тусалж, эх орны даалгаврыг амжилттай биелүүлсэн юмаа.

Чөлөөлөх дайнд харьяа отрядоо удирдан, байлдааны үүргийг нэр төртэй биелүүлсэн тул П.Чогдонг Байлдааны гавьяаны одонгоор шагнажээ[1].

БНМАУ-аас дайнд орох шийдвэр гаргахдаа Японы түрэмгийлэгчдийг бут цохиж, Өвөр Монголын нутгийг чөлөөлөх цэргийн бодлогын зэрэгцээ чөлөөлөгдсөн нутагт явуулах улс төрийн бодлогыг боловсруулж, түүнийг удирдан чиглүүлэх үүрэгтэй Засгийн газрын төлөөлөгчдийг томилсон байна. Үүнд: БНМАУ-ын Ерөнхий сайдын орлогч Б.Ламжав Өвөр Монголд, МАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга Н.Лхамсүрэн Хөлөн буйрын Баргад БНМАУ-ын засгийн газрын төлөөлөгчөөр томилогдон ажиллажээ.

1945 оны 8 дугаар сарын 10-нд Хөлөнбуйрт Зөвлөлтийн Улаан армийн цэргүүд цөмрөн орж, Японы цэргээс чөлөөлсөн бөгөөд харин БНМАУ-ын зүгээс төлөөлөгч Н.Лхамсүрэнгийн удирдсан Хилийн цэргийн отряд Хөлөнбуйрт 8 дугаар сарын 19-нд хилээр нэвтэрч, үдэш нь Хөлөнбуйрын Шинэ барга Баруун хошууны төв Алтан эмээлд очиж тусгай үүрэг гүйцэтгэжээ. БНМАУ-ын Засгийн газрын төлөөлөгч Н.Лхамсүрэнгийн бичсэн илтгэл ГХЯ-ны архивд[2] хадгалагдаж байна. БНМАУ-ын Засгийн газрын төлөөлөгч нь нэлээд өргөн эрх мэдэлтэй байсан бөгөөд шийдвэрээ тушаал гарган, тамга дарж баталгаажуулдаг байжээ.

Түүний удирдлагад улс төрийн ажилтан, орчуулагч зэрэг ажлын аппаратаас гадна Хилийн цэргийн отряд, Ардын өөрийгөө хамгаалах сайн дурын морьт отряд болон Дотоод яамны тусгай отрядууд багтаж байсан бололтой. Тухайлбал, Баргад томилогдон

[1] Н.Даваадорж. “Чөлөөлөх дайнд хилийн цэргийн оролцоо”. //Чөлөөлөх дайн 70 жил: Түүх, сургамж. ЭШХ-ын эмхэтгэл. Эмхэтгэсэн: С.Ганболд., Х.Шагдар., Ж.Базарсүрэн., Т.Эрдэнэхишиг., Н.Хүдэрбат., Ц.Бямба-Эрдэнэ., Т.Уранчимнг. УБ., 2016. Т. 39-40.

[2] ГХЯ-ны архив. Хөмрөг 5. Данс 2. Хадгаламжийн нэгж 3. Тал 1-50.

ажилласан Н.Лхамсүрэнгийн удирдлагад улс төрийн ажилтан /ШУ-ны хүрээлэнгийн судлаач цэдэн/, япон хэлний 2 орчуулагч, Манжуурын талаар мэргэжсэн 3 ажилтан явжээ.

Мөн ДЯЯ-ны 5-р хэлтсийн ахлах дэслэгч Даваажавын удирдсан гүйцэтгэх бүлэг, сайн дурын байлдагчдаас бүрдсэн тусгай хэсэг, “Цог” хэмээх тусгай отряд явсан байна. “Цог” отрядын бүрэлдэхүүнд ДЯЯ-ны тусгай бүлгийн 13 ажилтан, сонины 6 ажилтан, кино механикч, байлдагчийн үүргийг хавсран гүйцэтгэх 10 жолооч багтсан бөгөөд нийт 119 хүн явсан байна. Тэд 100000 сум бүхий гар пулемёт, автомат, герман винтовоор зэвсэглэжээ. Баргад томилогдон ажилласан Н.Лхамсүрэн нь 8 дугаар сарын 19-нөөс 8 дугаар сарын 30 хүртэл 10 хоног Хөлөнбуйрын Шинэ барга баруун, зүүн хошуу, Хайлаар, Хуучин барга, Солон баргад ажилласан байна.

Засгийн газрын төлөөлөгчийн мэдэлд үүрэг гүйцэтгэсэн Хилийн цэргийн отряд нь П.Чогдонгийн удирсан хилийн хөдөлгөөнт отрядтай яг нэг чиглэлд үүрэг гүйцэтгэсэн байгаа бөгөөд эдгээр нь нэг отряд уу?, өөр отряд үүрэг гүйцэтгэсэн юм уу? гэдгийг тодруулах зайлшгүй шаардлага гарч байгаа юм.

Төгсгөл:

Монгол Улсын баатар П.Чогдон нь дэлхийн 2 дугаар дайны эхлэл болох Халхын голын дайнд Хилийн Эрс уулын застав, дэлхийн 2 дугаар дайны төгсгөл Чөлөөлөх дайнд Хилийн 24 дүгээр отряд, түүний хөдөлгөөнт отрядыг удирдан амь биеэ үл хайрлан тулалдсан дайны баатар, Япон улсын дайнд оролцсон Холбоотон орнуудын цэргийн Ерөнхий командлагч генерал Дуглас Макартурын тушаалаар Японы цэргийн гэмт хэрэгтнүүдийн баривчилж, Токио хотод 1946-5-9-нөөс 1948-11-12-ны хооронд хуралдсан Алс дорнодын олон улсын шүүхээр хэлэлцэн ял онооход, БНМАУ-ын Засгийн газрын олон улсын шүүхийн үйл ажиллагаанд оролцох гэрчээр Тамсагийн отрядын даргаар ажиллаж байхдаа томилогдож, 1948 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн шүүх хуралд БНМАУ-ын эсрэг өдүүлсэн Японы түрэмгийллийн талаар цогтой үгээ хэлсэн Гэрч-Төлөөлөгч, энхийн хөдөлмөрт хөлсөө дуслуулан Маршал Чойбалсангийн нэрэмжит 5 дугаар морьт дивизийн үргэлжлэл, Барилгын цэргийн 021 дүгээр анги, Барилгын 5 дугаар батальоны захирагчаар 1961-1982 онуудад 21 жил тасралтгүй ажиллан, Биокомбинат зэрэг олон томоохон бүтээн байгуулалтыг гардан зохион байгуулсан энх хөдөлмөрийн баатар, бидний бахархан дуурайх, дурсах эрхэм хүн мөнөөс мөн болно.

20 дугаар зуунд Монгол Улсын гадаад улсуудтай хийсэн бүх дайн энэ л эх орончоор эхэлж, энэ л

хүн дуусгаж эцсийн цэгийг тавьсан[3].

Жич: Японы зүгээс 1932-1945 оны 8 дугаар сарын 20-ныг хүртэлх хугацааны дотор БНМАУ-ын хилийг удаа дараа бүрэн зэвсэг бүхий цэргийн хүчийг хэрэглэж, автомашинаар 44 удаа, нисэх онгоцоор 67 удаа, мөн уналга бүхий зэвсгийн хүчээр 191 удаа, явган цэргийн хүчээр 3 удаа бүгд 308 удаа манай улсын хил хязгаарын дотор цөмрөн зэвсэгт мөргөлдөөнийг өдүүлж, довтолсноос гадна тагнуулуудыг 831 удаа хил зөрчүүлж, 903 тооны тагнуулчдыг явуулж, хорлог сүйтгэх, тагнуул элсүүлэх,эсэргүү ухуулга хаях, орон нутгийн ардын мал хөрөнгийг дээрэмдэн авах, галдан шатаах, улсын хилийн овоо тэмдгийг эвдүүлэх зэрэг хэргүүдийг өдүүлж байжээ[4].

БНМАУ-аас дайны төлбөртэй холбогдуулан 1946-5-30-ны өдөр гаргасан баримтад: "Японы эзэрхэг түрэмгийчүүдээс манай БНМАУ-д 1935 ба 1937 он, 1939-1945 оны 9 дүгээр сарыг хүртэл учруулсан хохирлыг албан ёсоор тогтоосон актуудад Тус улсын хилийг хамгаалах хязгаарын ангиудад учруулсан бүх хохирол 83.896.249 төгрөг болно[5]" хэмээн тодорхойлжээ.

Хязгаарын 9, 12, 17, 20, 23, 24, 27 дугаар отрядын чиглэлээр Дотоод Монгол ба Манжийн хошуудаас офицер 227, цэрэг 1965 нийтдээ 2192 /**2319 хүн, хилийн 31-р отрядын мэдээ ороогүй/** дарга, цэрэг олзолсон "олзлогдсон" гэдэг.

Дүгнэлт:

1.Чөлөөлөх дайнд Хилчдийн оролцоо, дайчин замналыг судлах явцад өмнө нь 8 отряд Чөлөөлөх дайнд оролцсон гэдэг байсан бол 9 отрядын хөдөлгөөнт отряд/групп оролцсон болохыг /Сангийн далайн отряд/ доктор Н.Даваадорж тодруулсан болно.

2.Засгийн газрын төлөөлөгчийн мэдэлд үүрэг гүйцэтгэсэн Хилийн цэргийн отрядын талаар тодруулан судлах зайлшгүй хэрэгцээ, шаардлага гарч байгаа нь Чөлөөлөх дайнд Монголын хилийн цэрэг, хилчдийн гүйцэтгэсэн үүргийг бүрэн гүйцэд гаргахад нэн чухал болж байна.

3.Чөлөөлөх дайнд Хилийн цэргийн гүйцэтгэсэн үүрэгтэй холбогдуулан онцлон тэмдэглэх нь, дайны төгсгөлөөр Өвөр Монголоос баригдаж ирсэн нэлээд хүмүүсийг хилийн зарим отрядад хорьж байсан бололтой. Тухайлбал, Хилийн нэгэн отрядад Өвөр Монголоос баривчилж авчирсан 90 шахам хүнийг 1946 он гартал хорьж мөрдөн байцаагаад 1946 оны эхээр ДЯЯ-наас хошууч Гомбосүрэнгийн удирдсан мөрдөн байцаагчдыг томилон

[3] Ч.Алтангэрэл. Чөлөөлөх дайн ба Монголын хилчид. УБ.,2025 он. Т-399.

[4] ГХЯ. Төв архив. х 59, д 1, хн, т 1

[5] ГХЯ. Төв архив. х 59, д 1, хн, тт 2-4

явуулж хэргийг нь таслан шийдвэрлэжээ. Тэднийг БНМАУ-ын эсрэг тагнуул хийсэн, хорлон сүйтгэх ажиллагаа явуулсан, хилчид болон ард иргэдийн амь нас, эд хөрөнгөнд халдсан, эх орноосоо урвасан зэрэг хэргээр мөрдөн байцааж яллажээ[6].

Цаашид Чөлөөлөх дайны үед Хилийн цэргийнхэн Барга, Өвөр Монголоос нийт хичнээн хүнийг баривчилж авчирсан, тэдний хэд нь Барга, Өвөр Монголын харьяат болох, тэднийг хэрхэн шүүсэн, тэд үнэхээр гэмт хэрэгтэн байсан эсэх зэргийг нягтлан судлах шаардлагатай байна[7] гэж доктор Г.Мягмарсамбуу тэмдэглэснийг хилчин эрдэмтэд нягтлан судлах шаардлагатай.

Ашигласан бүтээлийн жагсаалт:

1.ГХЯ-ны архив. Хөмрөг 5. Данс 2. Хадгаламжийн нэгж 3. Тал 1-50.

2.Дэлхийн 2 дугаар дайны төгсгөл: Чөлөөлөх дайн 1945. УБ., 2025 он.

3.Монгол Улсын хил хамгаалалтын түүхэн тэмдэглэл. УБ.,1993 он.

4.Г.Мягмарсамбуу. Дэлхийн хоёрдугаар дайны төгсгөл Чөлөөлөх дайн 1945 он. УБ., 2025.

5.Б.Эрдэнэбилэг. 1945 оны чөлөөлөх дайн ба Монголын тусгаар тогтнол. УБ., 2025 он.

6.Чөлөөлөх дайн-1945 /Сонины мэдээ, нийтлэл, өгүүлэл, дурсамж/. УБ., 2025 он.


7.Ч.Алтангэрэл. Чөлөөлөх дайн ба Монголын хилчид. УБ., 2025 он.

8.Российско-Монгольское вүеннүе сотрудничество /1911-1946/. Сборник документов. Часть-1. Москва., 2019 г.


9.Российско-Монгольское вүеннүе сотрудничество /1911-1946/. Сборник документов. Часть-2. Москва., 2019 г


[6] Ч.Амархүү. Хилчид, тагнуулуудыг шүүн тасалсан нь. Эх орны маная сонин. 2020. 8 дугаар сар. №21 /2976/.

[7] Г.Мягмарсамбуу. Дэлхийн хоёрдугаар дайны төгсгөл Чөлөөлөх дайн 1945 он. УБ., 2025. Х-128.


РОССИЙСКО-МОНГОЛЬСКОЕ
ВОЕННОЕ СОТРУДНИЧЕСТВО
(1911–1946)
Сборник документов
Часть I
Москва
2019



РОССИЙСКО-МОНГОЛЬСКОЕ
ВОЕННОЕ СОТРУДНИЧЕСТВО
(1911–1946)
Сборник документов
Часть II
Москва
2019


ТОКИО 48
Баримтат түүж


Л.Н. СМИРНОВ, Е.Б. ЗАЙЦЕВ
СУД
В
ТОКИО


ЧӨЛӨӨЛӨХ ДАЙН - 1945
Сонины мэдээ, нийтлэл, өгүүлэл, дурсамж


ДЭЛХИЙН ХОЁРДУГААР ДАЙНЫ
ТӨГСГӨЛ ЧӨЛӨӨЛӨХ ДАЙН
1945 он


ДЭЛХИЙН
II ДАЙНЫ ТӨГСГӨЛ:
ЧӨЛӨӨЛӨХ ДАЙН
1945 он
2025 он


1945 ОНЫ ЧӨЛӨӨЛӨХ ДАЙН
ба
МОНГОЛЫН ТУСГААР ТОГТНОЛ


ХУРАНДАА
Ч.АЛТАНГЭРЭЛ
ЧӨЛӨӨЛӨХ ДАЙН БА
МОНГОЛЫН ХИЛЧИД

ОЛОН УЛСЫН ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ШИНЭ ХАНДЛАГА

Б.БАТТҮВШИН*
Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн 8022 дугаар дамжааны суралцагч, дэд хурандаа
*хариуцлагатай зохиогч: btuvshin005@gmail.com

Хураангуй:

Орчин цагийн даяаршлын нөхцөлд хил дамнасан бараа, хүн, мэдээлэл, гэмт хэргийн урсгал эрчимжихийн хэрээр “хилийн аюулгүй байдал” хэмээх ойлголт улс төр, аюулгүй байдлын судалгааны гол асуудлын нэг болж байна. Гэвч хилийн аюулгүй байдлыг онолын хувьд тодорхойлох, эмпирик хэмжүүрээр илэрхийлэх нь нэгдсэн ойлголтод хүрээгүй, зөрчилдөөн хэвээр байгаа нь судалгааны гол тулгамдсан асуудал болсоор байна. Энэхүү өгүүллийн зорилго нь хилийн аюулгүй байдлын агуулгыг тодорхойлж, хил дамнасан урсгалын шинэ шинж чанар, тэдгээрт улс орнуудын хэрэгжүүлж буй хяналтын бодлогын онцлогийг шинжилж, хилийн аюулгүй байдлыг үнэлэх арга зүйн чиг хандлагыг тодорхойлоход оршино.

Судалгаанд олон улсын онолын хандлага (реализм, транснационализм, постмодернизм), газар зүйн болон хил судлалын үзэл баримтлал, АНУ–Мексикийн хил, Европын холбооны гадаад хил зэрэг кейсүүдийн харьцуулсан шинжилгээг ашиглав.

Хэмжигдэхүүний түвшинд илрүүлсэн зөрчлийн тоо, төсвийн зардал зэрэг тоон үзүүлэлтээр бус, олон нийтийн аюулгүй байдлын мэдрэмж, хил хамгаалалтын арга хэмжээний ёс суртахуун, улс төрийн ашиг сонирхлын нөлөөг тусгасан “арга зүйн” хэмжигдэхүүнийг хамтатган харах шинэ хандлагыг дэвшүүлсэн нь энэхүү судалгааны гол онцлог болж байна.

Abstract: In the context of contemporary globalization, the intensified cross-border movement of goods, people, information, and illicit activities has positioned the concept of “border security” as a central issue in political and security studies. However, efforts to theoretically define border security and to formulate empirical indicators remain fragmented and internally inconsistent, constituting a major research challenge. The purpose of this article is to clarify the conceptual content of border security, examine the evolving nature of transboundary flows, analyze the characteristics of state-level border control policies, and outline methodological approaches for assessing border security.

The study employs comparative analysis based on major international theoretical perspectives (realism, transnationalism, postmodernism), geographical and border studies frameworks, as well as case studies such as the U.S.–Mexico border and the external borders of the European Union.

A key contribution of the research is the proposal of an innovative approach to measurement—one that incorporates not only quantitative indicators such as recorded violations and budgetary expenditures, but also “methodological” indicators reflecting public perceptions of safety, the ethical implications of border-

control measures, and the influence of political interests. This combined perspective offers a more comprehensive and nuanced understanding of modern border security.

Түлхүүр үг (Keywords): Улсын хил, аюулгүй байдал, шинэ хандлага, үзэл баримтлал, хилийн аюулгүй байдлын хэмжигдэхүүн.

State border, security, new approaches, conceptual frameworks, indicators of border security.

Удиртгал

Даяаршлын эрчимжилттэй хамт дайн, түрэмгийлэл, газар нутгийн маргаантай асуудал, хил дамнасан хууль бус цагаачлал, хар тамхины наймаа, терроризм, зохион байгуулалттай гэмт хэрэг, байгалийн гамшиг зэрэг аюул, заналхийлэл огцом өсөж, хилийн аюулгүй байдлыг улс орнуудын үндэсний аюулгүй байдлын бодлогын салшгүй хэсэг болгож байна. Хилийн хяналт, шалгалтыг чангатгах, зэвсэгт хүчин, техник технологийг их хэмжээгээр ашиглах бодлого өргөжин тэлж байгаа хэдий ч, бодит үр дүн нь зөрчил бууруулах бус, зарим тохиолдолд хууль бус урсгалыг шинэ хэлбэрт шилжүүлэх нөлөөтэй байгааг судалгаанууд харуулж байна. Хилийн аюулгүй байдлыг хэрхэн тодорхойлох, юуг хэмжиж байж “хил аюулгүй байна”, “хил аюултай байна” гэж үзэх вэ гэсэн асуудал онол, практикийн аль алинд нь бүрэн шийдэгдээгүй нь тулгамдсан асуудал болоод байгаа юм.

Хилийн аюулгүй байдлын асуудлыг анх “байгалийн хил”, “хориглолтын шугам” гэсэн ойлголтоор авч үзэж, нутгийн байгалийн саад тотгорыг хамгаалалтын үндсэн нөхцөл гэж үздэг байв. Дараа нь газар зүй, эдийн засаг, улс төр судлалын бүтээлүүдэд хил бол хөдөлгөөнийг зохицуулах, хууль ёсны урсгалыг дэмжихийн зэрэгцээ хууль бус урсгалаас хамгаалах “ашигтай зааг” байх ёстой гэсэн үзэл давамгайлах болсон. Олон улсын харилцааны реалист, транснационал, шинэ марксист, постмодернист чиглэлүүд хил, нутаг дэвсгэрийн үүргийг өөр өөрийн өнцгөөс тайлбарласан ч даяаршлын нөхцөлд хил зөвхөн цэргийн хамгаалалтын хэрэгсэл биш, харин мэдээлэл, капитал, хүмүүсийн урсгалыг “шүүх” зохицуулалтын төв болж хувирсныг нэгэн дуугаар хүлээн зөвшөөрч байна. Сүүлийн жилүүдэд “surveillance studies”, хил дамнасан аюулгүй байдлын тогтолцоо, зан үйлийн (body experience) шинжилгээ зэрэг чиглэлээр судалгаа өргөжсөн ч, хилийн аюулгүй байдлыг системтэй хэмжих онол-аргазүйн загвар хангалттай боловсроогүй байна.

Энэхүү судалгааны зорилго нь:

1.Хилийн аюулгүй байдлын агуулгыг орчин цагийн нөхцөлд дахин тодорхойлох;

2.Хил дамнасан урсгал, хилийн шалгалт, хяналтын бодлогын шинэ онцлог, зөрчлийг шинжлэх;

3.Хилийн аюулгүй байдлыг үнэлэхэд ашиглах боломжтой объектив ба арга зүйн (сэтгэл зүй, улс төрийн) хэмжигдэхүүнүүдийг ялган ангилж, тэдгээрийг уялдуулах арга зүйн чиглэлийг боловсруулахад оршино.

Судалгаанд чанарын шинжилгээний арга зүйг ашиглаж, онолын баримт бичиг, эрдэм шинжилгээний бүтээлүүдэд хийсэн контент шинжилгээ, АНУ–Мексикийн хил, Европын холбооны гадаад хил, ОХУ-ын туршлагыг

харьцуулсан кейс судалгаа, мөн хилийн аюулгүй байдлын үзэл баримтлал, бодлогын баримт бичгүүдийн харьцуулсан шинжилгээг хийв. Объектив хэмжигдэхүүний хувьд хил нэвтрэлтийн урсгал, илрүүлсэн зөрчлийн тоо, хамгаалалтын зардал, техникийн чадавх зэрэг тоон үзүүлэлтийг арга зүйн хэмжигдэхүүний хувьд олон нийтийн аюулгүй байдлын мэдрэмж, хил хамгаалалтын арга хэмжээний ёс суртахууны үнэлгээ, улс төрийн ашиг сонирхол, хил дээрх хүч хэрэглэсний нийгэм-сэтгэлзүйн үр дагаврыг онцлон авч үзсэн.

Судалгаанд дараах үндсэн таамаглалыг дэвшүүлэв:

Нэгдүгээрт. Хилийн шалгалтыг механик аргаар чангатгаж, техникийн хэрэгслийг нэмэгдүүлэх нь хилийн аюулгүй байдлын түвшнийг дээшлүүлэхгүй, тодорхой нэг түвшнээс цааш хөрөнгө оруулалтын өгөөж буурна.

Хоёрдугаарт. Хилийн аюулгүй байдлыг зөвхөн илрүүлсэн зөрчлийн тоо, төсвийн зарцуулалтаар хэмжих нь бодит нөхцөл байдлыг гуйвуулах бөгөөд олон нийтийн итгэл, хууль сахиулах байгууллагын ёс зүй, нийгмийн тогтворын үзүүлэлтүүдийг хамтатган авч үзэх шаардлагатай.

Гуравдугаарт. Хилийн бодлого хэт цэрэгжих нь богино хугацаанд “хатуу хяналт” мэт харагдавч урт хугацаанд нийгмийн хагарал, радикализаци (*дайсагнагч, хүч хэрэглэх үйлдэл рүү шилжих*), хууль бус урсгалыг далд хэлбэрт шилжүүлэх сөрөг үр дагавартай.

Судалгааны шинэлэг тал нь судалгааны хүрэх үр дүнд хилийн аюулгүй байдлыг “нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хилийн дэглэмийн ноцтой зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, хил дамнасан аюулыг нийгэм, эдийн засаг, улс төрийн хямралд хүргэхээс өмнө удирдах чадвар” хэмээн тодорхойлох онолын загвар дэвшүүлнэ. Объектив болон арга зүйн хэмжигдэхүүнүүдийг салангид биш, харилцан нөлөөлөлтэй цогц систем гэж үзэх, өөрөөр хэлбэл “хилийн аюулгүй байдлыг зөвхөн тоон статистикаар бус, хүмүүсийн аюулгүй байдлын мэдрэмж, төрийн бодлогын ёс суртахууны чанараар дамжуулан үнэлэх” шинэ хандлагыг санал болгож байгаа юм. Энэ нь хилийн бодлого боловсруулахдаа зөвхөн хяналт, хориглолтыг нэмэгдүүлэхээс гадна нийгэм-эдийн засгийн арга хэмжээ, эрсдэлийн удирдлага, хүний эрх, олон нийтийн итгэлийг хосолсон цогц арга зүйг төлөвшүүлэхэд чиглэсэн онол-практикийн ач холбогдолтой юм.

Үндсэн хэсэг

Нэг.Хилийн аюулгүй байдлын тухай ойлголт, агуулга:

“Хилийн аюулгүй байдал” (ХАБ) гэдэг бол эрдэмтэн судлаачид, шийдвэр гаргах түвшний хүмүүсийн өргөн хэрэглэдэг орчин цагийн чухал ойлголт болсон.

Хилийн аюулгүй байдлыг судлахаас өмнө аюулгүй байдал гэж юу болох, хаанаас эх сурвалжтай, аюул заналтайг тогтоох нь зүйтэй гэж үзэж байна.

Хувь хүн, нийгэм, төрийн амин чухал ашиг сонирхол хамгаалагдсан байдал буюу бодит аюул заналхийлэл байхгүй нөхцөлийг аюулгүй байдал гэнэ.

(Доржням .Ц, Цогтоо.М, Эрдэнэ .С, 2016, хуудсд. 20-21)

Мөн аюулгүй байдлын талаар бусад эх сурвалжид дараах байдлаар томьёолсон.

Үүнд:

-“Аюулгүй, зовлон гачаалгүй байх” Платон МЭӨ IY;

-"Бодит аюулгүйн үр дүнд бий болох амар тайван нөхцөл байдал" (бие мах бодийн болон сэтгэл санааны аль аль нь) И.Зоненфельс;

-“Улс эх орон, нийгэм, хувь хүний амин чухал эрх ашгийг гадаад, дотоодын бодит аюулаа хэрхэн хамгаалагдсаныг хэлнэ” ОХУ-ын ХАБА-ны хур/ген А.Шербаков;

-"Аюулгүй бүрэн бүтэн байх, итгэл найдвартай байх" В.Даль;

-"Аймаар юмгүй айж, болгоомжлох шаардлагагүй байх" гэж Я.Цэвэл нар тус тус тодорхойлсон.

Монгол Улсын хилийн аюулгүй байдал нь /цаашид "хилийн аюулгүй байдал" гэх/ Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын салшгүй хэсэг мөн.

Хилийн аюулгүй байдал гэж улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах, гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсаныг хэлнэ. (Хилийн тухай хууль, 2016)

Бүс нутгийн мөргөлдөөн, хууль бус цагаачлагчид, олон улсын террористууд, үндэстэн дамнасан гэмт хэргийн бүлэглэлүүд зэрэг хил дамнасан асуудлууд хурцадсантай холбогдоод энэ нэр томьёо ихээхэн анхаарал татах болсон юм. Жишээлбэл, хил дамнасан бараа таваар, цагаачид, ажил үйлчилгээний хууль ёсны болон хууль бус урсгал эрчимжиж байгаатай зэрэгцээд, улс хоорондын хилийг шинээр төвхнүүлэх хэрэгцээ шаардлага “хилийн аюулгүй байдал” гэдэг ойлголтыг ашиглахаас аргагүй байдалд хүргэж байгаа юм.

Хилийн харилцааны эрчимтэй өсөлт, уламжлалт бус аюулд төр, засаг тэр дор нь тэдгээрт тохирсон сөрөн тэсвэрлэх арга хэмжээ авах боломжийг алдагдуулж байна.

Орчин цагийн ном, бүтээлүүдэд бичигдсэн хилийн аюулгүй байдлын хүрээний эмпирик (*бодит өгөгдөл, туршилт*) боловсруулалтууд онолын шинжилгээний баталгаа багатай байна.

Хилийн аюулгүй байдал гэдэг юу юм бэ, зорилго юм уу, эсвэл өдөөлтийн эсрэг хариу арга хэмжээ авснаар хилийн аюулгүй байдал хангагдаж байдаг үйл явц юм уу гээд л, нэр томьёог тодорхойлохоос авхуулаад хүндрэл учирдаг.

ОХУ-ын Аюулгүй байдлын албаны Хилийн шинжээчид хилийн аюулгүй байдлыг хилийн харилцааны төр, нийгэм, иргэдэд аюул учрахааргүй байдал (Гришин М.Л., Губченко В.Н., Дмитриев В.А, 2001, хууд. 8) гэж үзэж байгаа юм. Тийм байдлын нарийвчилсан хэмжигдэхүүнийг гаргаж хэмжих боломжгүй болохоор энэ хувилбарын шинжлэх ухааны үнэ цэнэ алдагдаад байгаа юм.

Хилийн аюулгүй байдлын агуулга нь юун түрүүнд нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, аюулгүй байдлын хөндсөн

асуудлын цараагаараа тодорхойлогдоно.

Хилийн зөрчил нь хил нэвтрэх, ачаа тээвэр, ургамал, амьтдыг оруулах, гаргах журам тэрчлэн хилийн болон хил орчмын дэглэм зөрчигдсөнөөс болж гардаг. Ийм зөрчлүүд олноороо гарах нь улс төр, нийгэм, эдийн засгийн ноцтой үр дагавартай байдаг.

Энэ нь цэргийн түрэмгийлэл, хууль бус цагаачлал, контрабандын төрлүүдээр илэрч болно. Хилийн бүс нутаг дахь мөргөлдөөн, тогтворгүй байдал, салан тусгаарлах оролдлого ирредентизм (Irredentism – Editor's Definition, n.d.) *(ирредентизм гэж ард түмэн, үндэстэн, угсаатнуудыг нэгэн улсад нэгтгэх төрийн бодлогыг хэлдэг)* зэрэг нийгмийн зарим хурц асуудлуудыг хилийн аюулгүй байдлын хүрээнд авч үзэх нь зүйтэй.

Хилийн дэглэм сахиулах үед хилээр орж, гарахад үүсэх хүндрэлүүд, үүнтэй холбоотой дарамт үзүүлэх, авлига авах зэргийг энэ чиглэлийн асуудлуудад хамааруулах үндэстэй юм. Хил, хилийн бүсийн дэглэмийн биелэлттэй шууд холбогдолгүй, хурцадмал биш зарим асуудлуудыг аюулгүй байдлын хүрээллийн гадна гаргаж үзэх нь зүйд нийцнэ. Иймэрхүү асуудлууд нарийндаа, хилийн аюулгүй байдлаар хэлэлцэгдэх асуудлуудын тоог нэмэгдүүлж, онцлогийг бүдгэрүүлэхээс цаашгүй.

Хилийн аюулгүй байдлыг тухайн орны эрх баригчид, олон нийтийн санаа бодолд нийцтэл, нутаг дэвсгэрийнхээ бүрэн бүтэн байдлыг хадгалж, хилийн дэглэмийн ноцтой зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлснээр, хил, хязгаар нь хил дамнасан аюул заналаас найдвартай хамгаалагдсан байдал гэж тодорхойлж болох юм.

Хоёр.Хилийн аюулгүй байдалд гарч буй шинэ хандлагууд:

"Байгалийн хилийн онол"-оор хил бол гаднын халдлагаас хамгаалах хориглолтын зааг гэж үзэж байлаа. Асуудлыг энэ талаас нь авч үзэж, хориглолтын шугам, өндөр уулс, их элст манхан, уст гол, төрөл бүрийн угсаатны бүлгүүд суурьшсан заагуудаар дайран өнгөрөх ёстой гэж үзэж байв (Колосов В.А., Мироненко Н.С., 2001, хууд. 302).

Газар зүйчид хилтэй холбоотой аюулгүй байдлын асуудлыг зарчмын хувьд, юун түрүүнд "хаалт, саад" болох талаас нь харж, нууц далдуур хууль бусаар хил дамнасан хөдөлгөөн үйлдэгдэхээс сэргийлж, зохистой хөдөлгөөнийг зохицуулсан ашигтай зааг байх талаас нь авч үзэж байв. Европт интеграцчилагдах үйл явц газар авахын хэрээр хилийн "нигилист" *(нийтийн үнэт зүйлсийг үгүйсгэгчид)* үзэл дэлгэрч, тэр үзлийг дэлгэрүүлэгчид хаалт, саад барих нь хилийн харилцаанд бэрхшээл учруулж, хязгаарын районуудын хөгжилд дараас болж байна гэж үзэх болов. Зарим эдийн засагчид хилээс учирч байгаа эдийн засгийн хохирлыг тогтоохын тулд, хилийн шалгалт явагдах хугацаанд, орж ирж буй ачаа тээврийн урсгал

туулж өнгөрүүлэх зай буюу “завсрын эквивалент”-ыг тооцоолох гэж үзсэн байна. Саяхан болтол, олон улсын харилцааны онол (ОУХО), аюулгүй байдлын чиглэлээр хийгдсэн судалгаа шинжилгээнүүдэд, улс хоорондын хилийн асуудалд бага анхаардаг байсан юм.

Энэ нь реализм, транснационализм, шинэ марксизм гээд позитивизмын үндсэн чиглэлүүдийн хувьд бүгд өөр өөрийн онцлогтой. Хилийг янз бүрийн сургаалууд дээр хил залгаа улсууд, тэдний хоорондын харилцааг тодорхойлсон тусгал гэж үзэж байсан юм (R., 1984, хууд. 290).

Хил одоо орчин цагийн зэвсэг, сэтгэл санааны урсгал, олон улсын харилцааны олон хэлбэрийг огт хязгаарлаж чадахаа байсан (Herz, 1957) болохоор өөрийн хориглон хамгаалалтын ач холбогдлоо алдаж байгаа юм.

Хил дамнасан хөдөлгөөний нягтрал нэмэгдэж, хурд ихэссэн нь эдийн засгийн хөгжлийн хэмжүүр болж буурснаар, эдийн засгийн болон бусад салбарт ихээхэн хэмжээний хохирол учирч, хил нэвтрэх тээврийн хэрэгслийн хөдөлгөөн гацаж, хил орчмын нөхцөл байдал хурцдах болов. 1990-ээд онд АНУ-ын хил, гаалийн албаны төлөөлөгчид, ачааны автомашин болгонд хар тамхины нарийвчилсан шалгалт хийвэл хоёр долоо хоногийн дотор Мексикээс Америк-Мексикийн хил хүртэл 2000 км үргэлжилсэн дараалал үүсэх болно гэж мэдэгдэж (Andreas, 1999) байлаа. Хил дамнасан гэмт хэргийн бүлэглэлүүд ч даяарчлалын үр шимийг нэн эрчимтэй ашиглаж эхэлсэн байна. Гэмт хэргийн бүлэглэлүүдийн үйл ажиллагаа, тэдгээрийг сөрөн зогсох олон тооны хүнд суртлын дүрэм журамд баглагдсан, харилцан ажиллагааг нь сайтар зохицуулж өгөөгүй, нэг талын болоод хэд хэдэн талын хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагаанаас үнэндээ үр дүнгээр илүү байлаа.

Хилийн үүрэг ролийн тухай асуудалд улс төрийн газар зүйчид, постмодернист олон улс судлаачид анхаарлаа хандуулж эхэлсэн бөгөөд тэд даяаршлын нөхцөлд хил, дэглэм сахиулж буй улсын эрх зүйн чадамж, нутаг дэвсгэрийн зах хязгаарын тэмдэглэгээ гэдэг утгаа алдаж байна гэсэн санал дэвшүүлжээ. Иймэрхүү шинж тэмдгийг гадаадын хэвлэлүүдэд, монгол хэлэнд зохиц муутай сонсогдох “deterritorisation” (*нутаггүйжүүлэлт*), “debordernisation” *(хилгүйжүүлэлт)* хэмээн томьёолох болсон юм.

Аядуу постмодернистууд хилийн дэглэмийг чангатгасны үр дүнд, жишээлбэл, шинэ газруудаар хил тогтоосноор хилийн үүрэг роль багасахын хэрээр, тэдний үүрэг роль “reborderisation” *(дахин хилжүүлэлт)* дахин ихсэх үзэгдэл үүсэж гарч ирнэ гэж үзэж (Albert, 1998) байлаа. Европын холбоонд хийгдсэн хэт төвлөрөл, интеграцчилагдах үйл явц болон хилийн дэглэмийг сулруулсан явдлыг постмодернист үзэл баримтлалын сул тал гэж үзэж болох юм. Европын холбооны хилийн гадна, үндэсний улс хийгээд

түүний хилийн үүрэг ролийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн сөрөг үйл явц хүчээ авав (Paasi, 1998).

XXI зуунд хилийн аюулгүй байдлыг хангах асуудал өөрчлөгдөж байна. Хилийн аюулгүй байдлыг хангахад хилийн мөргөлдөөн гардаг орнуудын хувьд их байгаа болохоос биш, хилийн асуудлаа шийдчихсэн улсуудын хувьд төдийлөн их биш болжээ. Бүр Үндэсний аюулгүй байдалд аюул занал учруулах байсан ч хил мэдээллийн урсгал (интернэт, сансрын холбоо)-ыг хязгаарлагч болж чадахаа больжээ. Хил дамнасан гэмт хэрэг, хууль бус цагаачлал, хилийн аюулгүй байдлын асуудалд чухал байр суурь эзлэх боллоо. Хилийн хяналтын боловсронгуй техник хэрэгсэл ашиглаад ч хууль зөрчигчдийн арга, заль мэх сайжирснаар төдийгүй, хил нэвтэрч байгаа урсгал эрчимжиж байгаагаар хилийн зөрчил буурч, хамгаалалтын чадавх сайжрахгүй байна.

Хил дээр бөөгнөрөл үүсгэхгүйн тулд хилчид болоод гаальчид шалгавал зохих ачаа бараа, зорчигчдын нэгээхэн хэсгийг шалгаад, ихээхэн хэсэг (барууны орнуудад 90 гаруй хувь)-ийг орхигдуулж байна.

Нэг талаас хүмүүс болоод ачаа тээвэрт хугацаа зарсан нарийвчилсан үзлэг явуулж байж хар тамхи, зэвсэг, хүний наймааны хохирогчдыг илрүүлэх боломж бүрдэж байхад, нөгөө талаас иймэрхүү арга хэмжээ нь жуулчид, улс хоорондын худалдаанаас орох орлогыг багасгаж, хямд ажлын хүч ашиглах боломжийг бууруулдаг. Улсын хилээр нэвтэрч буй хүмүүсийн дотор онц аюултай гэмт хэрэгтнүүдийн тоо нэг хувь хүрдэггүй, захиргааны зөрчил тоотойхон гардаг болохоор асуудлын ёс суртахууны тал онцгой үүрэгтэй байдаг.

Хэрвээ хилийн дэглэмийг эрс чангатгах аваас ямар ч гэм зэмгүй аялагчид л энэ арга хэмжээний хохирогч болдог. Хил, хуулиа сахидаг хүмүүсийн хувьд хил тунгалаг, зөрчдөг хүмүүсийн тухайд чанга хатуу байх ёстой ч хэрэг дээрээ болохоор харин ч эсрэгээрээ, хуулиа сахидаг хүмүүс нь хохироод, зөрчдөг нь болохоор хил, гаалийн шалгалтын өө сэвийг ашиглаад ороод гараад байдаг.

Орчин цагийн хил хамгаалалтад ашиглагддаг нисэгчгүй нисэх аппарат, сансраас хянах систем, хэт улаан туяаны болоод дулаанаар мэдрэгчид, шалгах төхөөрөмжүүд, газоанализаторууд гээд техник хэрэгслүүдийн сонголт тогтмол нэмэгдэж байна. Эдгээр техник хэрэгслүүд, терроризмын заналхийллийн өнөөгийн нөхцөлд ч хилийн шалган нэвтрүүлэх чадварыг өндөрт байлгаж, хяналт шалгалтыг үр дүнтэй явуулах нөхцөл боломжоор хангасаар байгаа юм.

Европын холбооны улсууд, АНУ 2001 оны террорист халдлагаас хойш, хөрш орнуудтайгаа хилийн талаар “ухаалаг хил” (*smart border*)-ийн бодлого хэрэгжүүлж эхэлжээ. Гэхдээ дан ганц техник хэрэгсэл ашиглаад бүх асуудлыг бүрэн шийдвэрлэх боломжгүй. Америк-Мексикийн хил л гэхэд 1970-аад

оноос техник хэрэгслүүдээр дээд зэргээр тоноглогдсон атлаа, гэмт хэргийн гаралтаараа дэлхийд тэргүүлсэн хэвээрээ л байна. Хил дамнасан хөдөлгөөнийг гацаачихгүйн тулд, урьдын адил, ерөнхийлөн үзэх, дурын сонголт хийх, сэжигтэй мэдээллийг магадлах маягаар энэ том урсгалын багахан хэсэг шалгагдаж байна. Тэгэхэд контрабандистууд хууль бус ачаа бараагаа нуух хамгийн нарийн арга хэрэглэж байгаа нь, орчин цагийн техник хэрэгслээр хангагдсан хууль сахиулах байгууллагуудыг үүргээ биелүүлэхэд хүндрэл учруулсаар байгаа юм.

Онолын хувьд эдгээрээс илүү үр бүтээлтэй, илүү хүчин чадалтай, зарчмын хувьд цоо шинэ техник хэрэгслүүд гарч байж байдал сайжрах ч, энэ нь ойрдоо хэрэгжих боломж бага.

2.1. Хилийн хатуу хяналтын үр ашиггүй байдал:

Хил дамнасан урсгал эрчимжиж буй өнөөгийн нөхцөлд, хилийн шалгалтыг чангатгаснаар хилийн шалгалт явуулдаг төрийн байгууллагууд, хил зөрчигчдийн хоорондхууль бус өрсөлдөөн үүсэв. Дамын наймаачид, хар тамхи худалдаалагчид, хууль бусаар цагаачлах үйл ажиллагаа идэвхжихийн хэрээр хилийн болоод гаалийн хяналтаа чангатгаад эхлэхээр тийм өрсөлдөөн эхэлдэг байна. Эдгээр арга хэмжээнүүд хил зөрчигчдийн заримыг нь үргээж чадах ч, нөгөө хэсэг нь шинэ нөхцөл байдалд дасан зохицож чаддаг аж.

Хууль зөрчигчдийн хувьд хар тамхи (1000 хувийн ашигтай), контрабандын бусад эд зүйлсийн худалдаа хууль бус ажиллах хүч нийлүүлснээс олж байгаа ашиг, хилийн хяналтыг давахад гарах эрсдэл, зарах зардлаас их байгаад учир нь байгаа юм. Контрабанд үйлдэгчид хилчдийн нэгэн адил гар утас, тээврийн болон шөнийн харааны хэрэгсэл, интернэтэд байрлуулсан, цаг хугацаа, бодит байдлыг үзүүлсэн видео зураглал ашигладаг. Тэд нар хилийн дэглэмийн сул талыг илрүүлэхээр тандалт явуулахдаа орон нутгийн оршин суугчдад ихээхэн найдвар тавьж, хамтрагчаа болгодог.

Контрабанд үйлдэгчид болоод хууль бусаар цагаачлагчдыг шинэ техник хэрэгслүүд ч, гурван метрийн өндөртэй, нарийн бүтээцтэй хашаа ч, аль аль нь адилхан зогсоож чаддаггүйг Америк-Мексикийн хил хамгаалалтын туршлага бэлхнээ харуулж байна (Donaldson, 2005).

Төв сууринаас зайдуу газар хууль бусаар цагаачлагчдын зарим хэсэг нь чиглэлээ өөрчилж, албан ёсны суваг ашиглах оролдлого хийж эхлэв. Хил зөрчигчид хийгээд улсын хил хамгаалах үүрэг хүлээсэн субъектүүдийн хоорондын сөргөлдөөн хачирхалтай нөхцөл байдал үүсгээд байгааг Америкийн улс төр судлаач П.Андреас олж харжээ. Хилийн шалгалт хэдий чангаравч, хүссэн үр дүнд хүрдэггүй болохоор энэ нь “чанд шалгаж буй сүр үзүүлсэн улс төрийн арга хэмжээ болж хувираад байгаа юм”. “Төрийн дорой байдал урьд урьдынхаас улам тодорхой

харагдах боллоо” гэжээ (Andreas, Sovereigns and Smugglers: Enforcing the U.S.–Mexico Border in the Age of Globalization, 1999, хуудсд. 29, 31, 55). 1970-аад оноос авхуулаад одоо хүртэл АНУ-ын хилийн аюулгүй байдалдаа гаргасан зардал хэдэн арав дахин өсөв. Гэхдээ бүртгэгдсэн зөрчлийн тоон үзүүлэлт, хил бараг хамгаалалтгүй байсан 1950-иад оны түвшин (жилдээ нэг сая орчим хил зөрчигчид баригдаж байна)-д л байна. Хилийн шалгалтыг чангатгахад оруулсан хөрөнгө оруулалтын үр ашиг, гарч байгаа үр дүн хоёр шууд хамааралтай байж чадахгүй байна.

Ямар боловч хил хамгаалах байгууллагуудын хувьд ашигтай нөхцөл бүрдэж байгаа юм. Энэ нь нэг талаас хууль бус зүйл хил давуулах оролдлого идэвхжихийн хэрээр илэрсэн зөрчлийн тоо нэмэгдэж хилчид, гаальчид үр бүтээлтэй ажиллалаа гэж дүгнэгддэг. Нөгөө талаас хилийн албаныханд илүү эрх эдэлж, нэмэгдэл санхүүжилт авах боломж нэмэгдэнэ.

Хил хамгаалах алба, хил дамнасан гэмт хэргийн бүлэглэлүүд бие биетэйгээ харгалдахын зэрэгцээ нарийн төвөгтэй хоёрдмол байдалтай харилцан хамааралд орж байгаа юм. Хил хаалттай байснаар хууль зөрчигчид ашиг олж, хилийн зөрчил ихэссэнээр төрийн албаны бүтэц данхайж, нэмэгдэл санхүүжилт нэхэгдэж байх аж (Andreas, Sovereigns and Smugglers: Enforcing the U.S.–Mexico Border in the Age of Globalization, 1999, хуудсд. 64–65). Энэхүү холбоо эргүүлэг маягаар шатлан өргөжих атлаа хууль сахиулах байгууллагын хувьд хэрэгтэй өөрчлөлт гарахгүй байна.

Зарим хил (жишээ нь: Америк-Мексикийн)-дээр гарч буй армийн салбарууд, стратеги, тактик, зэвсэглэлийг хил хамгаалалтад ашиглан хилийг цэрэгжүүлж байгаа нь ноцтой асуудал үүсгэж байна (Dunn). Тэд жижиг зөрчил гаргасан хил зөрчигчдийн аахар шаахар асуудлыг шийдвэрлэхдээ хилчид болоод цагдаагийн албан хаагчдаас олон тоогоор зэвсэг хэрэглэж нөхөгдөшгүй гарз хохирол учруулах нь энүүхэнд. Чухам ийм учраас Европын холбооны стандарт ёсоор Европын холбооны гишүүн болон гишүүнээр элсэхээр бэлтгэж байгаа улсууд хил хамгаалах албадаа цэргийнхнээр биш цагдаа нараар бүрдүүлсэн байх юм. Энэ болоод бусад шалгуур үзүүлэлтүүдийг харгалзсан үр бүтээлтэй хилийн бодлого боловсруулах асуудал саяхан гарсан хэд хэдэн судалгааны ажлуудад (A. H. , 2004) тусгалаа олжээ.

Терроризмын аюул ихэссэнтэй холбогдон 2000-аад оны эхний жилүүдэд улсын хилээ бэхжүүлэх нь терроризмын эсрэг авсан үндсэн арга хэмжээнүүдийн нэг болсон юм. АНУ, ОХУ, Европын холбооны улсууд хилээ бэхжүүлж эхлэв. Терроризмын аюул энд ямар оролцоотой нь тодорхой бус, хилээ бэхжүүлэхийн тулд л бэхжүүлээд байгаа юм. Хил нэвтрэн орж ирж байгаа террористуудын тоо, хил даван ирж байгаа хүмүүсийн тоотой харьцуулахад маш өчүүхэн. Террорист ажиллагааг удирдагчид хийгээд гардан гүйцэтгэгчид хил

давж очдоггүй, террорист үйлдэл хийхээр сонгож авсан улсынхаа нутаг дэвсгэрт оршин сууж үйл ажиллагаагаа явуулдаг.

Тэгвэл терроризмын эсрэг сөрөг тусгай ажиллагааны нэгэн хэлбэр болгож, хилийн шалгалтыг чангатгах нь төдий л үр дүнтэй арга хэмжээ болж чаддаггүй нь эндээс харагдаж байна.

Төрийн хилийн бодлогод терроризмын аюул занал хэрхэн нөлөөлөх талаар хийгдсэн суурь судалгаа бараг байдаггүй нь (Ackleson, 2003) үүнтэй холбоотой байж мэдэх юм.

2.2. Хилийн аюулгүй байдлын объектив ба субьектив хэмжигдэхүүн:

Бидний авч үзэж буй асуудал объектив хэмжигдэхүүний зэрэгцээ, аргазүйн хэмжигдэхүүнтэй юм. Аргазүйн энэхүү хэмжигдэхүүн мэдээллийн ач холбогдлыг нэмэгдүүлэх, тэдгээрийн муу нөлөөллөөс олон нийтийн оюун санааг хамгаалах үйлдлийн аль алиныг нь давхар илэрхийлнэ. Ийм хэмжигдэхүүн янз бүрийн байдлаар илэрнэ. Үүнд:

-Хил болон хилийн аюулгүй байдлыг “Гадаад орчны аюул” хортой нөлөөллөөс хамгаалах хаалт саад (*ихэнхдээ олныг хамарсан зохисгүй*) гэдэг ойлголт;

-Шийдвэр гаргах явцдаа олон нийтийн санаа бодлыг засаг захиргааны нэгжүүдээр дэмжүүлэх;

-Төрөөс улс орныхоо хил хязгаарыг найдвартай хамгаалж буй төлөв байдал;

-Хил зөрчигчийн үйлдлийг илрүүлэх хүч хэрэгслийн нөлөөлөл;

-Хилийн аюулгүй байдлын талаар хэвшмэл буруу ойлголт түгэх;

-Улсын хил хамгаалах явцдаа онцгой аюултай объект болоод ноцтой асуудлуудыг бусдаас нь ялган таних зэрэг болно.

Энэ асуудлын сэтгэл судлалын хэмжигдэхүүнийг улс төр судлаачид болон практик улс төрчид ихэнхдээ дутуу үнэлсээр ирсэн юм. Бүр 1960-аад оны сүүлчээр Норвегийн антропологич Ф.Барт болон түүний залгамжлагчид олон нийтийн санаа бодолд ойр дөт үзэгдэл болох, “бат бэх” хилийн үүрэг, ролийн талаар асуудал дэвшүүлсэн юм. Энэхүү үзэгдлийн онцлог нь гадаад орчныг ихээхэн түрэмгий (Barth, 1969) гэж үзээд, “Гаднынхнаас” хилээрээ тусгаарлаж аваад аюулгүй амар жимэр амьдрах эрмэлзэл юм үзсэн.

Энэ санааг газар зүйн лимологид суулгаж, Финляндын газарзүйч А.Пааси (A. P. , 1995, хууд. 43) болон бусад судлаачид өөрсдийн бүтээлдээ үргэлжлүүлэн хөгжүүлсэн (Van Houtum, хуудсд. 62–65) юм. Францын улс төрч Д.Д.Бигогийн үзэж байгаагаар орчин үед хилийн үүрэг ролийг бууруулах нь “өр төлөөс”-т унагах буюу өөрөөр хэлбэл, янз бүрийн угсаатан арьстан бусад шинжээрээ ялгаатай бүлгүүдийн хооронд улам хатуу чанд үл үзэгдэх хаалт, хананууды босгох юм.

Энэ нь угсаатан хоорондын харилцаанд төвөг учруулна (Bigo, 1997). Аюул, заналт гадаад орчноос тусгаарлаж, харьцангуй ч гэсэн аюулгүй байдалд байх гэсэн сэтгэл зүйн хэрэгцээ шаардлагад тулгуурладаг байна.

2.3.Шинэ судалгааны арга, ажиглан шинжилгээ

Хууль бус цагаачлал, хар тамхины наймаатай тэмцэхэд онцгой арга хэмжээ аваад хүлээсэн үр дүндээ хүрдэггүйг ОХУ-ын болон олон улсын практик харуулж байна. Хар тамхины наймаатай тэмцэхэд хилийг "шүүлтүүр" болгон ашигласнаар гарах үр дүн тун тааруухан (Голунов С. В, 2007).

Хилийн хөдөлгөөнийг хянахад ашиглах журмыг боловсруулахад субьектив хүчин зүйлүүдийн үүрэг роль их байгаагаас хилийн болоод гаалийн албад зөнгөөрөө хүмүүсийг биеэ авч яваа байдал, гадаад шинж төрхөөр нь сэжиг бүхий хүмүүсийг илрүүлэх гэж оролдоцгоож байна. Дамын наймаа эрхлэгчид, хил зөрчигчид хэн хүнгүй, ажиг сэжиггүй аятайхан сэтгэгдэл төрүүлэхийг хичээдэг. Тэд хар тамхи болон хориглосон бусад бараа таваар зөөвөрлөхдөө хүүхдүүд, тахир дутуу хүмүүс, лам хувраг гээд санаанд оромгүй "анхаарал татахааргүй" хүмүүсийг ч ашигладаг.

Сүүлийн жилүүдэд "Ажиглан судлахуй" (*Surveillance studies*) гэдэг судалгааны шинэ салбар хөгжиж байна. Энэ салбар тусгай мэдээллийг цуглуулж, түүндээ дүн шинжилгээ хийнэ (Network, 2006).

Өргөн утгаар нь авч үзэх юм бол, энэ чиглэлийн хүрээнд "нутаг дэвсгэрийн гадна" түүгээр ч үл барам "хил дамнасан аюулгүй байдлын тогтолцоо буй болгох" асуудал судлагдаж байгаа юм. Энэхүү тогтолцоо хил дамнасан урсгал явагддаг бүх чиглэлүүдэд хяналт тогтоож, орж гарч байгаа жуулчид болоод цагаачлагчдын талаар бололцоотой бүх мэдээллийг цуглуулж, нэгдсэн дүгнэлт гаргахад үйл ажиллагаагаа чиглүүлэх юм.

Үр дүн сайтай байж мэдэх өөр нэг чиглэл бол хилийн аюулгүй байдлыг хүн судлалын талаас шинжлэх явдал бөгөөд, энэ нь "хувийн зан байдал" (*body experience*)-ын шинжилгээ юм. Энэхүү судалгааны төвд нэг улсаас нөгөөд орох хүмүүсийн биеэ авч яваа байдлын алгоритмыг загварчилж, аюултай байж мэдэх хүмүүсийн эерэг, сөрөг арга хэмжээний хувилбар боловсруулж бэлтгэдэг.

Даяаршин буй өнөөгийн нөхцөлд хилийн аюулгүй байдлын агуулга нь хил дамнасан гэмт хэрэг, хууль бус цагаачлал, терроризм гээд аюулгүй байдлын амин чухал "амаргүй" асуудлуудаар өргөжин тэлж байна. Улсын хилийг хамгаалах нь чухал ч гэлээ хил хамгаалж буй энэ тогтолцоо маань хууль бус урсгалын өчүүхэн жаахан хэсгийг л илрүүлж чадаж байгаа юм.

Судлаачид болоод практик ажилтнууд хилийн аюулгүй байдлыг хангахад хүч хэрэглэсний сөрөг үр дагавар, түүнээс үүдэн гарах дөжрөл, нийгмийн тогтворгүй байдал үүсэх холын хор хохирлыг сайтар бодолцох нь зүйтэй. Эндээс үзвэл хилийг зөрчилгүй байлгах нийгэм, эдийн засгийн шинжтэй арга хэмжээг давхар боловсруулж хэрэгжүүлснээр, хилийн урсгалыг зохицуулах хандлагаа тодорхойлох нь чухал юм.

Олон нийтийн оролцоо**:** Хил орчмын оршин суугчдыг хууль бус үйлдлээс сэрэмжлүүлж, хууль бус үйл ажиллагааны талаарх мэдээллийг цаг тухайд нь илгээх хамтын хяналт бий болгоно. Жишээ нь Европын холбооны “Community Policing” хөтөлбөрт орон нутгийн иргэдийг оролцуулж хил орчмын хууль бус үйл ажиллагааг мэдээлдэг.

Орон нутгийн хөгжлийг дэмжих**:** Хил орчмын ажилгүйдэл, ядуурлыг бууруулахын тулд жижиг бизнес, ажлын байр бий болгож, иргэд хууль бус үйлдэлд орох шаардлагыг багасгана.

Эдийн засгийн дэмжлэг, албан ёсны сувгийг бий болгох**:** Хил дамнасан худалдааг хууль ёсны сувгаар оруулах, татвар болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх нь дамын худалдааг хууль ёсны зам руу чиглүүлэх зэрэг арга хэмжээнүүд авах боломжтой.

ДҮГНЭЛТ

Орчин цагийн олон улсын хилийн аюулгүй байдал нь уламжлалт ойлголтоос эрс өөрчлөгдөж, олон талт, нийлмэл шинжтэй үзэгдэл болон хувирч байна. Даяаршлын үйл явц, хил дамнасан хөдөлгөөний эрчимжилт, хар тамхи, хүний наймаа, хууль бус цагаачлал, террорист сүлжээ зэрэг заналхийлэл нэмэгдэхийн хэрээр улс орнуудын хилийн хамгаалалт “хориглолтын зааг” бус, урсгалыг удирдах, эрсдэлийг бууруулах тогтолцоо болон өргөжиж байна.

Судалгаанаас харахад хилийн хяналт шалгалтыг механик аргаар нэмэгдүүлэх, техникийн хүчин чадлыг дангаар нь сайжруулах нь бодит үр дүн авчрахгүй байгаа бөгөөд АНУ–Мексикийн, Европын холбооны хилийн туршлагаас үзэхэд зардал өсөхийн хэрээр зөрчлийн далд хэлбэр, зохион байгуулалт улам боловсронгуй болж, хууль бус урсгал багасах бус шинэ зам, шинэ арга технологи бий болох хандлагатай байна.

Мөн хилийн аюулгүй байдлыг зөвхөн объектив үзүүлэлтээр (илрүүлсэн зөрчил, техник хэрэгсэл, төсөв) хэмжих нь хангалтгүй бөгөөд олон нийтийн итгэл, сэтгэл зүйн аюулгүй байдлын мэдрэмж, хил дээрх хүч хэрэглэсний нийгэм-сэтгэл зүйн үр дагавар зэрэг арга зүйн (subjektiv) хэмжигдэхүүнийг тусгах шинэ хандлага шаардлагатай байна.

Хэт цэрэгжсэн, хэт хаалттай хил нь богино хугацаанд хяналт сайжруулсан мэт боловч урт хугацаанд нийгмийн зөрчил, үл итгэлцэл, радикализаци зэрэг сөрөг нөхцөл бий болгох эрсдэлтэй.

Иймд хилийн аюулгүй байдлыг хангах орчин үеийн бодлого нь эрсдэлд тулгуурласан, хүний эрхийг хүндэтгэсэн, урьдчилан сэргийлэх чадвартай, ухаалаг хяналтын системийг бий болгон төлөвших хандлагатай гэж дүгнэж байна.

САНАЛ

1.Хилийн аюулгүй байдлыг “зөрчилгүй байдал” гэх хуучин ойлголтоор бус, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хилийн дэглэмийн зөрчлийг бууруулах, хил нэвтрэх хууль ёсны урсгалын саадгүй байдлыг хангах, хилийн

орон зайн нийгмийн тогтвортой байдал зэрэг нийлмэл шалгуураар тодорхойлох.

2.Объектив (зөрчлийн тоон үзүүлэлтийг тооцохоос гадна)– субьектив (олон нийтийн итгэл, хил нэвтрүүлэх чадвар, хүч хэрэглээний үр дагавар, аюулгүй байдлын сэтгэл зүйн хүчин зүйл**)** зэрэг хэмжигдэхүүн хосолсон үнэлгээний систем нэвтрүүлэх.

3.Ажиглан судлахуй, зан үйлийн алгоритм, профайлын ялгаатай болон давуу, сул талуудыг судлан хэрэгжүүлэх зэрэг болно.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

A., H. (2004). *Border Security in the Balkans: Europe's Gatekeepers.* Oxford University Press.

A., P. (1995). *Constructing Territories, Boundaries and Regional Identities.* Edward Elgar Publishing.

Ackleson, J. (2003). Directions in border security research. *The Social Science Journal, 40*(4), 579–580.

Albert, M. (1998). On Boundaries, Territory and Postmodernity. *Geopolitics, 3*(1).

Andreas, P. R. (1999). *Sovereigns and Smugglers.* Cornell University.

Andreas, P. R. (1999). *Sovereigns and Smugglers: Enforcing the U.S.–Mexico Border in the Age of Globalization.*

Andreas, P. R. (1999). *Sovereigns and Smugglers: Enforcing the U.S.–Mexico Border in the Age of Globalization.*

Barth, F. (1969). Introduction. In *Ethnic Groups and Boundaries: The Social Organization of Culture Difference* (pp. 9–38). Little, Brown and Company.

Bigo, D. (1997). Security, Borders, and the State. In *Borders and Border Regions in Europe and North America* (pp. 81–104). San Diego University Press.

Donaldson, J. (2005). Fencing the Line: Analysis of the Recent Rise in Security Measures along Disputed and Undisputed Boundaries. In *Global Surveillance and Policing: Borders, Security, Identity* (pp. 173–193). Willan Publishing.

Dunn, T. J. (n.d.). Op. cit.

Herz, J. (1957). Rise and Demise of the Territorial State. *World Politics, 9*(4), 482.

Irredentism – Editor's Definition. (n.d.). Editorial Note.

Network, S. S. (2006). *About the Surveillance Studies Network*. Surveillance Studies Network. http://surveillance-and-society.org/.htmjournal.htm

Paasi, A. (1998). Boundaries as Social Processes: Territoriality in the World of Flows. *Geopolitics, 3*(1), 69-88.

R., A. (1984). *Paix et guerre entre des nations.* Calmann-Levy.

Van Houtum, H. (n.d.). Op. cit.

Голунов С. В. (2007). Наркоторговля — вызов безопасности. *Стратегия России*(3).

Гришин М.Л., Губченко В.Н., Дмитриев В.А. (2001).

Проблемы пограничной политики государства и пути их решения. БДЦ-пресс.

Доржням .Ц, Цогтоо.М, Эрдэнэ .С. (2016). *Аюулгүй байдлын нэр томъёоны тайлбар толь.* https://doi.org/Улаанбаатар

Колосов В.А., Мироненко Н.С. (2001). *Геополитика и политическая география.* Аспект Пресс.

Хилийн тухай хууль. (2016). *Эрх зүйн мэдээллийн систем* . https://legalinfo.mn/mn/detail/12418

НИСГЭГЧГҮЙ НИСЭХ ХЭРЭГСЛИЙН ҮҮСЭЛ БА ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА

Г.САЙНБАЯР
Дотоод хэргийн их сургуулийн Хилийн албаны сургуулийн Инженер техникийн тэнхимийн багш, хошууч

Хураангуй: Аж үйлдвэрийн 4 дүгээр хувьсгалын өнөө үед нийгмийн бүх л салбар технологийн хөгжлийн шуурганд автаж өдөр болгон шинэ технологийг эзэмших, ашиглах, сурах шаардлага урган гарч байна. Бүхий л байгууллага албан хаагчийн албаны ачааллыг багасгах, хүрэхэд хүндрэлтэй хэсэгт хяналт зохиох, хяналтыг зохион байгуулах, бүх төрлийн техникийг албандаа ашиглан хүн бүрийг сургах арга хэмжээг тасралтгүй зохион байгуулж байна. Хил хамгаалах байгууллагын хувьд энэ асуудалд онцгойлон анхаарч шинэ техник технологийг үр дүнтэй албанд ашиглан хэрэгжүүлж байгаа ч бид бусад улсын хэрэглэж байгаа зэвсэг технологийг байнгын судалж, албанд нутагшуулах шаардлага үргэлж үүсэж байна. Сүүлийн үед зэвсэгт мөргөлдөөн болон дайны талбар дээр түлхүү ашиглаж байгаа нисгэгчгүй нисэх хэрэгсэл (UAV/дрон) хэрэглээ, тактик-стратегийн нөлөө, техник технологийн чиг хандлага, хууль ёсны болон ёс зүйн асуудлыг тодорхойлох явдал юм.

Түлхүүр үг: Нисгэгчгүй нисэх хэрэгслийн үүсэл, хөгжлийн түүхэн үе шат, цаашдын чиг хандлага

Нисгэгчгүй нисэх хэрэгсэл (UAV/дрон)-ийг 120-иод жилийн өмнөөс үүссэн гэж үздэг.

Нисгэгчгүй нисэх хэрэгслийн хөгжлийн үе шатыг дараах байдлаар авч үзэж болох юм.

1. 1900–1939 он цэргийн тэсрэх бөмбөг тээвэрлэх төхөөрөмж туршиж, Kettering Bug нэртэй нисгэгчгүй “нисдэг бөмбөг” зохион бүтээсэн нь дроны туршилтын буюу эхлэл үе.
2. 1939–1945 он Дэлхийн II дайнд анхны **de Havilland DH.82B Queen bee** нисгэгчгүй нисэх хэрэгслийг практик хэрэглээнд нэвтрүүлсэн үе.
3. 1945–1990 он Тагнуул, тандалтын зорилгоор өргөнөөр ашигласан үе.
4. 1990–2001 он энэ үед дроны хөгжил хурдацтай нэмэгдэж алсаас удирдах, бодит цагийн дүрс дамжуулах технологи бии болсон үе.
5. 2001–2020 он Дроныг зэвсгээр тоноглож байлдааны ажиллагаанд хэрэглэж эхэлсэн үе
6. 2020–2025 Үйлдвэрлэлийн өртөг буурч, хямд өртөг бүхий дронууд ихээр үүсэж, хүртээмж их болж дайны хуучин стратегийг өөрчилсөн үе.

21-р зуунд технологийн хөгжлийн хамгийн эрчимтэй өөрчлөлтийн нэг нь нисгэгчгүй нисэх хэрэгслийн (Unmanned Aerial

Vehicle, UAV) дэвшил бөгөөд энэхүү систем нь харьцангуй богино хугацаанд иргэний болоод цэргийн салбарт стратегийн ач холбогдолтой технологи болон өргөжин хөгжиж байна. Анх 20-р зууны эхэн үеийн туршилтын нисдэг төхөөрөмж хэлбэрээр ашиглагдаж байсан дронууд өнөөдөр хиймэл оюун, алсын мэдрэгч, өндөр нарийвчлалтай камер, автомат хяналтын системээр тоноглогдсон, бие даан шийдвэр гаргах чадвартай цогц платформ болж хувирсан байна. Энэ нь мэдээлэл цуглуулах, газарзүйн зураглал, эрэн хайх ажиллагаа, хүргэлтийн логистик, хөдөө аж ахуйн мониторинг зэрэг олон салбарын бүтээмж, үр ашигт хувьсгал авчрав.

Нисгэгчгүй нисэх хэрэгсэл нь орчин үеийн дайны тактик, аюулгүй байдлын орчныг эрс өөрчлөх хүчин зүйл болсон бөгөөд богино хугацаанд шуурхай маневрлах, хүний амь нас эрсдэлд оруулахгүйгээр нарийн ажиллагаа гүйцэтгэх, өртөг багатайгаар өндөр үр дүнд хүрэх зэрэг онцлог нь тэднийг зэвсэгт мөргөлдөөнүүдийн үндсэн хэрэгсэл болсон гэхэд хилсдэхгүй болжээ. Ялангуяа 2020 оноос хойших бүс нутгийн мөргөлдөөнүүдэд UAV-ийн хэрэглээний хүрээ улам өргөжин, FPV төрлийн хямд өртөгтэй дрон, электрон довтолгооны эсрэг системүүд, автоматажсан тактик зэрэг шинэ хандлагууд бий болж байна.

Үүнээс гадна нисгэгчгүй нисэх хэрэгслийн хэрэглээ хүчтэй нэмэгдэхийн хэрээр агаарын зай ашиглалтын зохицуулалт, хувийн мэдээллийн хамгаалалт, дрон–эсрэг дрон технологийн шаардлага зэрэг хууль эрх зүйн болон аюулгүй ажиллагааны асуудлууд хурцаар тавигдах болсон. Иймд UAV технологийн хөгжлийн динамик, хэрэглээний олон талт байдал, түүний дагаж гарч буй сорилт, боломжийг шинжлэх нь өнөөгийн шинжлэх ухаан, технологи, нийгэм, аюулгүй байдлын судалгаанд онцгой шаардлагатай асуудал болж байна.

21-р зууны зэвсэгт мөргөлдөөнүүдийн онцлог чанар нь цэргийн ажиллагаанд өндөр технологийн системүүд хурдацтай нэвтэрч, хүчний харьцааг үндсээр нь өөрчилж буй явдал бөгөөд тэдгээрийн дундаас нисгэгчгүй нисэх хэрэгсэл (Unmanned Aerial Vehicle, UAV) хамгийн нөлөө бүхий зэвсэгт платформуудын нэг болж байна. Анх 20-р зууны эхэн үеийн тагнуулын болон сургалтын зориулалттай туршилтын төхөөрөмжөөс үүссэн дронууд XXI зуунд хиймэл оюун, опто-электроник мэдрэгч, алсын холбооны өндөр нарийвчлалтай систем, автомат нислэгийн алгоритм бүхий цогц зэвсэгт платформын хэмжээнд хөгжсөн нь орчин үеийн дайны тактик, стратегид томоохон өөрчлөлт авчрав.

Цаашдын хөгжлийн чиг хандлага

Сүүлийн арван жилүүдэд болсон зэвсэгт мөргөлдөөнүүд —

тухайлбал Сири, Ливи, Нагорно-Карабах, Украин–Оросын мөргөлдөөн — нисгэгчгүй нисэх хэрэгслийн цохилт өгөх, тагнуул–тандалт (ISR), галын удирдлага, чиглүүлэх, электрон довтолгоо болон эсрэг дрон ажиллагаанд гүйцэтгэх үүргийг урьд өмнө байгаагүй хэмжээнд харуулсан юм. Ялангуяа хямд өртөгтэй FPV (First-Person View) төрлийн дрон, алсын зайн ажиллагаатай зэвсэглэсэн UAV (MALE/HALE), автомат бай илрүүлэлт бүхий AI системүүд нь хээрийн нөхцөлд шуурхай маневрлах, өндөр үнэтэй техник устгах, хүний амь нас эрсдэлгүйгээр нарийн ажиллагаа гүйцэтгэх зэрэг шинжээрээ уламжлалт зэвсэгт хүчний онол, практикийн тогтолцоог эмзэг болгож, орчин үеийн зэвсэгт мөргөлдөөнд сул талтай нь хүчтэй талд шууд бус, уламжлалт бус аргаар үйлдэл хийхийг давуу тал болгож байна.

Дроныг хэрэглэж буй талуудыг саармагжуулах олон төрлийн арга, технологи хөгжиж байна: радио давтамж гажуулалт (jamming), GPS spoofing, физик (kinetic) устгал, RF (radio-frequency) барих/хайчлах систем, мөн өндөр цахилгаан соронзон (HPM) болон микро долгионы систем зэрэг. Сүүлийн үеийн жишээнд Epirus компаниас танилцуулсан Leonidas систем зэрэг өндөр энергийн микроволны төхөөрөмжүүд сүрэг дронуудыг багцлан унтраах боломжтойг харуулсан туршилтыг амжилттай үзүүлсэн (олон тооны дрон устгасан тайланд). Ийм контр-технологи нь дронуудын өрсөлдөөнт давхаргад шинэ “томоохон” зөрчил үүсгэж байна — дронууд «илрэхгүй байх» болон «эвдрэлд тэсвэртэй байх» тал дээр хөгжиж байгаа бол харин тэдэнд эсрэг технологиуд улам илүү хүчирхэгжиж байна

Дрон ашиглах нь олон улсын хүмүүнлэгийн хууль (IHL) — ялгах зарчим (distinction), пропорциональ зарчим (proportionality), шаардлагын зарчим (necessity) болон болзошгүй хохирлыг бууруулах зарчмуудтай салшгүй холбогдоно. Дронуудын ашиглалтыг хянах, хариуцлага тооцох (accountability), албан ёсны эрх бүхий шийдвэр гаргах механизмын тун амаргүй байдал нь олон улс, судлаачдын анхаарлыг татаж байна. Үүнээс гадна дронуудын хязгааргүйгээр ашиглагдах нь төрийн бүрэн эрх (state sovereignty) ба хууль ёсны тулгамдсан асуудлуудыг үүсгэнэ

Дүгнэлт

Үүнээс дүгнэж үзэхэд Нисгэгчгүй нисэх хэрэгслийн цэргийн хэрэглээ хурдацтай тэлэхийн хэрээр агаарын зай хамгаалалт, радио-электрон тэмцэл, дрон-эсрэг дрон (C-UAS) технологи, логистикийн тогтвортой байдал, кибер халдлагын эрсдэл зэрэг шинэ үеийн сорилтууд хүчтэй нэмэгдэж байна. Эдгээр хүчин зүйлс нь жижиг дроноос эхлээд стратегийн түвшний UAV хүртэлх бүх төрлийн системд хамааралтай бөгөөд улмаар үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах бодлого, цэргийн ажиллагааны төлөвлөлтөд шинэ шаардлага тавьж байна.

ХИЛ ХАМГААЛАЛТЫН ТЕХНИК ХЭРЭГСЛИЙН НЭР ТОМЬЁО

Ш.УНДАРГА
Дотоод хэргийн их сургуулийн Хилийн албаны сургуулийн Инженер техникийн тэнхимийн ахлах багш, хошууч

Шинжлэх ухаан хурдацтайгаар хөгжиж өдөр тутам техник технологийн салбар шинэ бүтээл, шийдэлтэй нүүр тулж байна гэхэд хилсдэхгүй болжээ.

Өнөө цаг үед дэлхийн цөөнгүй улс орнууд газар нутгийн маргаан, дайн болон зэвсэгт мөргөлдөөн бүхий байдалтай байна. Сүүлийн 10 жилийн хугацаанд өрнөсөн дайн, зэвсэгт мөргөлдөөн нь байлдааны уламжлалт арга хэлбэрээс нисгэгчгүй нисэх хэрэгсэл (ННХ), дохиолол хяналтын хэрэгслийн (ДХХ) түлхүү ашигласан технологийн хэлбэрт шилжиж байгаа нь төрийн цэргийн байгууллагын бие бүрэлдэхүүн тэдгээрийг судалж эзэмших, төрөл ангиллыг ялгаж мэдэх, нэгдсэн нэр томьёог алба үйл ажиллагаандаа ашиглах шаардлага гарч байна. Дээрхтэй холбоотойгоор Хил хамгаалах байгууллага төдийгүй бусад салбаруудад дээрх шинэ тутмын техник хэрэгслийн нэр томьёо, ангилал, нэршлийг нарийвчлан ялгаж оноон албажуулсан дүрэм, журам заавар төдийлөн байдаггүй. Үүнээс үүдээд алба хаагчид олон улсад ашиглагдаж байгаа нэршлийг өөрсдийн ойлгосон, орчуулсан, ярьж хэвшсэн байдлаар хэрэглэдгээс үүдэн нэгдсэн ойлголтгүй байна.

Үндсэн хэсэг

Хил хамгаалах байгууллага 1960-аад оноос алба үйл ажиллагаандаа техник технологийн дэвшлийг эрчимтэй ашиглаж эхэлсэн боловч 1990-ээд оны шилжилтийн үед энэхүү ажиллагаа зогсонги байдалд орж 2000-аад оноос сэргэж эхэлсэн байдаг.

Өнөөгийн байдлаар хил хамгаалалтад шилэн кабелийн урт хэсгийн дохиоллын систем, жижиг оврын онгоц хэлбэрийн болон квадрокоптер хэлбэрийн нисгэгчгүй нисэх хэрэгслүүд, телехяналтын систем, түргэн дэлгэгдэх дохиоллын систем/хэрэгслүүд, хил хамгаалалтын программ хангамжууд зэрэг техник хэрэгслээр улсын хилийг хамгаалах чиглэлийг баримтлан худалдан авч үйл ажиллагаандаа ашиглаж байна. Цаашид техник хэрэгслийн төрөл зүйл нэмэгдэх хандлагатай байгаа нь энэхүү ахиц дэвшлийг дагаад тэдгээрийн төрөл, ангилал, тавигдах шаардлага, нэршил зэргийг тодорхойлон тайлбарласан эрх зүйн баримт бичгүүд боловсруулж албанд ашиглах шаардлага үүсэж байна.

Бид албаны өдөр тутмын үйл ажиллагаанд “Систем”, “хэрэгсэл”, “төхөөрөмж”, “телекамерын систем”, “хяналтын камерын систем”, “телехяналтын систем”, “дрон”, “нисгэгчгүй нисэх хэрэгсэл”, “урт хэсгийн”, “түргэн дэлгэгдэх дохиоллын систем” гэх зэрэг нэршлүүдийг хэрэглэдэг ч тэдгээр нэршлийн хамрах хүрээ, ямар агуулга оршиж байна вэ, ямар бүтэцтэй зүйлийг энэ үгээр төлөөлүүлэн хэлэх вэ гэдгийг журамлан албажуулсан тодорхой эрх зүйн баримт бичиг төдийлөн байхгүй.

Олон улсад хил хамгаалалт, дохиолол хяналт, техник хэрэгслийн салбарт ашиглагдаж буй үг, нэршил бүхэн өөр өөрийн утга, агууламж, ажиллагааны зарчим, тэдгээрийн хамрах цар хүрээг тодорхойлсон эрх зүйн баримт бичгийг хууль тогтоомж, тушаал зааврaар албажуулсан байх бөгөөд алба үйл ажиллагаандаа тэрхүү эрх зүйн баримт бичгийг баримтлан хэрэглэж байна.

Жишээ нь хил хамгаалалтын техник хэрэгслийн хүрээнд “төхөөрөмж” гэдэг нь тодорхой нэг үүргийг дангаар гүйцэтгэх боломжийг өөртөө багтаасан, өөрийн тэжээлийн эх үүсвэр, мэдээлэл дамжуулах сувагтай нэгж техник /гар станц, GPS төхөөрөмж гэх мэт/ гэж тодорхойлогдож байна.

Ижил эсхүл өөр өөр төрлийн 2 ба түүнээс дээш “төхөөрөмж”-ийн нэгдэл нэг үүргийг гүйцэтгэж байгааг систем.

Хоёр буюу түүнээс дээш систем нэгдэн ажиллаж нэг буюу хэд хэдэн төрлийн үүргийг гүйцэтгэж байгаа нэгдлийг комплекс буюу цогцолбор гэж тодорхойлж байна.

Урт хэсгийн дохиоллын систем гэх үгийг олон улсад хэрэглэгдэж буй “Linear Ground Detection System” /англи/ “Сигнализационная систма охраны протяженных участков” (ОХУ) гэх нэршлийг монгол хэлэнд орчуулан “Үргэлжилсэн урт хэсгийн дохиоллын систем” гэж ашиглаж байна. Энэ нь монгол хэлнээ албажуулан баталсан нэршил биш бөгөөд хэдэн метрээс дээш зайг халхалдаг зүйлийг урт хэсгийн гэх, ямар зориулалтаар ашиглах тухай нэгдсэн ойлголт өгөх эрх зүйн баримт бичиг байхгүй.

Дээрхийн адилаар түргэн дэлгэгдэх дохиоллын систем/хэрэгсэл/ ангилалд хэдий хугацаанд ажиллагаанд бэлэн болдог, хир удаан хугацаанд ашиглагддаг техник, хэрэгслийг хамааруулах нь мөн тодорхойгүй байна.

“Газар орон дээр байршуулахад харьцангуй бага хугацаа шаардах, байршлыг цагийн байдлын өөрчлөлтөд тохируулан богино хугацаанд өөрчлөх боломжтой, газар орныг урьдчилан бэлтгэх шаардлагагүй, хил зөрчигчийг хамгаалалтын зааг руу дөхөж ирэх үед урьдаас мэдэж мэдээлэх, анхааруулах боломжийг хилийн манааны бүрэлдэхүүнд олгох зориулалттай техник хэрэгслийг хэлнэ” гэж орчуулан тодорхойлж болох юм.

Нисгэгчгүй нисэх хэрэгслийн тухайд илүү дэлгэрэнгүй авч үзэх шаардлагатай. ННХ буюу дрон нь бүхээгтээ нисгэгчгүй, алсаас удирдагдах эсхүл урьдчилан программчилсан замналаар үүрэг гүйцэтгэх хэрэгсэл гэх агуулгатай тодорхойлогдож байна.

Хөгжингүй орнууд ННХ-ийн өөрийн жин, нислэгийн даац, ажиллагааны зарчим, хэлбэр, хөдөлгүүрийн төрөл болон бусад үзүүлэлтүүдээр нь дараах байдлаар ангилсан байна.

Бага оврын

Ангилал	Нислэгийн жин, кг	Нислэгийн алслалт, км	Нислэгийн өндөр, м	Нислэгийн хугацаа, ц
нано	<0,025	<1	<100	<1
микро	<5	<10	<250	1<
мини	5-150	<10	150-300	2<

Тактикийн

Ангилал	Нислэгийн жин, кг	Нислэгийн алслалт, км	Нислэгийн өндөр, м	Нислэгийн хугацаа, ц
Хөнгөн авангард	25-150	10-30	3000	2-4
Хөнгөн /ойрын зайн/	50-250	30-70	3000	3-6
Дундын	150-500	70-200	5000	6-10
Дундын /нислэгийн хугацаа урттай/	500-2500	>500	8000	10-18
Нам өндрийн	250-2500	>250	50-9000	0.5-1
Нам өндрийн /нислэгийн хугацаа урт/	15-25	>500	3000	>24
Дунд өндрийн	1000-1500	>500	5000-8000	24-48

Стратегийн

Ангилал	Нислэгийн жин, кг	Нислэгийн алслалт, км	Нислэгийн өндөр, м	Нислэгийн хугацаа, ц
Өндрийн /нислэгийн хугацаа урт	2500-5000	>2000	20000	24-48
Байлдааны /цохилтын/	>1000	1500	12000	2

Тусгай зориулалтын

Ангилал	Нислэгийн жин, кг	Нислэгийн алслалт, км	Нислэгийн өндөр, м	Нислэгийн хугацаа, ц
Байлдааны зэвсгүүдээр тоноглогдсон	-	300	4000	3-4
Хуурамч бай	150-500	0-500	50-5000	<4
Стратосферийн	>2500	>2000	>2000	>48
Экзостратосферийн	-	-	>30500	-

ННХ-ийг ажиллагааны зарчим, хэлбэрээр нь:

Онгоц хэлбэрийн (хөдөлгөөнгүй далавчтай):

Аэродинамикийн хуулийг ашиглан далавчны тусламжтайгаар өргөх хүчийг үүсгэж нисэх зарчмаар ажилладаг.

Вертолёт хэлбэрийн (сэнстэй)

А. Нэг роторт (Коптер): ННХ нь хийцээрээ нисдэг тэрэгтэй төстэй. Нэг том үндсэн сэнс, заримдаа нислэгийн чиглэлийг хянах, удирдах зорилгоор сүүлэн дээрээ нэг жижиг сэнстэй.

Б. Мульти роторт буюу олон роторт (Квадрокоптер): ННХ-нь гурваас дээш тооны (brushless) хөдөлгүүр ба сэнстэй, нисдэг платформ.

Холимог (Хайбрид):

Онгоц хэлбэрийн болон мульти роторын ННХ-ийн онцлог, шинж чанаруудыг хослуулсан, сэнснүүд нь хөөрөх, буух үед өргөлтийн хүч үүсгэх, ердийн нислэгийн үед түлхэх сэнс (таталт) -ний үүргийг гүйцэтгэнэ гэх мэтээр олон улсад ангилан төрөлжүүлж эрх зүйн баримт бичгээр албажуулсан байх бөгөөд алба хаагчид нь өгөгдсөн нэршлийг гажуудуулалгүй хэрэглэж нэгдмэл ойлголттой байдаг нь ажиглагдаж байна.

Дохиолол хяналтын техник хэрэгслийн нэршлийн талаар нэгдсэн ойлголттой болгох зорилгоор судлаачийн зүгээс дараах нэршил, тодорхойлолтыг санал болгож байна.

Дохиолол, хяналтын төхөөрөмж – хилийн хэсэг, объектод хяналт тавих, зөрчлийн мэдээллийг цуглуулах, боловсруулан дамжуулах, дохиолох зориулалт бүхий төрөл бүрийн физик ажиллагааны зарчмаар ажилладаг электрон хэрэгслийг хэлнэ.

Дохиолол хяналтын систем - хоёр болон түүнээс дээш тооны төхөөрөмж хоршин ажиллаж тодорхой үүргийг гүйцэтгэж байгаа төхөөрөмжийн нэгдлийг хэлнэ.

Дохиолол хяналтын цогцолбор – нэгдсэн удирдлагатай, хоёр болон түүнээс дээш системээс бүрдсэн нэгдлийг хэлнэ.

Урт хэсгийн дохиоллын систем – улсын хилийн 1км-ээс дээш хэсгийг тасралтгүй хянах, хилийн зөрчлийн мэдээллийг шуурхай дамжуулах зорилгоор байнгын байдлаар дэлгэн байрлуулсан нэгдсэн удирдлага бүхий хэд хэдэн төхөөрөмжийн нэгдлийг хэлнэ.

Түргэн дэлгэгдэх дохиоллын систем/хэрэгсэл - Газар орон дээр байршуулахад харьцангуй бага хугацаа шаардах, байршлыг цагийн байдлын өөрчлөлтөд тохируулан богино хугацаанд өөрчлөх боломжтой, газар орныг урьдчилан бэлтгэх шаардлагагүйгээр хилийн зөрчил гарч болзошгүй чиглэл, хил зөрчигч нуугдаж болзошгүй газар орон, хүрэхэд хүндрэлтэй, хилийн цагийн байдлын өрнөлт ихтэй хэсэг, хилд ойрхон суурьшлын бүс, улсын хилийг дайран өнгөрч буй авто болон төмөр зам, хил огтлон гарч буй гол, нуурын эрэг, гарам зэрэг газруудад 2 цаг хүртэлх хугацаанд дэлгэгдэж суурин болон хөдөлгөөнт

байдлаар мэдээлэл цуглуулах, дамжуулах зориулалттай систем/хэрэгслийг хэлнэ.

Нисгэгчгүй нисэх хэрэгсэл – Бүхээгтээ нисгэгчгүй, алсаас удирдах болон урьдчилан программчилсан замналаар эсхүл хосолсон удирдлагатай байдлаар нислэг үйлдэж тодорхой үүргүүдийг гүйцэтгэх хэрэгслийг хэлнэ.

Нисгэгчгүй нисэх онгоц – Далавч бүхий аэродинамикийн хуулийг өргөлтийн хүч болгон нислэг үйлддэг, нэмэлт хэрэгслээр тоноглон тодорхой үүргүүдийг гүйцэтгэх боломжтой нисэх хэрэгслийг хэлнэ.

ДҮГНЭЛТ:

Өнөөгийн байдлаар Монгол Улсад Цэргийн тайлбар толь, Аюулгүй байдлын толь, Гадаад хэлний тайлбар толь-ууд” зохиогдон олны хүртээл болсон байх боловч шинэ цагийн техник технологийн салбарын нэр томьёог тайлбарлан тодорхойлсон бүтээл байхгүй байна. Иймд нэр томьёог цэгцэлж, техник хэрэгслүүдийн төрөл, ангилал, нэршлийг тодорхойлж албажуулан олон нийтэд хүртээл болгон мөрдүүлэх шаардлагатай байна.

ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧИЙН СЭТГЭЛ ЗҮЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТҮҮНИЙГ УДИРДАХУЙН АСУУДАЛ

Сэтгэл зүй бол хүний хамгийн үнэт зүйл,
хөдөлгөгч хүч юм. Курт Левин

Т.АРИУНСҮХ
Дотоод хэргийн их сургуулийн Биеийн тамир, албаны бэлтгэлийн институтийн багш, ахлах дэслэгч

Хураангуй: Хилийн цэргийн 0168 дугаар анги, Хилийн албаны сургуулийн 4431, 4421 дүгээр дамжааны сонсогч нараас судалгаа авч Хил хамгаалах байгууллагын алба хаагчдын сэтгэл зүйн байдлыг боломжит хувилбараар тогтоохыг зорилоо. Судалгааны эрэл, хайгуулын үндсэн дээр тэдний сэтгэл зүйн байдалд тулгамдаж байгаа асуудлыг нээн илрүүлэх, шийдвэрлэх “арга, зам”-ыг эрэлхийлэх оролдлого хийсэн болно.

Түлхүүр үгс: Төрийн тусгай байгууллага, алба хаагчдын сэтгэлзүй, ажлаас халшрах хам шинж

Нэг. Үндсэн хэсэг

Ажлын сэтгэл зүй асуудал нь орчин үеийн сэтгэл судлалын шинжлэх ухааны үндсэн судлагдахуун болж, шинжлэх ухааны бүхий л салбарын эрдэмтэн судлаачдын анхаарлын төвд байгаа бөгөөд байгууллагын сэтгэл судлал болон ажлын байран дахь ажилчдын (алба хаагчид) зан төлөвийг судлахад чиглэдэг байна[8].

Аж үйлдвэрийн сэтгэл судлалын анхдагч гэгддэг Хюго Мюнстерберг (1887-1913)[9], ажлын сэтгэл судлалыг *“...ажилчид болон тэдний ажлын орчин хоорондын харилцааг шинжлэх ухаанаар судалдаг...”* гэж тодорхойлсон бөгөөд *“...ажилчдын бүтээмж, сайн сайхан байдлыг сайжруулахын тулд сэтгэл зүйн зарчмуудыг хэрэгжүүлэх нь нэн чухал...”* болохыг онцолсон байна.

Алдарт сэтгэл зүйч Курт Левин (1890-1947)[10] ажлын байрны буюу ажлын сэтгэл судлалын салбар нь *“...хувь хүн болон бүлгийн зан төлөвт байгууллагын хүрээнд янз бүрийн хүчин зүйл хэрхэн нөлөөлж байгааг судалдаг шинжлэх ухаан....”* гэж, ажлын урам зориг, ажлын сэтгэл ханамжийг судалдаг нэрт зүтгэлтэн Эдвин А.Локке, ажлын сэтгэл судлалыг *“...тухайн хүний ажлын байран дахь гүйцэтгэл, сэтгэл ханамжид нөлөөлдөг сэтгэл зүйн үйл явцыг судлах явдал...”* гэж тус тус тодорхойлсон (LockeEdwin, 1976).

[8] Тематический философский словарь: Московский государственный университет имени М.В. Ломоносова. МОСКВА. 2009., С. 7

[9] Албан ёсны сайт http://nrs.harvard.edu/urn-3:HUL.InstRepos:12274284 хандсан огноо (2023.10.16)

[10] Lewin, K. (1935). A dynamic theory of personality. New York: McGraw-Hill.

Сэтгэл судлаач Гордон Виллард Олпорт (1897-1967) хувь хүний мэргэжлийн сонирхлыг төлөвшүүлэхэд *“...соёл, нийгмийн хүчин зүйлс маш чухал...”* болохыг онцолсон бөгөөд[11] ажлын сонирхолд *“...тухайн хүний соёлын гарал үүсэл, гэр бүл, нийгмийн туршлага...”* нөлөөлдөг гэж тэрээр үзсэн (NicholsonIan, 1998).

Эндээс бид ажлын “сэтгэл зүй” болон “дур, сонирхол”-ын асуудал нь *“...хүний амьдралын туршид хувьсан өөрчлөгдөж, амьдралын янз бүрийн үүрэг, туршлагаас шалтгаалж байдаг...”,* “ажлын онцлог” нь *“...урам зориг, ажлын сэтгэл ханамж, ажилчдын сайн сайхан байдал...”* зэрэг олон хүчин зүйлс эерэг, сөргөөр нөлөөлдөг гэж үзэж болохоор байна.

Судлаачийн зүгээс *“...төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын алба хаагчдын сэтгэл зүйн өнөөгийн байдал, түүнийг удирдахуйн асуудал...”* сэдвийг судлахын өмнө тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын хэрэгжүүлж буй үндсэн чиг үүрэгтэй *“...нэн тэргүүнд, зайлшгүй...”* хамааруулж үзэх нь зүйтэй гэж үзсэн.

Хүмүүн төрөлхтөн өөрсдийн амьдарч буй хорвоо ертөнцөд хүрээлэн оршин тогтнож буй эд зүйлсийг төрөл, хэлбэрээр нь *“...амьтай, амьгүй...”,* нөлөөлөл, хамаарал талаас нь хүнээс хамаарах буюу “субьектив”, хүнээс хамааралгүй буюу “обьектив” хүчин зүйлс[12] гэж ангилан авч үздэг.

Эндээс бид төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлж буй байгууллагуудын хууль, эрх зүйн баримт бичигт *“...хар бэхээр цагаан цаасан дээр бичээгүй...”* чиг үүргийг олж авахыг хичээсэн бөгөөд өмнө нь түүхийн аливаа эх сурвалж, судалгааны ажилд бичиж үлдээгээгүй, хэн нэгэн эрдэмтэн, судлаач цохон тэмдэглээгүй, бусдаас өөр ангид байдлаар тодорхойлохыг зорьсон болно.

Буцаад бид хөндсөн сэдвийн хар үсгийн мөрийг ухаж олсон нь “...нэгдүгээрт төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын чиг үүрэг, үйл ажиллагаа бидний мөрийн өмнө дурдсан өгүүлбэрээр бол “...амьтай...” тодотголд хамааруулж, хоёрдугаарт, “...амьгүй...” зүйл буюу нүдэнд харагдаж, гарт баригддаггүй зүйлийг хүртэл яруу найргийн хэллэгээр “...амьчилж...” хийдэг ажил юм, гуравдугаарт, хамаарах хүчин зүйлийн хувьд цэвэр хүнээс буюу “субьектив” хүчин зүйлийг “обьектив” хүчин зүйл руу

[11] Албан ёсны сайт: doi.10.1037/1093-4510.1.1.52. ISSN 1939-0610. PMID 11620320. (хандсан огноо: 2023.10.16)

[12] Э.Жамбалрагчаа. “Монгол улсын төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын залуу офицеруудын албандаа итгэх итгэл, үнэмшил, хүний нөөцийн асуудал”. “Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын залуу офицеруудад тулгамдаж буй асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ., 2023. 68 дахь тал.

чиглүүлж хийдэг ажил юм гэж тодорхойлсон.

Энд олсноос судлаачийн зүгээс төрийн тусгай байгууллага бүрийн чиг үүрэг бүрийг нэг бүрчлэн дурдалгүйгээр нэгдүгээрт, амьд биес буюу хүнтэй харьцдаг, хоёрдугаарт, хэрэгжүүлж буй чиг, үүрэг үйл ажиллагаа нь субьектив хүчин зүйлс буюу хүний хүчин зүйлээс шууд хамаардаг, гуравдугаарт бидний "итгэл, үнэмшил" болсон *"...эх орон, тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал..."* гэсэн "абстракция" буюу хиймэл ухагдахуунд шууд чиглэдэг юм байна.

Дээр дурдсан ойлголт, хүчин зүйлүүдээс магадгүй *"...дархан хилийн мөнхийн манаа, эх орны онгон хил, халдашгүй дархан байдал, энх цагийн баатрууд, амгалан төрийн алтан аргамж, монгол төрийн цагдаа, хүчин..."* гэх үгс урган гарсан байж болох юм.

Тэдний үйл ажиллагаа, чиг үүрэг хүнтэй ажилладаг, хүнийг хүн болгодог *(энд зөвхөн хар цэргийг хүмүүжүүлэх талаар яриагүй, бидний өмнөх үе, удирдлага, ахлахууд, ахмадууд биднийг халамжлан хүмүүжүүлж, энэ цаг үеийг бидэнд залгуулсан)* тусгай, онцгой чиг үүрэг тул мэргэжлээс шалтгаалах бие махбодын болон сэтгэцийн эрүүл мэндийн өвчлөл, өөрчлөлт, эмгэгүүд сэтгэлзүйн тулгамдсан асуудлууд нь ***(цэрэг амиа хорлох, буу авч дутаах, алба хаагч амиа егүүтгэх)*** зэрэг нийгмийн цочроосон мэдээллээр илрэн гарч байгааг бид мартах юун.

Дэлхий дахины шинжлэх ухааны орчин үеийн сэтгэл судлалын судалгааны ажлууд нь *"...мэргэжлээс шалтгаалсан сэтгэл зүйн өөрчлөлт, эмгэгүүд нэлээдгүй шинээр бий болсон...."* талаар баталж байгаа бөгөөд тэр дундаа хүнтэй ажилладаг төрийн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагууд болон нийгмийн салбарын мэргэжилтний дунд тохиолдож байгаа сөрөг илрэлийн нэг нь ***"ажлаас халширах хам шинж"*** юм.

Ажлаас халшрах хам шинж буюу "burnout" нь гадаад болон дотоод хүчин зүйлсийн нөлөөн дор олон төрлийн зан ааш, араншинтай хүмүүстэй харилцах явцад үүсдэг сэтгэл зүйн тамирдал, шавхагдал бөгөөд алба хаагч эрч хүчгүй болсон үедээ *"...хүнтэй харилцах явцдаа зөрчилдөх, маргалдах нь ихсэх, амьдралын утга учир, үнэт чанарын талаарх мэдрэмж буурах, хайхрамжгүй хандах, сэтгэл хуваалцахаас төвөгшөөх..."* зэрэг шинж тэмдгүүдээр илэрдэг байна.

Сэтгэл зүйн энэ төрлийн эмгэгийг 1974 онд Америкийн Нэгдсэн Улсын сэтгэц мэдрэлийн эмч, сэтгэл судлаач Х.Д.Фрейденберг анх удаа *"...мэргэжлийн сэтгэл гутрал" өөрөөр хэлбэл сэтгэл зүйн ядаргааны туйлдсан байдал..."* хэмээн хэрэглэсэн бөгөөд "burnout" буюу ажлаас халшрах хам шинж нь *"...ямар нэгэн ажлыг бүтээн бий*

болгох явцад биеийн болон оюуны үйл ажиллагаанаас бэрхшээх, зүрхшээх сэтгэцийн эмгэг өвчний харилцан уялдаатай олон шинжийн цогцолбор...”[13] гэж тодорхойлсон байна.

Ажлаас халшрах хам шинжийн нөлөөгөөр *“...алба хаагчийн албандаа хандах итгэл, үнэмшил, дур сонирхолгүй болох, ажил, мэргэжлийн түвшинд бүтээмж, гүйцэтгэл буурах, аливаа зүйлийг эергээр хүлээж авахаа болих, байгууллагын хэвийн үйл ажиллагаа алдагдах...”* зэрэг асуудлууд үүсдэг бөгөөд алба хаагч сэтгэцийн болон биеийн эрүүл мэндийн хувьд хүндрэл бэрхшээл тулгарч байгууллага, ажилтан хоёрын аль аль нь эрсдэлтэй нөхцөл байдалд ордог байна.

Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын офицеруудын ажилд нэн тулгамдсан асуудлыг нэгдүгээрт, *удирдах ажилтны арга барил – 35.7%*, *хоёрдугаарт,* цалин хөлс бага – 21,4%, *гуравдугаарт, амьдрах орон нууц байхгүй – 22,4%, дөрөвдүгээрт, дэвшин томилогдох болон гэр бүлийн гишүүд хамт нэг байгууллагад ажиллах боломж хомс, орон тоо байхгүй – 14,3%, тавдугаарт, ажил, албандаа хандах дур сонирхолгүй болсон – 8,0%* гэсэн байдлаар эрэмбэлж *сонгосон байна.*

Бидний явуулсан судалгааны эцсийн үр дүнгээс үзэхэд ажлаас ***хамаарах хам шинжээс шалтгаалан*** төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын офицеруудын албандаа итгэх итгэл үнэмшил, албаны дур сонирхол тодорхой хэмжээгээр буурсан гэж үзэж болохоор байна.

Хүснэгт. 1. Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын офицеруудад нэн тэргүүний тулгамдсан асуудлын харьцуулалт.



Түүнчлэн энэ төрлийн сэтгэл зүйн эмгэг нь зөвхөн хүнтэй ажилладаг ажил мэргэжлийн хувьд үүсэх ба *“...хүн бүрийн бусад хүнд үзүүлж буй эерэг, сөрөг хандлага, харьцаанаас шалтгаалан алба хаагчийн сэтгэцэд бий болж буй олон шинжийн эмгэгийн цогцолбор...”* гэж үзэж болох бөгөөд ажлаас халшрах хам шинж илэрсэн алба хаагч, ажилтанд *“...стресс, сэтгэл гутрал, айдас, түгшүүр,*

[13] М.Хишигбаяр. “Монгол улсын төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын залуу офицеруудын ёс зүй, ёс суртахууны төлөвшлийн байдал”. “Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын залуу офицеруудад тулгамдаж буй асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ., 2023. 48 дахь тал.


илрэхээс гадна сэтгэл зүйн тавгүйдэл, харьцаа холбооны хөндийрөл илрэх магадлал их...” байдаг талаар судлаачид нотолсон байна.

Ажлаас халшрах хам шинжээс үүдэлтэй сэтгэл зүйн харьцаа холбооны хөндийрөл, өөрийгөө тусгаарлах үзэгдэл нь эхний шатандаа нийгмийн буюу хамт олны харилцаа буурах, хүсэл тэмүүлэл, бүтээлч үйл ажиллагаа суларч, ганцаардах, мэдрэмтгий, тээнэгэлзэх, өөртөө хэт дүн шинжилгээ хийх зэрэг шинжүүдээр илэрдэг байна.

Сэтгэл судлалын доктор /Ph.D/ профессор Д.Эрдэнэчулуун ажлаас халшрах хам шинж нь *“...алба хаагч ажлын эрч хүчгүй болох, бусадтай харилцах явцдаа зөрчилдөх нь ихсэх, амьдралын утга учир, үнэт чанарын талаарх мэдрэмж буурах, хайхрамжгүй хандах, сэтгэл хуваалцлаас төвөгшөөх...”* зэрэг шинж илэрдэг талаар дурсан байна.

Судалгаанд хамрагдсан алба хаагчдын 1,9% нь ажлаас халшрах хам шинж *“маш доогуур”,* 12 *% нь “доогуур буюу бараг илрээгүй”* сайн үзүүлэлттэй гарсан бол 86.1% *нь* ажлаас халшрах хам шинж ***“дундаас дээш түвшинд”*** илэрсэн дүн гарсан.[14]


Хүснэгт 2. Хил хамгаалах байгууллагын алба хаагчдын ажлаас халшрах хам шинжийн тоон үзүүлэлт.



Харин харилцаа холбооны хөндийрөлд 18.8 *%* нь *“өндөр”,* 55.6 *%* нь *“дунд түвшинд”* 25.6% *“хэвийн”* гэсэн дүнтэй гарсан бөгөөд алба хаагчдын 74.4 *%* нь *“...хүмүүстэй харилцаа, холбоо тогтоохоос зайлсхийх, эсвэл цөөрүүлэх, харилцаа үүссэн нөхцөлд уцаарлах, бухимдах, зөрчилдөх, хамт олондоо эргэлзэх, сөргөөр хандах...”* зэрэг хандлагатай үр дүн үзүүлсэн байна.

Хүснэгт 2. Алба хаагчдын харилцаа, холбооны хөндийрлийг харуулсан тоон үзүүлэлт.

[14] П.Баярбаатар “Хорих ангийн алба хаагчдын ажлаас халшрах хам шинжийг ажлын сэтгэл ханамжтай холбон судалсан нь” магистрын ажил. УА., 2020. 52 дахь тал.



Ажлаас халшрах хам шинжийн түвшин нэмэгдэхэд *“...алба хаагч ажиллах эрч хүчгүй болох, хүмүүстэй харьцах явцад зөрчилдөх нь ихсэх, амьдралын утга учир, үнэт чанарын талаарх мэдрэмж сулрах, өөртөө итгэх итгэл алдрах, бусад хүмүүсийн санаа бодол, мэдрэмжид хайхрамжгүй хандах буюу хүнлэг чанар буурах, бусадтай харилцаанд орох, сэтгэл хуваалцахаас төвөгшөөх, зожиг болох...”* зэрэг шинж тэмдгүүд илэрч байдаг байна.

Түүнчлэн ажлаас халшрах хам шинж нь *“...алба хаагчдад ядрах, нойргүйдэх, аливаа зүйлийг эргээр хүлээн авахаа болих, хүмүүст шүүмжлэлтэй, хүнлэг бусаар хандах, өөрийн үүргийг гүйцэтгэх хүсэлгүй болох, ажилдаа хойрго хандах, урт завсарлага авах, хоцрох, эсвэл ажлаасаа эрт гарах хувийн хэрэгцээндээ төвлөрөөд амьдралын зорилгоо алдах, атаархалд автах, сэтгэл гутралд өртөх, хардамтгай болох, бусадтай зөрчилдөх, үйл ажиллагааны үр өгөөж буурах, даалгаврыг зөвхөн зааврын дагуу гүйцэтгэх, никотин, кофе, согтууруулах ундаанаас хамааралтай болох донтох магадлал өндөр болдог...”* гэж эрдэмтэд үзсэн байна.

Согтууруулах ундааны зүйл, тамхи (никотин), кофе зэргээс хамааралтай болох эмгэг нь тэдгээрийг зүйлийг хэтрүүлэн хэрэглэснээс үүдэлтэй нийгэм, сэтгэц болон бие махбод физиологийн дасан зохицох байдалд эмгэг хямрал үүсгэгч хэлбэрээр явагддаг байна.

Хоёр. Дүгнэлт

Бидний явуулсан судалгааны үр дүнгээс үзэхэд ажлын онцлогоос хамааран *“...байгууллагын удирдлагын арга барил, хамт олны таагүй уур амьсгал, ажлын орчноос гадна хариуцсан ажил, чиг үүрэг нь алба хаагчдын хүсэл эрмэлзэл, сонирхолтой нийцдэггүй, ажлын ачаалал их, алба хаагчдад хоригдлын зүгээс үзүүлэх харилцааны болон сэтгэл зүйн дарамт...”* зэргээс алба хаагчдын ажлаас халшрах хам шинжийн түвшин нэмэгдсээр байгаа гэж үзэж болохоор байна.

Түүнчлэн байгууллагын хэрэгжүүлж буй чиг үүрэг, удирдлагаас хамаарсан *“...сэтгэл зүйн тулгамдсан асуудалд орох, түүнээсээ ангижрах арга барил, мэдлэг дутмаг байдал...”* болон *“...тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын алба хаагчдын сэтгэл зүйн бэлтгэлжилт хангалтгүй хэмжээнд байгаа...”* зэрэг нь ажлаас халшрах хам шинжийн түвшнийг нэмэгдүүлж буй гол хүчин зүйлс болж байна.

Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын хэмжээнд *“...алба хаагчид албандаа хандах дур сонирхол буурсан, ажлаас халширах хам шинжийн түвшин өндөр үзүүлэлттэй гарсан нь...”* бодлогын хэмжээнд алба хаагчдын сэтгэл зүйн байдалд зайлшгүй анхаарал хандуулж, Монгол Улсын хууль тогтоох байгууллага болон засгийн газар, агентлагийн хэмжээнд шат дараатай арга хэмжээ авч хэрэгжүүлэх цаг үеийн шаардлага бий болсныг илтгэн харуулж байна.

Гурав. Санал

Судлаачийн зүгээс төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын алба хаагчдын сэтгэл зүйн байдалд тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хүрээнд дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын хэмжээнд алба хаагчдад сэтгэл зүйн зөвлөгөө, тусламж дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий сэтгэл судлаач, сэтгэцийн эмч мэргэжлээр гадаад, дотоодын их дээд сургууль төгссөн мэргэжилтнүүдийн бүрэлдэхүүнтэй сэтгэл зүйн тусгай нэгж байгуулах;

2. Дотоод хэргийн их сургуулийн Хилийн албаны сургуулийн сургалтын хөтөлбөрт ерөнхий сэтгэл судлалын хичээлээс гадна хуулийн сэтгэл судлал, гэмт хэрэгтний сэтгэл зүй, алба хаагчийн сэтгэл зүйн онцлогийн талаар түлхүү тусгаж, ажлын сэтгэл зүйн бэлтгэлжилтийг хангаж, сэтгэл зүйн анхны тусламж үзүүлэх мэдлэг олгох;

3. Удирдах албан тушаалтны хуучинсаг арга барилыг халах, удирдлагын зөв хандлагыг төлөвшүүлэх, удирдлагын арга барилд сэтгэл зүйн төрөл бүрийн арга, аргачлалыг хэрэглэх,

4. Алба хаагчдын мэдлэг, ур чадвар, ажлыг шударгаар үнэлэх, сэтгэл зүйн хувийн онцлогийг харгалзан албан тушаал дэвшүүлэх, бууруулах, шударга зарчимд суурилсан албаны итгэл, үнэмшлийг сэргээх ажлын орчныг бүрдүүлэх.

5. Судлагдсан зарим хүчин зүйлийг дэлгэрүүлэн судлан шинжилж, багц судалгаа хийн үр дүнг бусад шатны байгууллагад уламжлах.

Ашигласан эх сурвалж, материалын жагсаалт

Монгол хэл дээр:

Д.Эрдэнэчулуун Удирдахуйн сэтгэл судлал. УБ.,2016

Д. Мөнхцэцэг “Хуулийн сэтгэл судлал ба сэтгэл зүйн зөвлөгөө 2020 он

Э.Жамбалрагчаа. “Монгол улсын төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын залуу офицеруудын албандаа итгэх итгэл, үнэмшил, хүний нөөцийн асуудал”. “Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын залуу офицеруудад тулгамдаж буй асуудал” сэдэвт эрдэм

шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ., 2023. 68 дахь тал.

М.Хишигбаяр. “Монгол улсын төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын залуу офицеруудын ёс зүй, ёс суртахууны төлөвшлийн байдал”. “Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын залуу офицеруудад тулгамдаж буй асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ., 2023. 48 дахь тал.

П.Баярбаатар “Хорих ангийн алба хаагчдын ажлаас халшрах хам огноо (2023.10.12) шинжийг ажлын сэтгэл ханамжтай холбон судалсан нь” магистрын ажил. УБ., 2020. 52 дахь тал.

Орос хэл дээр:

Тематический философский словарь:Московский государственный университет имени М.В. Ломоносова. МОСКВА. 2009

1. Lewin, K. (1935). A dynamic theory of personality. New York: McGraw-Hill.

http://nrs.harvard.edu/urn-3:HUL.InstRepos:12274284 хандсан

МОНГОЛ УЛСЫН ХИЛ ХАЛДАШГҮЙ, ДАРХАН БАЙХ ЗАРЧИМ ҮНДСЭН ХУУЛИЙН СУУРЬ ОЙЛГОЛТ БОЛОХ НЬ

Х.АСХАР
ДХИС-ийн Хилийн албаны сургуулийн Хилийн боомтын аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх албаны тэнхимийн профессор, доктор (Ph.D), хурандаа
Емайл хаяг: askarteacher269@gmail.com

Хураангуй: Энэхүү өгүүлэлд Монгол Улсын хил халдашгүй, дархан байх зарчмыг олон улсын эрх зүйн үндэслэл, Үндсэн хуулийн суурь ойлголт, үндэсний аюулгүй байдал, орчин цагийн сорилт, бусад орны туршлагатай харьцуулан шинжлэх зорилгыг агуулсан болно. Энэ нь онол болон практикийн судалгааны нэг хэсэг болох ач холбогдолтой бөгөөд Монгол Улсын ирээдүйн хөгжил, тусгаар тогтнолын баталгаанд чухал хувь нэмэр оруулах юм. Судалгааны ажилд онолын болон харьцуулсан судалгааг түлхүү ашиглаж, суурь ойлголтуудыг тайлбарлах, эмпирик судалгааны зарим аргыг ашигласан болно. Ялангуяа олон улсын харилцаа, эрх зүй, хил судлалын салбарын эрдэмтэн, судлаачдын бүтээлээс түлхүү судалж, ойлголтуудыг тодорхой болгох, олон улсын туршлагаас гадаадын зарим улсыг сонгон авч, туршлага, сургамж болохуйц асуудлыг хөндөхийг эрмэлзсэн болно. Дэлхийн улс орнуудын аюулгүй байдлын чухал үндэс суурь нь улсын хилийн халдашгүй байдлын зарчим юм. Үүнд одоо байгаа хилийг олон улсын эрх зүйн дагуу хууль ёсоор тогтоосон гэж хүлээн зөвшөөрөх асуудал ордог. Улсын хилийн халдашгүй дархан байх гэсэн суурь зарчмыг 1975 онд Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны бага хурлаар "Оролцогч улсууд бие биеийнхээ бүх хил, түүнчлэн улсын хилийг халдашгүй" гэж тунхаглаж байжээ.

Abstract: This article aims to examine the principle of Mongolia's border inviolability and integrity through the lens of international legal foundations, constitutional doctrine, national security, contemporary challenges, and comparative experiences from other countries. It holds significance as part of both theoretical and practical research, contributing meaningfully to Mongolia's future development and the assurance of its sovereignty.

The study primarily employs theoretical and comparative legal research methods to interpret foundational concepts, supplemented by selected empirical approaches. In particular, it draws extensively from the works of scholars and researchers in international relations, law, and border studies to clarify key ideas. The research also seeks to analyze relevant international experiences by selecting specific countries whose practices and lessons may offer valuable insights.

The principle of border inviolability is a fundamental pillar of national security for countries around the world. It includes the recognition of existing borders as legally established under international law. Notably, this principle was affirmed at the 1975 Conference on Security and Cooperation in Europe, where participating states declared that "all borders, as well as national frontiers, shall be inviolable."

Түлхүүр үгс: улсын хил, халдашгүй дархан, сорилт, хил хамгаалалт
Keywords: state border, inviolability, challenge, border protection

Удиртгал

Дэлхийн улс орон бүр зэргэлдээ улстайгаа газрын гадаргуу, далай, тэнгисийн мандал, тэдгээрийн хэвлий болон агаарын орон зайд тодорхой шугамаар хязгаарладаг бөгөөд нэг улсыг хөрш зэргэлдээ улсаас нь зааглаж байгаа энэ тодорхой шугамыг тухайн улсын "Улсын хил" гэж олон улсын хэмжээнд нэрлэдэг байна.

"Улс" түүний "Хил" гэсэн ойлголт нь нийгэм, улс төрийн агуулга бүхий тогтолцооны илэрхийлэл, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, тусгаар тогтнол, аюулгүй байдал зэрэг улсыг бүрдүүлэгч оршин тогтнохуйн элементүүдтэй хамаарал бүхий шинжүүдийг агуулна.

"Улсын хил" гэдэг ойлголт нь философи, социологи, улс төр, цэргийн, хилийн зэрэг шинжлэх ухааны олон салбаруудад хамаарал бүхий ухагдахуун юм. Энэ агуулгаараа улсын хил нь тухайн улсын анхдагч субъект болох төрийн засаглал, хууль тогтоомж үйлчлэх нутаг дэвсгэрийн хүрээ, бодлого, үйл ажиллагаа явуулах орон зайн хязгаарыг тодорхойлно.

Улсын хилийг хил залгаа хоёр улс олон улсын гэрээ, хэлэлцээрийн үндсэн дээр тогтоох бөгөөд, түүний холбогдох баримт бичгийг НҮБ-д бүртгүүлэх нь аливаа үүсэж болох хилийн асуудал, хилийн маргаан нь олон улсын хяналтад байж, тэдний оролцоотойгоор олон улсын эрх зүйн хэм хэмжээнд шийдвэрлэгдэх боломжийг олгодог эрх зүйн зохицуулалт мөн.

"Монгол Улсын хил халдашгүй, дархан" (Үндсэн хууль, 1992) байх зарчим нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын баталгаа бөгөөд Үндсэн хуульт ёсны суурь ойлголтын нэг хэсэг юм. Энэхүү суурь зарчим нь зөвхөн хууль эрх зүйн хүрээнд хязгаарлагдахгүй, улс-төр, эдийн засаг, нийгэм, соёлын бүхий л салбарт шууд болон шууд бусаар нөлөөлдөг (С.Энхсайхан, 2015) байна. Улсын улсын хил халдашгүй дархан байх нь хүний эрх чөлөө, төрийн бүрэн эрхт байдал, үндэсний аюулгүй байдлыг хамгаалах үндсэн нөхцөл болж ирсэн (Д.Батсүх, 2018).

Түүхэн хөгжлийг авч үзвэл, хил хязгаарын асуудал нь улс орны оршин тогтнох эсэхийг шийдвэрлэж байсан олон чухал үе шаттай холбогддог (Sneath, 2003). XIII зууны Их Монгол Улсын үед эзэнт гүрний хил хязгаар өргөжин тэлж, Евроазийн өргөн уудам нутгийг хамарч байсан (Weatherford, 2004) нь түүхэнд тэмдэглэгдэн үлдсэн байдаг. Харин XVII–XX зууны эхэн үед Монгол Улс Манж Чин улсын эрхшээлд орсноор хил хязгаарын асуудал бүрхэг болж, Монголын тусгаар тогтнол алдагдсан (Narangoa & Cribb, 2004). Энэ нь хил хязгаарын баталгаагүй байдал улс орны тусгаар тогтнолд ямар аюултай болохыг харуулсан түүхэн тод жишээ юм.

Үндэсний эрх чөлөөний хувьсгал 1911 онд гарсны үр дүнд Монгол Улс тусгаар тогтнолоо сэргээсэн боловч олон улсын түвшинд бүрэн хүлээн зөвшөөрөгдөөгүй байсан (Batbayar, 2016) ба 1921 оны Ардын хувьсгалын дараа зөвлөлт орос (хуучин нэршлээр)-ын дэмжлэгтэйгээр Монгол Улс тусгаар тогтнолоо баталгаажуулж, улмаар 1945 оны "Ялт" хотноо болсон бага хурлын

шийдвэр, НҮБ-д элссэн үйл явцын үр дүнд олон улс Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрсөн (United Nations, 1945). Энэ бүх үйл явцад улсын хилийн асуудал байнга чухал байр суурь эзэлж байв (Bayarkhuu, 2019) гэж дурдагдсан байдаг.

Улмаар БНХАУ-тай 1962 онд, ЗХУ-тай 1977 онд байгуулсан хилийн гэрээнүүд нь Монгол Улсын өнөөгийн хил хязгаарыг албан ёсоор тогтоож, олон улсын эрх зүйн түвшинд баталгаажуулснаар (Ministry of Foreign Affairs of Mongolia, 2019) Монгол Улсын улсын хил халдашгүй дархан байх зарчмыг олон улсын хэмжээнд бүрэн хүлээн зөвшөөрүүлсэн чухал алхам болсон (National Security Council of Mongolia., 2010) гэж судлаач, шинжээчид үздэг.

Өнөөдөр улсын улсын хил халдашгүй дархан байх зарчим нь зөвхөн газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хамгаалахаас гадна үндэсний аюулгүй байдал, эдийн засгийн тогтвортой хөгжил, нийгмийн эв нэгдэл, соёлын дархлааг хамгаалах өргөн хүрээтэй ойлголт болжээ (Bold, 2017). Хил тогтвортой байх нь хөрш орнуудтай харилцах харилцаанд хамтын итгэлцлийг бий болгож, олон улсын хамтын ажиллагаанд оролцох суурь нөхцөл болдог (Lkhagvasuren, 2020) байна.

Үндсэн хэсэг

Олон улсын эрх зүйн онолын түвшинд энэхүү суурь зарчмыг дараах үндэслэлээр авч үздэг байна. Хил халдашгүй, дархан байх зарчим нь олон улсын эрх зүйн суурь ойлголтын нэг бөгөөд улс орнуудын бүрэн эрхт байдал, тусгаар тогтнолын баталгааг хангах үндсэн нөхцөл гэж үзэгддэг (United Nations General Assembly, Declaration on Principles of International Law concerning Friendly Relations and Co-operation among States, 1970). Энэхүү зарчим нь олон улсын гэрээ, конвенц, тунхаглал, шүүхийн практикт өргөн тусгагдсан байдаг (International Court of Justice, 1949). Эдгээр баримт бичгүүдэд агуулга хэрхэн тусгагдсаныг авч үзсэн болно. Үүнд:

1.1945 онд батлагдсан НҮБ-ын дүрэмд улс орнуудын бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн халдашгүй байдлыг хүндэтгэхийг заасан (United Nations, 1945). Тухайлбал, 2 дугаар зүйлийн 4-т “Улс орнуудын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улс төрийн тусгаар тогтнолд халдах аливаа заналхийлэл, хүч хэрэглэхийг хориглоно” гэж заасан. Энэ заалт нь улсын хил халдашгүй дархан байх зарчмын олон улсын эрх зүйн үндэс болж байна (United Nations General Assembly, 1994).

2.Найрсаг харилцааны тухай тунхаглал буюу 1970 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас баталсан “Улс орнуудын хоорондын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай тунхаглал”-д улсын хил халдашгүй дархан байх зарчмыг дахин баталгаажуулсан (United Nations General Assembly, Declaration on Principles of International Law concerning Friendly Relations and Co-operation among States, 1970). Ингэснээр улс орнуудын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хил хязгаарын халдашгүй байдлыг хүндэтгэх нь олон улсын энх тайван, аюулгүй байдлын үндэс гэж энэ баримт бичигт тодорхойлсон байна (Batbayar, 2016).

3. Хельсинкийн эцсийн акт. Энэхүү баримт бичиг нь 1975 онд батлагдсан бөгөөд Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын хүрээнд гарсан ч дэлхий нийтэд чухал ач холбогдолтой гэж үздэг (Organization for Security and Co-operation in Europe, 1975). Тус актад улс орнуудын хооронд тогтоосон хил хязгаарыг хүчээр өөрчлөхийг хориглож, энхийн замаар шийдвэрлэж байхаар тусгасан (Bayarkhuu, 2019). Энэ нь ямар ч улсын улсын хил халдашгүй дархан байх зарчмыг бүс нутгийн түвшинд баталгаажуулсан чухал баримт бичиг юм (Narangoa & Cribb, 2004).

4.Олон улсын шүүхийн практикт шүүгчдийн гаргаж байсан шийдвэрүүдэд улсын хил халдашгүй дархан байх зарчмыг харгалзан үздэг байдал тогтмол явагдаж ирсэн нь үүнийг баталгаажуулж байгааг харуулж байна (International Court of Justice, 1949). Жишээлбэл, Керфү сувгийн 1949 онд болсон хэрэгт Олон улсын шүүх улс орнуудын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдалд халдах аливаа үйлдлийг олон улсын эрх зүйн зөрчил гэж үзсэн

(Lkhagvasuren, 2020). Энэ нь улсын хил халдашгүй дархан байх зарчмыг олон улсын шүүхийн практикт баталгаажуулсан тод жишээ юм (Bat-Erdene, 2021).

5.Монгол Улс хөрш орнуудтайгаа хилийн асуудлыг олон улсын эрх зүйн дагуу гэрээ, хэлэлцээрээр шийдвэрлэсэн (Ministry of Foreign Affairs of Mongolia, 2019). Тухайлбал, Хилийн болон хилийн дэглэмийн гэрээ, хилийн боомтын асуудлаар байгуулсан хэлэлцээрүүд зэргийг дурдаж болно.

Монгол Улсын Үндсэн хууль дахь заалтын гол агуулга, мөн чанар

Монгол Улсын Үндсэн хууль нь тус улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын баталгаа бөгөөд улсын улсын хил халдашгүй дархан байх зарчмыг шууд тусгасан эрх зүйн суурь баримт бичиг юм (Монгол Улсын үндсэн хууль, 1992). Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлд "Монгол Улс бол тусгаар тогтносон, бүрэн эрхт, Бүгд найрамдах улс мөн" (1992) гэж заасан нь улсын улсын хил халдашгүй дархан байх зарчмын суурь ойлголт болно (Монгол Улсын Үндсэн хуулийн цэц, 2020). Энэ заалт нь Монгол Улс олон улсын харилцаанд бие даасан субъект болохыг баталгаажуулж, хил хязгаарын халдашгүй байдлыг хамгаалах эрх зүйн үндэс болж өгдөг (Д.Батсүх, 2018). Мөн хуулийн 2 дугаар зүйлд "Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байна" (Монгол Улсын Үндсэн хууль, 1992) гэж заасан нь нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хил хязгаарын халдашгүй байдлыг баталгаажуулдаг (С.Энхсайхан, 2015).

Үндсэн хуулийн 4 дүгээр зүйлд "Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хил хязгаар халдашгүй дархан байна" гэж тодорхой заасан нь энэ зарчмыг Үндсэн хуулийн түвшинд баталгаажуулсан хамгийн чухал заалт юм (Lkhagvasuren, 2020). Энэ нь зөвхөн хууль эрх зүйн баталгаа төдийгүй төрийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үндсэн чиглэл болж өгдөг (Bayarkhuu, 2019).

Үндсэн хуулийн цэцийн практикт улсын улсын хил халдашгүй дархан байх зарчимтай холбоотой маргааныг шийдвэрлэх бүрэн эрхтэй бөгөөд энэ нь эрх зүйн баталгааг улам бэхжүүлж байна (Монгол Улсын Үндсэн хуулийн цэц, 2020). Одоогоор улсын хилтэй холбоотой маргаан гараагүй ч Цэцийн шийдвэрүүдэд "төрийн бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн халдашгүй дархан байдал" гэсэн ойлголтыг тогтмол баримталж ирсэн нь энэ зарчмын эрх зүйн баталгааг улам тодотгож байна (Batbayar, 2016). Энэ зарчим нь ардчилал, хүний эрх, төрийн бүрэн эрхийн баталгаа болж, Монгол Улсын оршин тогтнох үндэс, ард түмний эрх чөлөөний баталгаа юм (Bayarkhuu, 2019). "Иймээс Үндсэн хуульд туссан улсын хил халдашгүй дархан байх зарчим нь зөвхөн хууль эрх зүйн ойлголт бус, ардчилал, хүний эрх, төрийн бүрэн эрхийн баталгаа болж байна" (Bold, 2017) гэж үзсэн байна.

Тэгэхээр улсын улсын хил халдашгүй дархан байх суурь

зарчмын хувьд үндэсний аюулгүй байдалд хэрхэн хамааралтайг харуулахыг зорилоо. Тэгэхээр Монгол Улсын үндэсний аюулгүй байдал нь улс орны тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нийгмийн тогтвортой хөгжил, иргэдийн эрх чөлөө, аюулгүй байдлыг хангах цогц ойлголт юм (National Security Council of Mongolia., 2010). Энэ хүрээнд улсын улсын хил халдашгүй дархан байх зарчим нь үндэсний аюулгүй байдлын хамгийн чухал тулгуур багана болж ирсэн (Д.Батсүх, 2018).

Цэрэг-стратегийн хувьд улсын хил хамгаалалт нь улсын батлан хамгаалах чадавхыг илэрхийлдэг бөгөөд Монгол Улс хоёр их гүрэнтэй хиллэдэг онцлогтой тул энэ асуудал онцгой ач холбогдолтой (Bat-Erdene, 2021) гэж үзжээ. Харин Д.Баярхүү гуай үзэхдээ улсын хил хамгаалалт нь зөвхөн цэрэг зэвсгийн асуудал бус, стратегийн тэнцвэр, хөрш орнуудтай харилцах бодлогын үндэс болдог (2019) гэж арай өөр өнцгөөс нь тайлбарласан байна.

Эдийн засгийн хувьд улсын хил тогтвортой байх нь худалдаа, тээвэр, хөрөнгө оруулалтын урсгалыг баталгаажуулдаг (Batbayar, 2016). Монгол Улсын экспорт, импортын бүхий л урсгал хилийн боомтоор дамжин өнгөрдөг тул улсын хил тогтвортой, найдвартай, хамгаалалттай байх нь эдийн засгийн аюулгүй байдалд шууд нөлөөлдөг (Lkhagvasuren, 2020). Хэрэв хил тогтворгүй байвал эдийн засгийн аюулгүй байдалд ноцтой эрсдэл учирна (С.Энхсайхан, 2015).

Нийгэм-соёлын хувьд улсын хил нь үндэсний эв нэгдэл, соёлын дархлааг хамгаалдаг (Bold, 2017). Улсын хил тогтвортой байх нь ард иргэдийн дунд эх оронч үзлийг төлөвшүүлж, үндэсний бахархлыг бэхжүүлдэг (Narangoa & Cribb, 2004). Мөн түүнчлэн хил орчмын бүс нутгийн хөгжил, оршин суугчдын амьдралын чанарт шууд нөлөөлдөг (Weatherford, 2004) болохыг бүтээлдээ дурдсан байна.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “Монгол Улсын газар нутгийн бүрэн бүтэн байдал, хил хязгаарын халдашгүй дархан байдлыг хангах нь төрийн оршин тогтнох үндэс” гэж тодорхойлсон байдаг (National Security Council of Mongolia., 2010). Энэ нь улсын улсын хил халдашгүй дархан байх зарчим нь зөвхөн хууль эрх зүйн төдийгүй төрийн бодлогын түвшинд баталгаажсан болохыг харуулдаг (Д.Батсүх, 2018).

Иймээс улсын хил халдашгүй дархан байх зарчим нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын баталгаа мөн бөгөөд улс орны оршин тогтнох, хөгжих үндэс юм (Bayarkhuu, 2019) гэж хэлсэн нь үндэслэлтэй юм. Энэ зарчим нь цэрэг, эдийн засаг, нийгэм-соёлын бүх салбарт нөлөөлж, Монгол Улсын тусгаар тогтнолын баталгааг хангаж байна (Bat-Erdene, 2021).

Тэгвэл улсын хилийн халдашгүй байдалд үүсэж буй сорилтууд ба цаашдын хөгжлийн чиг хандлага ямар байхыг авч үзье. XXI зуунд улсын хил дээр улам бүр шинэ сорилтуудтай тулгарч байна (Bat-Erdene, 2021). Тухайлбал, олон улсад өрнөж буй глобалчлал, бүс

нутгийн интеграци, технологийн хөгжил, геополитикийн өрсөлдөөн зэрэг хүчин зүйлс нь улсын хил хамгаалалтын уламжлалт ойлголтыг шинэ шатанд гаргаж байна (Bayarkhuu, 2019) гэж эрдэмтэн, судлаачид олонтоо ярих болжээ. Ямар агуулгын хүрээнд яригдах болов гэсэн асуулт урган гарч байна. Олон улсад улсын хил дээр гарч буй зөрчил, гэмт хэрэг, үүсэж буй нөхцөл байдал зэргээс хамааран дараах сорилтууд хэдийнээ бий болжээ. Үүнд:

1. Хууль бус цагаачлал ба хил дамнасан гэмт хэрэг

Сүүлийн жилүүдэд хууль бус цагаачлал, хар тамхи, зэвсгийн хууль бус наймаа, хүний наймаа зэрэг хил дамнасан гэмт хэрэг нэмэгдэж байна (Batbayar, 2016). Энэ нь зөвхөн Монгол Улсын аюулгүй байдалд бус, бүс нутгийн тогтвортой байдалд ч заналхийлж байна (Д.Батсүх, 2018). Иймээс хил хамгаалалтын байгууллагын чадавхыг нэмэгдүүлэх, олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх шаардлагатай (United Nations, 1945) гэж үзэх болсон.

2. Байгаль орчин буюу дэлхийн экологийн тэнцвэрт байдал алдагдаж, түүнтэй холбоотой үүссэн шинэ сорилт

Хил дамнасан гол мөрөн, усны нөөц, байгалийн баялгийн ашиглалт нь орчин цагийн шинэ сорилт болж байна (Narangoa & Cribb, 2004). Зарим улс орнуудад ундны усны хомсдол, уур амьсгалын өөрчлөлт нь хил орчмын бүс нутгийн тогтвортой хөгжилд нөлөөлж, улмаар улс хоорондын харилцаанд зөрчил үүсгэх (Weatherford, 2004) эрсдэлийг дагуулж байна.

3. Улс орнуудын геополитикийн өрсөлдөөн

Монгол Улс хоёр их гүрний дунд оршдог геополитикийн онцлогтой (Bayarkhuu, 2019). Энэ нөхцөлд улсын улсын хил халдашгүй дархан байх зарчим нь зөвхөн дотоодын хууль эрх зүйн асуудал бус, олон улсын харилцааны тэнцвэрт байдлыг хадгалах чухал хүчин зүйл болдог (Batbayar, 2016). Хөрш орнуудын бодлогын өөрчлөлт, бүс нутгийн геополитикийн өрсөлдөөн нь Монгол Улсын хил хамгаалалтын бодлогод шууд болон шууд бусаар нөлөөлөх боломжтой юм.

4. Мэдээлэл, технологийн хөгжил ба улсын хил хамгаалалтад ашиглах боломж

Орчин цагийн хил хамгаалалт нь зөвхөн цэргийн хамгаалалтаар хязгаарлагдахгүй (Bold, 2017). Цахим технологи, хиймэл оюун ухаан, хяналтын систем, кибер аюулгүй байдал зэрэг шинэ хэрэгсэл, арга барилуудыг уламжлалт байдалтай хослуулан ашиглах зайлшгүй хэрэгцээ шаардлага бий болж байна. Энэ нь нэг талаасаа хил хамгаалалтын үр нөлөөг нэмэгдүүлэх, нөгөөтээгүүр үүнтэй зэрэгцээгээр шинэ төрлийн аюул заналхийллийг ч авчирч болзошгүйг үгүйсгэх аргагүй юм.

Ийм нөхцөлд үүсэж буй сорилтуудаас хамааран цаашдын хөгжлийн чиг хандлага ямар байх вэ? Эрдэмтэн, судлаачид өөр өөрийн байр суууриа илэрхийлсэн байдаг. Тэдний зүгээс үүнийг тодорхойлж авч үзэхдээ ирээдүйд

Монгол Улсын хил хамгаалалтын бодлого дээр дурдсан үүсэж буй сорилтуудад чиглэж хөгжих шаардлагатай бөгөөд хөрш орнуудтайгаа хамтын ажиллагааг өргөжүүлэх (Ministry of Foreign Affairs of Mongolia, 2019), хил хамгаалалтын дэд бүтцийг шинэчлэх, технологийн дэвшлийг ашиглах (Lkhagvasuren, 2020), хил орчмын бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих (С.Энхсайхан, 2015), олон улсын байгууллагуудтай хамтран хил дамнасан асуудлыг шийдвэрлэх зэргээр бодлогын түвшинд өөрчлөлт, шинэчлэлтийг зайлшгүй хийх шаардлагатай.

Иймээс дээр дурдагдсан сорилтуудыг даван туулахын тулд Монгол Улс хил хамгаалалтын бодлогоо шинэ шатанд гаргах шаардлагатай бөгөөд энэ нь манай улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлын баталгаа юм (2018) гэж Д.Батсүх бүтээлдээ дурдсан байдаг.

Энэхүү судалгааны ажлын хүрээнд бид олон улсын туршлагаас судалж, үр дүнг товч хэлбэрээр тусгахыг оролдсон. Улсын хил халдашгүй, дархан байх зарчмыг хэрэгжүүлэх нь улс орон бүрийн түүхэн нөхцөл, геополитикийн байр суурь, хууль эрх зүйн тогтолцооноос хамааран өөр өөр хэлбэртэй байдаг (Narangoa & Cribb, 2004)-ыг судлаачид онцлон дурдсан байна. Монгол Улсын хувьд энэхүү зарчмыг хэрэгжүүлэхэд хоёр их гүрний дунд орших геополитикийн онцлогоос шалтгаалан онцгой ач холбогдолтой. Бусад орны туршлагыг авч үзэх нь Монгол Улсын бодлогыг улам боловсронгуй болгоход чухал сургамж өгдөг (Batbayar, 2016).

1. Швейцар улсын туршлага

Швейцар улс олон зууны турш төвийг сахисан бодлого баримталж ирсэн бөгөөд энэ нь улсын хил халдашгүй дархан байх зарчмыг баталгаажуулахад чухал нөлөө үзүүлсэн (Weatherford, 2004). 1815 оны Венын конгрессоор Швейцарын төвийг сахисан статус олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн бөгөөд түүнээс хойш тус улс дайн, зөрчилдөөнд оролцоогүй (United Nations General Assembly, 1970). Хилээ хамгаалахдаа зөвхөн цэрэг зэвсгийн хүчээр бус, дипломат харилцаа, олон улсын гэрээ хэлэлцээрээр баталгаажуулсан нь онцлог (Bayarkhuu, 2019).

2. Финлянд улсын туршлага

Финлянд улс Зөвлөлт Холбоот Улстай хиллэдэг онцлогтой байсан бөгөөд энэ нөхцөлд хил халдашгүй байдлаа хадгалахын тулд “Финляндын загвар” хэмээх тэнцвэртэй гадаад бодлого хэрэгжүүлсэн (Batbayar, 2016). Энэ нь нэг талаас ЗХУ-тай найрсаг харилцаа тогтоож, нөгөө талаас барууны орнуудтай эдийн засаг, соёлын харилцаагаа өргөжүүлэх бодлого байв (United Nations, 1945). Ингэснээр Финлянд улс хилээ тогтвортой байлгаж, тусгаар тогтнолоо хадгалж чадсан (Narangoa & Cribb, 2004).

3. БНКазУ-ын туршлага

БНКазУ ЗХУ задран унасны дараа тусгаар тогтнолоо сэргээж, хөрш орнуудтайгаа хилийн асуудлыг энхийн замаар

шийдвэрлэх бодлого баримталсан гэж судлаачид үздэг. Тус улс ОХУ, Хятад, Төв Азийн бусад орнуудтайгаа хилийн гэрээ байгуулж, хилээ олон улсын эрх зүйн дагуу баталгаажуулсан. Энэ нь Казахстаны нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, үндэсний аюулгүй байдлын баталгаа болсон (2021) гэж Ж.Бат-Эрдэнэ дурдсан байна.

Эдгээр орны туршлагаас харахад улсын хил халдашгүй дархан байх зарчмыг баталгаажуулахад дараах нийтлэг туршлага, сургамжууд харагдаж байна. Үүнд: улсын хил хамгаалалтыг зөвхөн цэрэг, зэвсгийн хүчээр бус, олон улсын гэрээ, улс-төр, дипломат харилцаагаар баталгаажуулах, хөрш орнуудтайгаа харилцан ашигтай хамтын ажиллагаа өрнүүлэх замаар улсын хилийн тогтвортой байдлыг хангах, үндэсний хууль эрх зүйн тогтолцоонд улсын хил халдашгүй дархан байх зарчмыг баталгаажуулж, төрийн бодлогын түвшинд хэрэгжүүлэх зэрэг болно.

Монгол Улсын үндэсний хууль эрх зүйн актуудад энэ ойлголтыг дараах байдлаар тусгагдсан байдаг. Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хамгаалах нь Монгол Улсын язгуур эрх ашигт багтдаг бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хил халдашгүй дархан байна” (Монгол Улсын үндсэн хууль, 1992); Монгол Улсын хилийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2-д “Улсын хил халдашгүй дархан байна.”, мөн хуулийн 31.1-д “Улсын хил хамгаалалт нь үндэсний аюулгүй байдлыг хангах арга хэмжээний салшгүй хэсэг мөн” (Монгол Улсын хилийн тухай хууль, 2016) гэж тус тус хуульчилсан. БНХАУ болон ОХУ-тай байгуулсан хилийн болон хилийн дэглэмийн гэрээгээр улсын хилийг хамтран хамгаалах, харилцан хүндэтгэх асуудлыг тусгасан байдаг. Нутаг дэвсгэр, улсын хилийн халдашгүй байдлын тухай олон улсын эрх зүйн зарчмыг баримтална. Монгол Улсын олон улсын гэрээнд Монгол Улсын хилийн тухай хууль тогтоомжид зааснаас өөр журам тогтоосон нь Үндсэн хуульд харшлаагүй бол олон улсын гэрээний заалтыг баримтална. Хил хамгаалах байгууллага нь Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах, Монгол Улсын хилийн хууль тогтоомж, хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээг хэрэгжүүлэх, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох зорилгоор улсын хилийн зурвас, боомтын бүс, хил орчмын нутаг дэвсгэрт улсын хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах, зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх, цэргийн, инженер-техникийн, мэдээлэл технологийн, тагнуулын, хилийн төлөөлөгчийн арга хэмжээг хослуулан явуулдаг онцлогтой. Төрөөс хилийн талаар баримтлах бодлогын баримт бичигт “Улсын хилийн халдашгүй дархан байдал: Хилийн шугам хууль бусаар өөрчлөгдөөгүй, хилийн асуудлаар байгуулсан Монгол

Улсын олон улсын гэрээ, хэлэлцээр зөрчихгүй байх явдлаар хангагдана” гэж тусгасан нь Улсын хил хамгаалах чиг үүрэг бүхий мэргэжлийн байгууллага, хилчдийн гүйцэтгэх үндсэн үүргийг тодорхой болгосон юм. Энэхүү үүргийг биелүүлэхдээ олон улсын хилийн асуудлаар байгуулсан эрх зүйн акт, ОХУ, БНХАУ-тай байгуулсан хилийн гэрээ, хилийн дэглэмийн гэрээ, “Нэг хил-Хоёр улс, Найрсаг хөршийн зарчим”-г чанд баримтлан “Улсын хил халдашгүй дархан байх” суурь зарчмыг бүрэн хангах нөхцөл бүрдүүлэхэд чиглэгдсэн байна.

Дүгнэлт, санал

Монгол Улсын хил халдашгүй, дархан байх зарчим нь тус улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын баталгаа бөгөөд Үндсэн хуульт ёсны суурь ойлголттой нягт уялддаг болох нь илтгэлд дурдсан баримтууд, олон улсын туршлагаас харж болохоор байна. Энэ зарчим нь олон улсын эрх зүйн баримт бичгүүдэд баталгаажсан бөгөөд Монгол Улсын Үндсэн хуульд шууд тусгагдсан нь түүний эрх зүйн баталгааг улам бэхжүүлж байна.

Улсын хил халдашгүй дархан байх зарчим нь зөвхөн газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хамгаалахаас гадна ардчилал, хүний эрх, төрийн бүрэн эрхийн баталгаа болж байна (С.Энхсайхан, 2015). Энэ нь Монгол Улсын оршин тогтнох үндэс, ард түмний эрх чөлөөний баталгаа юм (Д.Батсүх, 2018). Үндсэн хуулийн цэцийн практикт ч энэ зарчим тогтмол баримтлагдаж ирсэн нь эрх зүйн баталгааг улам тодотгож байна (Монгол Улсын Үндсэн хуулийн цэц, 2020).

Олон улсын эрх зүйн түвшинд улсын хил халдашгүй дархан байх зарчим нь НҮБ-ын дүрэм, Хельсинкийн эцсийн акт, Найрсаг харилцааны тухай тунхаглал зэрэг баримт бичгүүдэд тусгагдсан. Энэ нь улс орнуудын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хил хязгаарын халдашгүй байдлыг хүндэтгэх нь олон улсын энх тайван, аюулгүй байдлын үндэс гэдгийг нотолж байна.

Монгол Улс хөрш орнуудтайгаа байгуулсан хилийн гэрээнүүдээр хилээ олон улсын түвшинд баталгаажуулсан нь тус улсын тусгаар тогтнолын баталгаа болсон. Энэ нь Монгол Улсын гадаад бодлогын чухал амжилт бөгөөд улсын хил халдашгүй дархан байх зарчмыг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрүүлсэн алхам юм (Bayarkhuu, 2019).

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд улсын хил халдашгүй дархан байх зарчим нь төрийн оршин тогтнох үндэс гэж тодорхойлогдсон (National Security Council of Mongolia., 2010). Энэ нь цэрэг-стратегийн, эдийн засгийн, нийгэм-соёлын бүх салбарт нөлөөлж, Монгол Улсын тусгаар тогтнолын баталгааг хангаж байна (Bold, 2017). Хил тогтвортой байх нь худалдаа, тээвэр, хөрөнгө оруулалтын урсгалыг баталгаажуулж, эдийн засгийн аюулгүй байдлыг хамгаалдаг (Batbayar, 2016).

Өнөөгийн нөхцөлд үүсэж буй шинэ сорилтууд нь улсын хил

халдашгүй дархан байх зарчмыг шинэ нөхцөлд хэрэгжүүлэх шаардлагыг бий болгож байна (Bat-Erdene, 2021). Хууль бус цагаачлал, хил дамнасан гэмт хэрэг, байгаль орчны доройтол, геополитикийн өрсөлдөөн зэрэг нь Монгол Улсын хил хамгаалалтын бодлогод шинэ сорилт болж байна (Narangoa & Cribb, 2004). Технологийн хөгжил нь хил хамгаалалтыг шинэ шатанд гаргаж байгаа ч кибер аюулгүй байдлын эрсдэл дагуулж байна (Lkhagvasuren, 2020).

Бусад орны туршлагаас харахад хилийн халдашгүй байдлыг баталгаажуулахад дипломат харилцаа, олон улсын гэрээ, тэнцвэртэй гадаад бодлого чухал болох нь харагдаж байна (Weatherford, 2004). Швейцарын төвийг сахисан бодлого, Финляндын тэнцвэртэй гадаад бодлого, Казахстаны энхийн замаар хилийн асуудлыг шийдвэрлэсэн туршлага нь Монгол Улсад сургамж болох юм (United Nations General Assembly, 1994).

Цаашид Монгол Улс “улсын хил халдашгүй дархан байх суурь” зарчмыг хангахын тулд хөрш орнуудтайгаа байгуулсан хилийн гэрээг чанд мөрдөх, хил хамгаалах байгууллагын чадавхыг нэмэгдүүлэх, технологийн дэвшлийг ашиглах, хил орчмын бүс нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжих, олон улсын байгууллагуудтай хамтран хил дамнасан асуудлыг шийдвэрлэх шаардлагатай.

Төгсгөлд нь Монгол Улсын хил халдашгүй, дархан байх зарчим нь ард түмний тусгаар тогтнолын баталгаа, төрийн бүрэн эрхийн үндэс, үндэсний аюулгүй байдлын тулгуур юм. Энэ зарчмыг эрх зүйн болон бодлогын түвшинд тууштай хэрэгжүүлж чадвал Монгол Улс ирээдүйд ч тусгаар тогтнолоо баталгаатай хадгалж, дэлхийн хамтын нийгэмлэгийн дунд нэр хүндтэй байр суууриа хадгалсаар байх болно гэж судлаачийн зүгээс үзэж байна.

Эх сурвалж

Batbayar, T. (2016). Mongolia's Foriegn Policy: Ensuring Sovereignty between Russia and China. In T. Batbayar, *Asian Survey* (pp. 344-367).

Bat-Erdene, J. (2021). Border Security Challenges in Mongolia: A Contemporary Analysis. *Mongolian Journal of Political Science*, 18(1), 77–95.

Bayarkhuu, D. (2019). *Geopolitics of Mongolia: Between Russia and China.* Ulaanbaatar: Nepko Pulishing.

Bold, B. (2017). *Mongolia's Security and Border Policy in the 21st Century.* Ulaanbaatar: Academy of Sciences Press.

International Court of Justice. (1949). *Corfu Channel Case (United Kingdom v. Albania).* ICJ Reports.

Lkhagvasuren, G. (2020). Territorial Integrity and Constitutionalism in Mongolia. *Journal of Asian Legal Studies*, 45-62.

Ministry of Foreign Affairs of Mongolia. (2019). *Foreign Policy Concept of Mongolia.* Ulaanbaatar: MFA.

Narangoa & Cribb, R. (2004). *Imperial Japan and National*

Identities in Asia, 1895-1945. Ulaanbaatar: NSC.

National Security Council of Mongolia. (2010). *National Security Concept of Mongolia.* Ulaanbaatar: NSC.

Organization for Security and Co-operation in Europe. (1975). *Helsinki Final Act.* Retrieved from OSCE : Archives. https://www.osce.org/helsinki-final-act

Sneath, D. (2003). *Mongolia in the Twentieth Century: Landlocked Cosmopolitan.* Routledge Curzon.

United Nations. (1945). *Charter of the United Nations*. Retrieved from Charter of the United Nations: https://www.un.org/en/about-us/un-charter

United Nations General Assembly. (1970). *Declaration on Principles of International Law concerning Friendly Relations and Co-operation among States.* USA: United Nations.

United Nations General Assembly. (1994). *UN Documents.* Retrieved from Declaration on the Protection of States and Their Security: https://legal.un.org/ilc/texts/instruments/english/draft_articles/2_1_1949.pdf

Weatherford, J. (2004). *Genghis Khan and Making of the Modern World.* Crown.

Д.Батсүх. (2018). *Монгол Улсын үндэсний аюулгүй байдал ба хил хамгаалалт.* Улаанбаатар: МУИС-ийн хэвлэх үйлдвэр.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц. (2020). *Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар*. Retrieved from https://www.constitutionalcourt.mn

Монгол Улсын Үндсэн хууль. (1992). *Үндсэн хууль*. Retrieved from Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: legalinfo.mn

Монгол Улсын үндсэн хууль. (1992). *Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем*. Retrieved from Үндсэн хууль: https://legalinfo.mn/mn/detail?lawId=367

С.Энхсайхан. (2015). *Монгол Улсын гадаад бодлого ба хил хамгаалалтын асуудал.* Улаанбаатар: Адмон ХХК хэвлэх үйлдвэр.

ХИЛ ОРЧМЫН НУТАГ ДЭВСГЭРТ ҮЙЛДЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГТ МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ОНЦЛОГ

Н.САЙНБАЯР
ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн процессын эрх зүйн тэнхимийн дэд профессор, хууль зүйн доктор, цагдаагийн хошууч
Sainbayar.n@uia.gov.mn

Хураангуй: Төрийн гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийн салшгүй шинж нь шуурхай байдлыг хангахад оршино. Ингэснээр бусдын зөрчигдсөн эрхийг сэргээх боломжтой болох юм. Энэ талаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод ч тодорхой зааж өгсөн.

Үйлдэгдсэн гэмт хэргийг шуурхай илрүүлэхэд мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий байгууллагуудын бэлэн байдал, хүний нөөцийн хүртээмж мэдээж чухал үүрэг гүйцэтгэнэ.

Монгол Улсын хэмжээнд гэмт хэрэг бүртгэгдсэн даруйд цагдаагийн байгууллагаас хойшлуулшгүйгээр мөрдөх ажиллагаа явуулах хуулийн зохицуулалттай ч тэр бүр түргэн шуурхай ажиллах боломж нь гадаад хүчин зүйлийн нөлөөллөөр хангагдаад байдаггүй. Энэ тохиолдолд зарим орчин нөхцөлд үйлдэгдсэн гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагааг хойшлуулшгүйгээр явуулах бусад байгууллагын боломжийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан. Гэвч энэ хуулийн заалт практикт ямар ч хэрэгжилтгүй байгаа нь хил орчмын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэргийг илрүүлэлт, шийдвэрлэлтэд хүндрэл бэрхшээл үүсгэж байгаа тул хойшлуулшгүйгээр мөрдөн шалгах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг судалсны үндсэн дээр тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, шийдлийг эрэлхийлсэн.

Түлхүүр үгс: хил орчмын нутаг дэвсгэр, хилийн зөрчил, хил дээрх гэмт хэрэг.

ҮНДСЭН ХЭСЭГ:

Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна[15] хэмээгээд энэхүү чиг үүргээ хэрэгжүүлэхийн тулд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтыг "…*гэмт хэргийг шуурхай*, бүрэн илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон шударгаар ял оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах,

[15] Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг.

зөрчигдсөн эрхийг сэргээхэд оршино”[16] гэж тодорхойлсон.

Үүнээс гэмт хэрэгтэй тэмцэх бүхий л үйл ажиллагаа шуурхай байх нь бусад зорилтыг хангах үндэс нь юм. Аливаа гэмт хэрэг үйлдэгдсэн хугацаа өнгөрөх тусам түүнийг илрүүлэх боломж тэр хэрээр буурч байдаг онцлогтой. Тиймээс бүртгэгдсэн гэмт хэрэгт төрийн зүгээс шуурхай арга хэмжээ авах нь олон талын ач холбогдолтой юм.

Гэмт хэрэг бүртгэгдсэн даруйд мөрдөгч хэргийн газарт очиж ажиллах хууль зүйн зохицуулалттай. Гэсэн хэдий ч зарим төрлийн нөхцөл байдалд цагдаагийн байгууллагын мөрдөгч тэр бүр шуурхай очиж ажиллах боломж хомс тул тэрхүү онцлогийг харгалзан тодорхой чиглэлийн төрийн алба хаагчдад хойшлуулшгүйгээр мөрдөн шалгах ажиллагаа явуулах боломжийг хуулиар нээж өгсөн. Тодруулбал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 30.7 дугаар зүйлийн 2 дах хэсэгт хойшлуулшгүйгээр мөрдөн шалгах ажиллагаа явуулах боломжит субъектүүдийг заасан. Үүнд:

1.гомдол, мэдээллийг шалгах явцад гэмт хэрэг үйлдэж байгаа болон үйлдсэн тухай үндэслэлтэй сэжиг байгаа тохиолдолд мөрдөгч, тагнуул, цагдаа, авлигатай тэмцэх байгууллагын алба хаагч;

2.Монгол Улсын хилийн гадна байгаа тус улсын усан онгоц, агаарын хөлөг аялж яваа үед гарсан гэмт хэрэгт усан онгоцны ахмад, агаарын хөлгийн багийн дарга;

3.Монгол Улсаас гадаад улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газрын эзэмшил нутагт гарсан гэмт хэрэгт тухайн Дипломат төлөөлөгчийн газрын консулын асуудал эрхэлсэн ажилтан;

4.хорих ангийн харьяа нутаг дэвсгэрт хоригдлын үйлдсэн гэмт хэрэгт хорих байгууллагын эрх бүхий албан тушаалтан;

5.зэвсэгт хүчний анги, байгууллагын нутаг дэвсгэрт цэргийн алба хаагчийн үйлдсэн гэмт хэрэгт тухайн зэвсэгт хүчний анги, байгууллагын захирагч;

6.хилийн зурваст гарсан гэмт хэрэгт улсын хил хамгаалах байгууллагын эрх бүхий албан тушаалтан;

7.цэргийн алба хаагч энхийг дэмжих, олон улсын бусад ажиллагаанд оролцох явцад тэдний хооронд үйлдсэн гэмт хэрэгт тухайн цэргийн багийн эрх бүхий албан тушаалтан;

8.гаалийн хяналт, шалгалтын явцад илэрсэн гэмт хэрэгт гаалийн улсын байцаагч зэрэг болно.

Хил хамгаалах байгууллагын алба хаагч мөрдөх ажиллагаа явуулж буй туршлага нь дан ганц манай улсад төдийгүй төв азийн дийлэнх улсуудад хил хамгаалах байгууллагын алба хаагчид харьяалах хэрэг

[16] Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг.

бүртгэлтийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулдаг аж. Тухайлбал, ОХУ-ын Эрүүгийн процессын хуульд урьдчилсан мөрдөн шалгах ажиллагааг Мөрдөн шалгах хороо (Следственный комитет), Холбооны аюулгүй байдлын алба (Федеральная служба безопасности), Дотоод хэргийн яам (Министерство внутренных дел)-ны мөрдөн байцаагч нар хэрэгжүүлдэг. Харин хэрэг бүртгэлтийн ажиллагааг Дотоод хэргийн яам, Хил хамгаалах алба, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, Гаалийн алба, Гал түймэртэй тэмцэх алба, Мөрдөн шалгах хороо зэрэг байгууллагууд хэрэгжүүлдэг.

Эрүүгийн процессын хуулийн[17] 38 дугаар зүйлд мөрдөн байцаагч гэх тодорхойлолт, эрх, үүргийн талаар тусгаж өгсөн. “Мөрдөн байцаагч” нь Эрүүгийн процессын хуульд заасан эрх хэмжээний хүрээнд эрүүгийн хэрэгт урьдчилсан мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий албан тушаалтныг хэлнэ гэж тодорхойлжээ.

Хилийн зурваст гарсан гэмт хэрэгт улсын хил хамгаалах байгууллагын эрх бүхий албан тушаалтан хойшлуулшгүйгээр мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх хэмжээтэй юм. Тэгэхээр хилийн зурваст гарсан аливаа гэмт хэрэгт хил хамгаалах байгууллагын эрх бүхий албан тушаалтан хойшлуулшгүйгээр мөрдөн шалгах ажиллагаа явуулж, улмаар харьяаллын дагуу материалыг прокурорын хяналтад шилжүүлэх ёстой гэсэн үг. Өөрөөр хэлбэл, 19 хоногийн хугацаанд гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээллийг шалгах ажиллагааг явуулж, үр дүнг хяналтын прокурорт шилжүүлнэ гэсэн үг.

Гэтэл хуулийн энэхүү заалт практикт ямар ч хэрэгжилтгүй байдаг нь гэмт хэргийг цагдаагийн байгууллага шалгадаг гэх хуучин хандлагатай холбоотой юм. Тэгэхээр хилийн зурваст үйлдэгдсэн гэмт хэргийг шуурхай илрүүлэхийн тулд хуулийн дээрх заалтыг хэрэгжилтийг хангах хэрэгцээ шаардлага байсаар байна.

Улсын хилийн дэглэмийг сахиулах, улсын хил хамгаалалт, шалган нэвтрүүлэх албыг зохион байгуулах, хилийн инженер, техникийн байгууламж барих зориулалтаар улсын хилийн шугамаас дотогш 15 км-ээс илүүгүйгээр тусгай журам тогтоосон нутаг дэвсгэрийг улсын хилийн зурвас гэнэ[18]. Товчхондоо Монгол Улсын Хилийн шугамаас дотогш 15 хүртэл км орон зайг хилийн зурваст хамааруулжээ.

Хил хамгаалах байгууллагын алба хаагч нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан зөвхөн хойшлуулшгүйгээр явуулах боломжтой дараах мөрдөн шалгах ажиллагааг явуулна. Үүнд:

1.1.үзлэг хийх;

1.2.шинжилгээнд зориулж дээж, хурууны хээ, ул мөрний хэв авах;

[17] Уголовно-процессуальный кодекс РФ от 18 декабря 2001 года N174-ФЗ.

[18] Монгол Улсын Хилийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг.

1.3.хохирогч, гэрч, сэжигтнээс мэдүүлэг авах;

1.4.хэрэгт ач холбогдол бүхий тээврийн хэрэгсэл, мөнгө, эд зүйлийг хурааж авах;

1.5.эд хөрөнгийг битүүмжлэх.

1.6.шинжилгээ хийлгэх шийдвэр гаргах[19] зэрэг болно.

Өөрөөр хэлбэл, хилийн зурваст үйлдэгдсэн гэмт хэргийн шинжтэй дуудлага мэдээлэл ирсэн даруйд хил хамгаалах байгууллагын эрх бүхий албан тушаалтан дээрх мөрдөн шалгах ажиллагааг явуулах боломжтой ба бусад төрлийн мөрдөн шалгах ажиллагааг явуулах нөхцөл байдал тогтоогдсон тохиолдолд түүнийг хэрэгжүүлэхгүйгээр, материалыг харьяаллын дагуу шилжүүлэх байдлаар хэрэгжүүлэх үүрэгтэй байна.

Холбогдох шалгалтын ажиллагааг хуульд заасан хугацаанд хэрэгжүүлсний дараа материалыг хяналтын прокурорт харьяаллаар шилжүүлэх саналтай шилжүүлнэ. Үүний дараа хяналтын прокурор харьяалах цагдаагийн байгууллагад шилжүүлснээр эдийн засгийн хувьд ач холбогдолтой юм.

Газар нутгийн асуудал тодорхой боловч бүртгэгдсэн гэмт хэрэгт хэн мөрдөх ажиллагаа явуулах нь тодорхойгүй байсаар байна. Өөрөөр хэлбэл, хил хамгаалах байгууллагын эрх бүхий албан тушаалтан гэдэгт чухамхүү ямар боловсролтой, албан тушаалтныг хамааруулахыг хил хамгаалах байгууллага дотоод баримт бичгээр тодорхойлох боломжтой. Тухайлбал, албан тушаалын холбогдох баримт бичгүүдэд хойшлуулшгүйгээр мөрдөн шалгах ажиллагааг явуулж болохоор зааж болно.

Хилийн зурваст үйлдэгдсэн аливаа гэмт хэрэгт хил хамгаалах байгууллагаас мөрдөх ажиллагаа явуулах нь олон талын ач холбогдолтой болох нь судалгаагаар тодорхойлогдсон. Үүнд:

1. Хилийн зурваст үйлдэгдсэн гэмт хэргийн нэгдсэн бүртгэл хөтөлснөөр хилийн зөрчлийн суурь шалтгааныг тодорхойлж, хил хамгаалалтын үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах боломжтой.

2. Хилийн зурвас дах эмзэг, эрсдэлтэй нөхцөл байдлыг тодорхойлж, хариу арга хэмжээ авах,

3. Хууль бусаар хил нэвтрэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх,

4. Алслагдсан хилийн зурваст хүрч ажиллахад шаардлагатай хүн хүч, техник хэрэгсэл, түлшний зардлыг хэмнэх зэрэг болно.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албанаас 2021 онд Хил хамгаалах байгууллагын алба хаагчдын үйлдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөл, хүчин зүйлсийг тодорхойлох судалгааны ажлын хэсгийн бүрэлдэхүүнд

[19] Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 30.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

судлаачийн хувиар оролцож, энэ хүрээнд Дорноговь аймаг дэх хилийн байгууллагуудаар алба хаагчидтай уулзаж байхад хойшлуулшгүйгээр мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх хэмжээтэй талаар мэдлэггүй байсан бөгөөд гэмт хэрэг үйлдэгдсэн даруйд харьяа цагдаагийн байгууллагад мэдэгдэж, цагдаагийн алба хаагчдыг иртэл гэмт хэрэг үйлдсэн этгээдийг саатуулах зэрэг ажиллагааг л хэрэгжүүлдэг талаараа хэлж байв.

Мөн хилийн шалган нэвтрүүлэх хэсгүүдэд хил хамгаалах байгууллагын эрх бүхий алба хаагчид ажилладаг боловч гэмт хэргийн шинжтэй үйлдэл тодорхойлогдсон тохиолдолд цагдаагийн байгууллагад мэдэгдэх байдлаар ажиллаж байна. Эдгээр нь цагдаагийн байгууллагаас мөрдөгч, үзлэгийн баг хүрэлцэн ирэх хугацаанд гэмт этгээдэд гэмт хэргийн ул мөрөө баллах, оргон зайлах зэрэг сөрөг талтай.

Түүнчлэн, цагдаагийн байгууллагаас эрх бүхий алба хаагч хүрэлцэн ирэх хугацаанд гэмт хэрэг үйлдэгдсэн этгээдийг саатуулж байгаа бөгөөд энэ нь ямар ч хууль зүйн хүрээнд зохицуулалтгүй харилцаа болох нь эргээд хил хамгаалах байгууллагын алба хаагчдад эрсдэлтэй нөхцөл байдлыг үүсгэж байна. Хилийн тухай хуульд саатуулах харилцаа зохицуулсан боловч тэр нь зөвхөн хил зөрчигчид хамаарах зохицуулалттай байгаа бөгөөд хилийн зурваст үйлдэгдсэн бусад төрлийн гэмт хэрэгт саатуулах эрх зүйн харилцааг зохицуулсан зохицуулалт байхгүй байна.

Хилийн төлөөлөгч, орлогч, туслагч нь улсын хилийн болон хил орчмын дэглэм зөрчсөн этгээдийг шалгах зорилгоор зургаан цагаас илүүгүй хугацаагаар түр саатуулах, зөрчил гаргасан этгээдийн баримт бичгийг шалгах, түүний өмчлөлд, эсхүл эзэмшилд байгаа эд зүйл, биед үзлэг хийх, эд зүйл, баримт бичгийг түр хугацаагаар хураан авах, битүүмжлэх, согтууруулах ундаа, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэсэн эсэхийг шалгах, гэмт хэргийг таслан зогсоох, гэмт этгээдийг мөрдөх үед байгууллага, иргэний орон байранд нэвтрэн орох, түр саатуулагдсан этгээдийн эд зүйл, биед үзлэг хийсэн, эд зүйл, баримт бичгийг хураан авсан тохиолдол бүрд хуульд заасны дагуу тэмдэглэл үйлдэх эрх хэмжээтэй талаар заасан боловч ямар хуулийн процессыг баримтлах нь тодорхойгүй байна. Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг үйлдэгдсэн тохиолдолд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, зөрчлийн шинжтэй бол Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиудад заасан хэм хэмжээг баримталж, нотлох баримтыг бэхжүүлдэг.

Гэтэл Хилийн тухай хуульд дээрх процессыг аль хуулийн агуулгаар хэрэглэх нь тодорхойгүйгээс алба хаагчдын зүгээс үндэслэлгүйгээр бусдын эрхийг хязгаарлах нөхцөлд хүргэж байна. Жишээ нь гэмт хэргийн шинжтэй үйлдэлд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах г.м.

ДҮГНЭЛТ

Судалгааны үр дүнд дараах дүгнэлтэд хүрлээ. Үүнд:

1. Хил хамгаалах байгууллагын эрх бүхий албан тушаалтан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу хойшлуулшгүйгээр мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх хэмжээтэй боловч практикт энэ хуулийн хэрэгжилт байхгүй болох нь тогтоогдов.

2. Хил хамгаалах байгууллагын эрх бүхий албан тушаалтны харьяалах хойшлуулшгүйгээр мөрдөн шалгах ажиллагаа явуулах үндэслэл нь хилийн шугамаас дотогш 15 км-ээс ихгүй газар нутаг хамаарах бөгөөд энэ орон зайд үйлдэгдсэн ямар ч төрлийн гэмт хэрэгт хойшлуулшгүйгээр мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх хэмжээтэй юм.

3. Хил хамгаалах байгууллагын эрх бүхий албан тушаалтан хойшлуулшгүйгээр мөрдөн шалгах ажиллагаа явуулах хуулийн зохицуулалттай ч чухамхүү хэрхэн хэрэгжүүлэх нь ойлгомжгүй, тодорхойгүй хэвээр байгаа зэрэг болно.

Дүгнэлтийг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

7. .

1. Хил хамгаалах ерөнхий газарт Хэрэг бүртгэх албыг шинээр байгуулах,

2. Хил хамгаалах байгууллага бүрд хэрэг бүртгэх эрх бүхий албан тушаалтныг томилж, хилийн зурваст үйлдэгдсэн гэмт хэрэгт хойшлуулшгүйгээр мөрдөн шалгах ажиллагааг явуулах.

3. Хил хамгаалах байгууллагын эрх бүхий алба хаагчдад гэмт хэрэг мөрдөх чиглэлээр тогтмол сургалтыг зохион байгуулах зэрэг болно.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ:

1. Монгол Улсын Үндсэн хууль 1992 он,

2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2017 он,

3. Хилийн тухай хууль 2016 он,

4. ДХИС. Хил хамгаалах байгууллагын алба хаагчдын үйлдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөл, хүчин зүйлс. Судалгааны ажлын тайлан Уб.,2021 он,

5. Г.Лхагвамаа, Ч.Мягмарбаяр. Хилийн эрх зүй. Сурах бичиг. Уб.,2018 он,

6. Хилийн аюулгүй байдлын онол ба практикт тулгамдсан асуудлууд-2017 он. Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Уб.,2017 он

ШАЛГАН НЭВТРҮҮЛЭХ АЛБА БА ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГ

П.БАТБААТАР.
Хилийн цэргийн 0218 дугаар ангийн Ажиллагааны төлөвлөлт, бэлэн байдлын ахлах офицер, Дотоод хэргийн их сургуулийн эрх зүйн магистрант, ахмад

Товч агуулга: Энэ илтгэлд хүн худалдаалах гэмт хэргийн ойлголт, төрөл, түүний хор уршиг, олон улсын шинж чанарыг нээн харуулахын хамт, Монгол Улсад үйлдэж буй энэ гэмт явдлын өнөөгийн байдлын талаар болон хилийн хяналт шалгалтын үйл ажиллагааг сайжруулах асуудлыг тусгасан болно.

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх ажил нь хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд үр дүнд хүрдэг бөгөөд хил хамгаалах байгууллагын оролцоо, ялангуяа хилийн шалган нэвтрүүлэх албаны ажилтны үүрэг нэмэгдэж байгааг олон улсын болон дотоодын нөхцөл байдал харуулж байна.

Хил залгаа ОХУ, БНХАУ-д энэ гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хамтын ажиллагааны талаар өгүүлнэ.

Түлхүүр үгс: Хүн худалдаалах гэмт хэрэг, бэлгийн мөлжлөг, боолчлох, эд эрхтнийг нь авах, албадан хөдөлмөрлүүлэх, гэмт хэргийн хохирогч, хүн худалдаалахтай тэмцэх арга хэрэгсэл, хяналт.

Агуулга

1990 оноос хойш үүсэн бий болсон чөлөөт байдал, ядуурал, ажилгүйдэлтэй холбоотойгоор охид, эмэгтэйчүүд найз нөхдийн ятгалга, цахим мэдээллийн сүлжээгээр өндөр цалинтай ажилд оруулж /загвар өмсөх, бүжиглэх, зочин угтах, ширээний хүүхэн гэх мэт/ зуучлах нэрээр БНХАУ-ыг зорих, амар хялбар аргаар мөнгө олохын тулд тэнд биеэ үнэлэх явдал өсөн нэмэгдэж, буурах хандлагагүй байна. Гадаад улсад энэ төрлийн гэмт хэрэгт өртөж хохирсон иргэд хар тамхи, мансууруулах бодист донтох, бусдад зодуулах, улмаар амь нас, эрүүл мэндээрээ хохирох болон бусад төрлийн гэмт хэрэгт холбогдох давхар эрсдэлд орох байдал нэмэгдэж байна.

Илрүүлэн шалгасан хэргүүдээс харахад хүн худалдаалах гэмт хэргийн гаралт, урсгал нь манай улсын хувьд Зүүн Өмнөд Ази рүү чиглэсэн байдалтай байна. 2024 оны байдлаар БНХАУ-ын хотууд болон Зүүн өмнөд азийн Макао, Сингапур, Малайз, Филлипин зэрэг орнуудад орнуудад биеэ үнэлдэг, үнэлж болзошгүй нийт 500-600 орчим Монгол охид, эмэгтэйчүүд биеэ үнэлж байна гэсэн албан бус судалгаа байна.

Мөн хүн худалдаалах гэмт хэрэг нь мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлт, цахим гэмт хэрэг болон бусад шинэ төрлийн гэмт хэргүүдтэй хослон үйлдэгдэх хандлагатай болсон.

Монгол Улсаас БНХАУ руу Замын-Үүд-Эрээн, Гашуун сухайт-Цагаан хад, Хавирга-Ар хашаат, Гашуунсухайт-Ганц Мод боомтуудаар дамждаг байсан бол Өмнөговь аймгийн Шивээхүрэн, Сүхбаатар аймгийн Бичигтийн боомтууд зэрэг шинэ гарц, чиглэл нэмэгдэж гадаадад зорчиж биеэ үнэлэх урсгал жил бүрийн 6 дугаар сараас 09 дүгээр сарын хооронд ихэссэн тоо үзүүлэлт харагддаг.

Хүн худалдаалах гэмт хэргийн цар хүрээ нь дэлхий нийтийг хамарч, нийгмийн хөгжилтэй зэрэгцэн үйлдлийн арга нь нууц, далд, зохион байгуулалттай хэлбэрээр үйлдэгдэж мөнгө угаах, терроризмын гэмт хэргийн санхүүгийн эх үүсвэр болоод зогсохгүй олон улсын шинж чанартай, өргөн хүрээнд, тогтвортой чиглэл, бүтэцтэй болж өсөн нэмэгдсэн.

Хил залгаа ОХУ, БНХАУ нь өөрсдийн орны биеэ үнэлэгч нартай тэмцэх чиглэлээр Гадаад улс руу зорчих эрхийг хязгаарладаг эрх зүйн орчныг бүрдүүлж ажилласнаар биеэ үнэлэлт, бэлгийн мөлжлөг, хар тамхи, зохион байгуулалттай гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, цагдаа, тагнуул, хил хамгаалах байгууллагын алба хаагчдыг хохирогчийг олж илрүүлэх, тусламж үйлчилгээ үзүүлэхэд анхаарал хандуулан ажиллаж байна. 2022 онд Орос-Украйны хооронд цэргийн тусгай ажиллагаа эхэлснээр хүний худалдаа ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийн худалдаа, эд эрхтний худалдаа Зүүн Европт ихэссэн гэж үздэг.

Хүний эрхийн зөрчил нь олон хэлбэрээр илэрч байдаг. Эдгээр нь эрүүдэн шүүх, хүн худалдаалах, гэмт хэргийн хохирогч болгох, хөдөлмөрийн мөлжлөг, бэлгийн мөлжлөг, шашин болон хүйс, арьс өнгөөр ялгаварлан гадуурхах зэргээр илэрдэг.

Улсын хил болон үндэстэн дамнасан зохион байгуулалттай олон улсын гэж нэрлэгддэг гэмт хэргийн төрлүүд дотроос олон улсын анхаарлыг ихээр татаж байгаа гэмт хэрэг бол хүн худалдаалах гэмт хэрэг юм. Энэ гэмт хэргийг хэн нэгэн ганцаар үйлдэх боломжгүй бөгөөд бүгд нарийн зохион байгуулалтад орж хийгддэг, богино хугацаанд их хэмжээний ашгийг авчирдгаараа бусад төрлийн гэмт хэргээс ялгардаг онц ноцтой гэмт хэрэг тул олон улсын анхаарлын төвд байдаг.

Хүн худалдаалах гэмт хэрэг нь хил болон үндэстэн дамнасан, олон улсын, бүс нутгийн болон үндэсний хэмжээний хурц асуудал болоод байгаа билээ. Дэлхий дээр жил бүр дунджаар 1-2 сая хүн худалдаалагддаг гэсэн тоо баримт байгаа бөгөөд дийлэнх нь хүүхэд, эмэгтэйчүүд байна[20]. Тийм ч учраас олон улсын хэмжээнд энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болсон олон эмэгтэйчүүд, хүүхдүүдийн эрхийг хамгаалах, нийгэмшүүлэх, хүний наймаа эрхлэгчдэд хуулийн хатуу хариуцлагыг хүлээлгэх нийтлэг чиг хандлага давамгайлж байгаагаас гадна олон нийтийн мэдлэг, ойлголт ухамсрыг дээшлүүлэх, өөрсдөө энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх төлөвшлийг бий болгоход анхаарлаа хандуулж байна.

Олон улсын нийгэмлэгийн зүгээс хүн худалдаалахтай тэмцэх асуудлаар хамгийн сүүлд авсан чухал арга хэмжээ бол хүний худалдаа, нэн ялангуяа хүүхэд эмэгтэйчүүдийг худалдахаас урьдчилан сэргийлэх, түүнийг хориглох, цээрлүүлэх тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын Протокол юм. 1990 оны дундуур хэвлэл мэдээллийн хэрэгслүүд Орос улс болон зүүн Европын эмэгтэйчүүд Америкийн Нэгдсэн Улс руу худалдагдаж байгаа тухай мэдээлж эхэлсэн. 2001 онд Америкийн Нэгдсэн Улсын Төрийн Департамент нь Америкийн Нэгдсэн Улсыг "дамжин өнгөрөх буюу зорилтот" улс[21] гэж тодорхойлсон байна. Энэ тодорхойлолтоос үүдэн улс орнуудыг хүлээн авагч, дамжин өнгөрүүлэгч, илгээгч улс орнууд хэмээн ангилан үзэх болсон байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын протокол[22] нь хүний наймааг зогсооход эрчимтэй хичээж

[20] Francis Mik, Trafficking in woman and CChildren: The U.S and International Response, Cong recessional Research Report 98-649-C (May 10.2000),1.

[21] "International approaches to Human trafficking: The call for a Gender-Sensitive Perspective in International Law" PHyllis Coontz and Catherina Griebel, 2004., USA

[22] Үндэстэн дамнасан зохион байгууллаттай гэмт хэргийн эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцийн нэмэлт болох хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан

байгаа ч олон улсын түвшинд хүний наймааны нэгдсэн ойлголтыг өгч чадахгүй байна. Дээрх бүхнээс гадна хүн худалдаалах нь тухайн улсын эдийн засгийн хөгжил, соёлоос хамааран өөрчлөгдөж байдаг нийгмийн асуудал болсон.

Хүн худалдаалах гэмт хэрэг гэдэг нь "хүнийг мөлжих зорилгоор хүч хэрэглэхээр заналхийлэх буюу хүч хэрэглэх, эсхүл хүчирхийллийн бусад хэлбэрийг ашиглах, хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах буюу эмзэг байдлыг нь ашиглах, эсхүл өөр этгээдийг хяналтдаа байлгаж буй этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр хийж буюу ашиг олгон хахуулдах зэрэг аргаар хүмүүсийг урвуулан элсүүлэх, тээвэрлэх дамжуулах, нуугдуулах буюу хүлээж авах үйлдлийг хэлдэг[23].

Монгол Улсад хүн худалдаалах гэмт хэрэгтэй хийх эрх зүйн тэмцэл 1998 оноос эхэлсэн гэж үздэг бөгөөд эрүүгийн хуульдаа хүн худалдаалах гэмт хэргийн талаарх зохицуулалтыг оруулсаар ирсэн. НҮБ-ын улс хоорондын зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг олон улсын конвенц"-ийн нэмэлт болох "Хүн худалдаалах ялангуяа эмэгтэйчүүд хүүхдийг худалдах, залхаан цээрлүүлэхийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх" Палермогийн протоколд 2008 оны 05 дугаар сард нэгдэн орсон.

Мөн Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль 2012.01.19-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж байна. 2015 оны Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд “Биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах эд эрхтнийг авах, албадан хөдөлмөрлүүлж мөлжих зорилгоор хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, хулгайлж, хууран мэхэлж, итгэл эвдэж эрх мэдлээ урвуулан ашиглаж, эмзэг байдлыг нь далимдуулж, эсхүл хяналтдаа байлгаж байгаа хүнд төлбөр төлж, хахуульдаж хүнийг эрхшээлдээ оруулан элсүүлсэн, тээвэрлэсэн, орогнуулсан, дамжуулсан, хүлээн авсан бол” эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр хуульчилж өгсөн.

Хүн худалдаалах гэмт үйлдэлтэй тэмцэх зорилгоор Монгол Улсын Засгийн газар 2017 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 148 дугаар тогтоолоор "Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр" баталж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд 6 яам, тэдний харьяа агентлаг хамрагдаж хүрээнд энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хохирсон иргэдийг хамгаалах, нийгэмшүүлэх, гадаад улс, олон улсын болон төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх зэрэг

сэргийлэх, таслан зогсоох шийтгэх тухай протокол, 2000 он

[23] Үндэстэн дамнасан зохион байгууллаттай гэмт хэргийн эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцын нэмэлт болох хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох шийтгэх тухай протокол, 2000 он

бодлогын шинжтэй ажлуудыг тусгаж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан, үр дүнг тооцон ажиллаж байна. Тус хөтөлбөрийн 3 3.1.8.1 дүгээр зүйлд "хил хяналтын болон эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудыг сургалтад хамруулах, мөн 3.1.8.3 дугаар зүйлд "хилийн хяналтын байгууллагуудыг орчин үеийн техник хэрэгслээр хангах", 3.2.4 дүгээр зүйлд "гадаад улсад хохирогч болсон Монгол Улсын иргэнд туслалцаа үзүүлэх, эргүүлэн авчрах, Монгол Улсад хохирогч болсон гадаадын иргэнийг эх оронд нь буцахад туслалцаа үзүүлэх чиглэлээр олон улсын болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах" гэж заасан нь хил хамгаалах байгууллагын албан хаагчдыг чадавхжуулах үндэслэлийг тодорхойлж байгаа юм.

Насанд хүрээгүй хүнийг улсын хилээр шалган нэвтрүүлэхдээ ХЗДХ-ийн сайдын 2017 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн А49 тоот тушаалаар батлагдсан "Хүүхдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд хяналт тавих" журмаар зохицуулдаг.

Монгол Улсын Дээд Шүүхийн 2008 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн тогтоолоор Хил давуулан худалдаалсан, тээвэрлэсэн, дамжуулсан, орогнуулсан хүлээн авсан гэх ойлголтуудыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор тайлбарласан байдаг.

Хил давуулан худалдаалсан гэдэгт хүнийг худалдаалахын тулд улсын хилийг нууцаар эсхүл хууль ёсоор олж авсан баримт бичиг ашиглан хилээр нэвтрүүлэхийн аль аль нь хамаарна.[24]

Тээвэрлэсэн гэдэгт хүн худалдаалж байгааг мэдсэн этгээд худалдаалагдаж буй хүнийг нэг газраас нөгөөд бүх төрлийн тээврийн хэрэгслээр ил болон далд хэлбэрээр зөөвөрлөхөөс гадна уг ажиллагаанд бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэхийг ойлгоно. Хүн худалдаалж байгаа этгээд өөрөө тээвэрлэсэн бол энэ нь түүний гэмт үйлдлийн нэг хэсэг болно.[25]

Дамжуулсан хүн худалдаалж байгаа мэдсэн этгээд хүнийг гуравдагч улсын нутаг дэвсгэрээр дамжуулан хил нэвтрүүлэх, нэг этгээдээс нөгөөд хүнийг шилжүүлэх болон уг ажиллагаанд бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэхийг ойлгоно.[26]

Орогнуулсан гэдэгт хүн худалдаалж байгааг мэдсэн этгээд хүн худалдаалж буй хүнийг хүлээн авах этгээдэд шилжих хүртэл түр хугацаагаар өөрийн, эсхүл бусдын орон байранд хяналттай болон хяналтгүйгээр нуугдуулан байрлуулахыг ойлгоно.[27]

Хүлээн авсан гэж худалдаалагдсан хүнийг өөрийн

[24] Улсын Дээд Шүүхийн 2008.03.26-ны өдрийн 12 тоот тогтоол

[25] мөн тэнд

[26] мөн тэнд

[27] мөн тэнд

мэдэлд байлгаж, ашиглахаар шилжүүлэн авахыг ойлгоно.[28]

Монгол Улсын хэмжээнд Хүн худалдаалах гэмт хэрэг 2002-2013 оны хооронд нийт 123 хохирогчтой, 198 холбогдогчтой, 189 гэмт хэрэг бүртгэгдэж, 44 хохирогчийн 19.678.033 төгрөгийн хохирол барагдуулсан бол 2015-2018 онд 30 хохирогчтой, 27 холбогдогчтой 24 гэмт хэрэг бүртгэгдэж шалгагдсан байна.

Хүн худалдаалах гэмт хэрэг нь ямагт зохион байгуулалттай төдийгүй олон улсыг хамарсан шинжийг өөртөө агуулдаг. Энэ утгаараа хүн худалдаалах гэмт хэрэг нь үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн нэг бие даасан төрөл гэж хүлээн зөвшөөрөгддөг бөгөөд дэлхийн улс, орон бүрд тархаж байна.

Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын 2017 онд хийсэн судалгаагаар "Орчин цагийн боолчлолд 40 сая хүн өртөж байгаа байгаа бөгөөд үүнээс 24.9 сая хүн албадан хөдөлмөр эрхэлж байгаа бөгөөд 4 хүн тутмын нэг нь хүүхэд, 71 хувь нь охид, эмэгтэйчүүд байна" гэсэн статистик судалгаа гарсан байна.

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд дотоодын хяналтын байгууллагууд төдийгүй хил залгаа улс орнуудын хилийн байгууллагуудын үр дүнтэй хамтын ажиллагаа чухал ач холбогдолтой байдаг бөгөөд энэ төрлийн гэмт хэргийн эсрэг тэмцэх үйл ажиллагаанд дэлхийн улс орнууд бүсийн хэмжээндээ болон улс орнуудын хооронд ихэвчлэн санамж бичиг байгуулах, харилцан гэрээ байгуулах замаар ажиллаж байна.

Манай улсын хувьд энэ төрлийн гэмт хэрэг гарах болсонтой холбогдуулан хилийн хяналтыг сайжруулах, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг төр засгийн түвшинд зохион байгуулах, хууль, хяналтын байгууллагын ажилтнуудын мэдлэг чадварыг нэмэгдүүлэх, төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын үйл ажиллагааг сайжруулан үр өгөөжтэй болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Иймээс хилээр нэвтэрч байгаа тээврийн хэрэгслүүдэд тавьж буй хяналтаа улам сайжруулах, дэвшилтэд тоног төхөөрөмж ашиглах, бусад төрлийн хяналтын арга хэмжээг байнга авч ажиллах шаардлагатай байна. Манай улсын хувьд Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард улстай хиллэдэг учир машин, онгоц, гал тэрэг зэрэг хүн тээвэрлэх боломжтой тээврийн хэрэгслүүдэд онцгой анхаарал тавьж ажиллах шаардлагатай юм.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд Монгол Улсын хилээр нэвтэрч байгаа хүүхдийн биеийн байцаалтыг тодруулах, итгэмжлэлийн үндсэн дээр бусдын хүүхдийг харгалзан яваа этгээдийн

[28] мөн тэнд

биеийн байцаалт, ямар зорилгоор хүүхдийг дагуулан явж байгаа, тухайн хүүхэдтэй ямар холбоотой болох, хүлээн авагч гадаад улс, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг шалгаж нягтлах, итгэмжлэлийн үндсэн дээр гадаад улсад зорчиж байгаа хүүхэд тухайн улсад удаан хугацаагаар сурах, амьдрах тохиолдолд хүлээн авах этгээдийн талаарх мэдээллийг нягтлах, Улсын хилээр хамт гарсан насанд хүрээгүй хүнийг хилийн гадна үлдээсэн тохиолдолд эргэж ирээгүй шалтгааныг нь тодруулах, шаардлагатай гэж үзвэл тухайн асуудлыг цагдаагийн байгууллагад шалгуулахаар шилжүүлэх талаар тус тус хуульчилж өгсөн байдаг.

Хилийн шалган нэвтрүүлэх боомт дээр хүнийг орох, гарах эрх өгдөг хамгийн анхны эрх мэдэл бүхий субъект нь төрийн албан хаагч нар байдаг тул эдгээр албан тушаалтнуудыг сонор сэрэмж, мэдлэг чадварыг нэмэгдүүлэх нь энэ төрлийн гэмт хэргийг таслан зогсоох гол хүчин зүйл болдог.

ХЗДХЯ, Азийн сан, Хүйсийн тэгш эрхийн төв "Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хохирогч төвтэй аргачлалыг хэрэглэхтэй холбоотой Монгол улсын хууль тогтоомж болон сургалтын гарын авлагыг харьцуулах, алба хаагчдын чадавхыг үнэлэх судалгааны тайланд /УБ., 2017, 74 дахь тал/

Таны бодлоор, Хүн Худалдаалах Гэмт Хэргийн аль хэлбэрүүд Монгол Улсад давамгайлж байна вэ? гэсэн асуултад биеийг нь хүчээр үнэлүүлэх (78.7%), бэлгийн мөлжлөгт байлгах (66.0%), албадан хөдөлмөр эрхлүүлэх (66.0%) хэлбэрүүд Монгол Улсад давамгайлж байна гэж судалгаанд оролцогчдын дийлэнх үзжээ. Мөн хуурамч гэрлэлт, эд эрхтнийг наймаалах, тээгч эх болгох хэлбэрүүд олшрох болсон гэж үзэж байгаагаа илэрхийлжээ. Оролцогчдын 4.3% нь ХХГХ-ийн ямар хэлбэрүүд МУ-д давамгайлах болсныг "мэдэхгүй" гэсэн байна".

Цаашид хил залгаа улс орнуудтай хамтран хилийн хяналтыг бүхий л боломжийн хирээр бэхжүүлж, сайжруулах шаардлага бий болж байгаагаас гадна хил дээр ажиллаж буй боловсон хүчнүүдийн Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн талаарх мэдлэг ойлголт, **сонор, сэрэмжийг сайжруулах,** түүнийг илрүүлэх ур чадварыг нэмэгдүүлэх, хил залгаа улс оронтой мэдээллээ богино хугацаанд солилцох боломж нөхцөлөөр хангах талаар тодорхой арга хэмжээг авч ажиллах шаардлагатай юм.

Дүгнэлт

1. Хүн худалдаалах гэмт хэргийн гаралт, урсгал нь манай улсын хувьд Зүүн Өмнөд Ази рүү чиглэсэн байдалтай байна. Монгол Улсаас БНХАУ руу Замын-Үүд-Эрээн, Гашуун сухайт-Цагаан хад, Хавирга-Ар хашаат, Гашуунсухайт-Ганц Мод боомтуудаар дамждаг байсан бол Өмнөговь аймгийн

Шивээхүрэн, Сүхбаатар аймгийн Бичигтийн боомтууд зэрэг шинэ гарц, чиглэл нэмэгдэж гадаадад зорчиж биеэ үнэлэх урсгал улирлын шинжтэй болох хандлагатай байна.

2. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх ажил нь хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд үр дүнд хүрдэг бөгөөд хил хамгаалах байгууллагын оролцоо, ялангуяа хилийн шалган нэвтрүүлэх албаны ажилтны үүрэг нэмэгдэж байгааг олон улсын болон дотоодын нөхцөл байдал харуулж байна. Тухайлбал, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг хил залгаа улсууд руу, төдийгүй тив дамжуулан худалдаалах хандлага олон улсад түгээмэл байна. Түүнчлэн монгол улсад бүртгэгдсэн хүн худалдаалах гэмт хэргийн 70 орчим хувь нь хилийн чандад, гадаад улсад худалдаалагдсан, бэлгийн мөлжлөгт өртсөн шинжтэй байна.

Хүүхэд тээлгэх зорилго нь сайн дурын үндсэн дээр харилцан тохиролцсон байвал танин мэдэх, таслан зогсооход хүндрэлтэй, эх, хүүхэд хоёрын амь насанд эрсдэлтэй, - жирэмсэн эсэхийг нь мэдэх боломжгүй, тээгч эх гэдгийг нотлоход хүндрэлтэй зэрэг олон хүндрэл бэрхшээл байдгийг алба хаагчид дурдсан байна

3. Хил хамгаалах байгууллагын хилийн шалган нэвтрүүлэх албаны албан хаагчдын хүн худалдаалах гэмт хэргийн талаарх ойлголт, хохирогчийг олж тогтоох, анхан шатны үйлчилгээ үзүүлэх, холбогдох байгууллагад шилжүүлэх, хамгаалах мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байна.

4. Хил хамгаалах байгууллагын албан хаагчдыг чадавхжуулах зорилгоор Олон улсын жишигт нийцүүлэн боловсруулсан хөтөлбөрөөр үндэсний сургагч багш нар сургалт тогтмол явуулах нь хил дамнасан хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэхэд ач холбогдолтой.

ХИЛИЙН ШАЛГАН НЭВТРҮҮЛЭХ АЛБАНЫ ЭРХ ЗҮЙН ОРЧИН,ТУЛГАМДАЖ БУЙ ЗАРИМ АСУУДАЛ

С.ЭНХЧИМЭГ
ДХИС-ийн хил судлалын магистрант, Хилийн цэргийн 0166 дугаар ангийн ахлах шалгагч, ахмад
*хариуцлагатай зохиогч: soenkhchimeg77@gmail.com

Хураангуй: Энэхүү өгүүлэл нь Монгол Улсын хилийн шалган нэвтрүүлэх албаны эрх зүйн орчныг онолын болон практик үүднээс шинжилж, тулгамдаж буй гол асуудлуудыг тодорхойлж, шийдвэрлэх боломжит арга замуудыг санал болгож байна. Судалгаанд Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээ, хилийн хяналтын бодлого, хэрэгжилтийн байдал, хилийн албаны ажилтнуудын эрх зүйн баталгааг хамруулсан. Онолын үндэслэл, харьцуулсан эрх зүйн шинжилгээ, бодит кейсүүдийг ашиглан хилийн албаны үйл ажиллагаанд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлсон. Мөн судалгааны үндсэн арга зүйд тулгуурлан Монгол Улсын хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, тайлан, судалгааны өгүүлэл, олон улсын туршлага, хүний эрхийн тайлан, хил хамгаалалтын байгууллагын судалгаа, технологийн дэвшлийн талаарх мэдээлэлд суурилсан баримт бичгийн шинжилгэ, хилийн шалган нэвтрүүлэх үйл ажиллагааны бодит үзүүлэлт, байгууллагын тайлан, Үндэсний статистикийн хорооноос гаргасан статистик мэдээлэлд тулгуурласан тоон болон чанарын дүн шинжилгээ, олон улсын туршлага, хууль эрх зүйн зохицуулалтын харьцуулалт, хууль тогтоомжийн хэрэгжилт, технологийн дэвшлийн талаарх шинжилгээнд тулгуурлан санал дүгнэлтийг гаргасан болно. Тулгамдаж буй асуудлуудад хууль тогтоомжийн зөрчил, эрх зүйн зохицуулалтын давхардал, хүний нөөцийн чадавх, сургалтын тогтолцооны сул тал, олон улсын хамтын ажиллагааны хязгаарлалт зэрэг багтаж байна. Эцэст нь, эрх зүйн орчныг сайжруулах, хилийн албаны чадавхыг нэмэгдүүлэх, олон улсын туршлагыг нэвтрүүлэх чиглэлээр саналыг дэвшүүлсэн болно.

Abstract: This article analyzes the legal environment of the Mongolian border control service from a theoretical and practical perspective, identifies key issues and suggests possible solutions. The study covers Mongolian legislation, international treaties, border control policies, implementation status, and legal guarantees for border service officers. Using theoretical foundations, comparative legal analysis, and real cases, the factors influencing the activities of the border service are identified. Also, based on the main research methodology, the study analyzes documents based on Mongolian legislation, policy documents, reports, research articles, international experience, human rights reports, border guard agency research, and information on technological advances; quantitative and qualitative analysis based on actual indicators of border control activities, agency reports, and statistical data released by the National Statistics Committee; comparison of international experience and legal regulations; and conclusions are drawn based on

the analysis of legislative implementation and technological advances. Challenges include legal inconsistencies, overlapping legal regulations, weaknesses in human resource capacity, training systems, and limitations in international cooperation. Finally, proposals are made to improve the legal environment, increase the capacity of border services, and introduce international practices.

Түлхүүр үгс: эрх зүй, хилийн боомт, бодлого, технологи
Keywords: law, border, policy, technology

Удиртгал

Монгол Улсын хил нь тусгаар тогтнол, аюулгүй байдлын үндсэн баталгаа бөгөөд хилийн шалган нэвтрүүлэх алба нь энэ баталгааг хангах, үндэсний аюулгүй байдал, эдийн засгийн тогтвортой хөгжил, олон улсын харилцаан дахь улс орнуудын хоорондитгэлцлийг бүрдүүлэхэд онцгой үүрэг гүйцэтгэдэг. Хилийн шалган нэвтрүүлэх үйл ажиллагаанд оролцогч байгууллагуудын үйл ажиллагаа, эрх зүйн орчин, төрийн бодлого, олон улсын гэрээ хэлэлцээрийн хэрэгжилт, хүний нөөц, дэд бүтцийн хөгжил, эрсдэл удирдлагыг цогцоор шинжлэх нь улам бүр чухалд тооцогдож буй юм. Сүүлийн жилүүдэд Монгол Улсын хил дээр ялангуяа Чингис хаан, Замын-Үүд, Гашуунсухайт, Алтанбулаг зэрэг боомтуудаар нэвтрэх ачаа бараа, зорчигчдын урсгал эрс нэмэгдсэн, шинэ технологиуд нэвтэрч буй нь орчин цагийн шинэ сорилтууд тулгарав.

Энэхүү өгүүлэл нь хилийн шалган нэвтрүүлэх албаны эрх зүйн орчныг онолын үндэслэлийг судлах, Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын эрх зүй, бодлогын баримт бичгүүд, хэрэгжилт, тулгамдаж буй асуудлыг дүн шинжилгээний үр дүнгээр гаргах, түүнийг шийдвэрлэх арга зам, олон улсын туршлагаас суралцах, харьцуулсан судалгааны үр дүнд тулгуурлан цогц дүгнэлт гаргах зорилготой юм.

Үндсэн хэсэг

Хилийн шалган нэвтрүүлэх ажиллагааны эрх зүй нь эрх зүйн онолын үүднээс төрийн бүрэн эрх, нутаг дэвсгэрийн халдашгүй байдал, олон улсын эрх зүйн үндсэн зарчимд тулгуурладаг. ЮНЕСКО, НҮБ-ын үндсэн баримт бичгүүдэд улсын хил халдашгүй, бүрэн бүтэн байдал, тусгаар тогтнолыг хүндэтгэх, олон улсын хэм хэмжээг мөрдөх гол зарчмуудыг заасан байдаг (United Nations, 1945). Эдгээр зарчмууд хилийн аюулгүй байдлын эрх зүйн үндэс болж, үндэсний хууль тогтоомжид тодорхой тусгагдсан байдаг.

Төрийн эрх зүйн онолд хилийн хэлбэр, хил хамгаалах механизм, засаг захиргаа, бүрэн эрхт байдал хилийн бодлого, хилийн хамгаалалтыг тодорхойлдог. Д.Баярсайхан (2018) зэрэг судлаачид "эрх зүйн философи"[29] талаас нь авч үзвэл улсын хил нь зөвхөн газар зүйн зааг

[29] **“Эрх зүйн философи”** гэдэг нь эрх зүйн мөн чанар, шударга ёс, хууль зүйн үндэслэл, хүний эрх, нийгмийн зохицуулалтын тухай гүн ухааны эргэцүүлэл юм. Эрх зүйн философийн үндэс нь Эртний Грекийн сэтгэгчид болох *Сократ, Платон, Аристотель* нарын бүтээлүүдэд тавигдсан. НТӨ V зуунаас эхлэн эрх зүйн тухай философийн сэтгэлгээ хөгжиж ирсэн. “Эрх зүйн философи” гэсэн нэр томьёо нь XVIII зууны сүүлчээр Германы хуульч *Густав Гуго*-гийн бүтээлд анх хэрэглэгдсэн гэж үздэг.

биш, эрх зүйн субъектив болон объектив хэм хэмжээний огтлолцол, үндэсний хууль тогтоомж ба олон улсын эрх зүйн уулзвар, суурь зохицуулалтын бүс болохыг тэмдэглэсэн байдаг. Улсын хилийг хамгаалах нь хоёрдугаар дайн ба түүнээс хойш НҮБ-ын гишүүн орнууд дээрх зарчмуудыг хатуу баримталж ирсэн түүхтэй. Хил хамгаалах тухай үндсэн эрх зүйн орчны хувьд олон улсын конвенци, протокол, хоёр талт болон олон талт гэрээ, бүс нутгийн болон дэлхийн хэмжээний хамтын ажиллагааны механизмууд олон улсад жишиг болжээ.

Судлаачид хилийн шалган нэвтрүүлэх албаны үйл ажиллагааг тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын хэрэгжилт, өөрийн хууль тогтоомжийг үндэслэн хилийн боомтуудаар улсын хилээр нэвтрүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэх үндсэн бүрэлдэхүүн хэсэг хэмээн тодорхойлдог. Хилийн дэглэмийн тогтолцоо нь олон улсын болон үндэсний эрх зүйн харилцан уялдаа, хилийн боомтод гарч буй практик үйл ажиллагааны зохион байгуулалт, үүсэж болзошгүй эрсдэл ба аюулгүй байдлын удирдлага, дэвшилтэд техник, технологийг нэвтрүүлэх, хүний нөөцийн ур чадвар, ёс зүй зэрэг олон хүчин зүйлсээс шалтгаалдаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн 4[30] дүгээр зүйлийн гол агуулга улсын хил хамгаалалт, шалган нэвтрүүлэх албаны үйл ажиллагааны бүхий л эрх зүйн зохицуулалтын суурь ухагдахуун юм.

Монгол Улсын Засгийн газраас тухайлан хилийн боомттой холбоотой харилцааг ОХУ, БНХАУ-ын Засгийн газартай байгуулсан хэлэлцээр, Хилийн тухай хууль, Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоолоор зохицуулдаг. Хилийн боомт, түүний үйл ажиллагаатай холбоотой дараах голлох олон улсын хэлэлцээр, хуулийг дагаж мөрдөж байна. Үүнд:

- 1992 онд Хилийн тухай хууль,
- 1994 онд Монгол Улс, ОХУ-ын хилийн боомтын хэлэлцээр,
- 2002 онд Төрөөс хилийн талаар баримтлах бодлого,
- 2004 онд Монгол Улс, БНХАУ-ын хилийн боомтын хэлэлцээр,
- 2006 онд Монгол Улс, ОХУ-ын хилийн дэглэмийн гэрээ,
- 2010 онд Монгол Улс, БНХАУ-ын хилийн дэглэмийн гэрээ,
- 2016 онд шинэчлэн найруулсан Хилийн тухай хууль
- 2021 онд Монгол Улс, ОХУ-ын хилийн боомтын хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай протокол бий.

Үүнээс гадна хилийн хяналтын байгууллагууд дээрх хууль, хэлэлцээрийг хэрэгжүүлэх хүрээнд бусад дүрэм, журам, стандартыг үйл ажиллагаандаа дагаж мөрддөг байна. Өнөөгийн мөрдөгдөж буй хууль тогтоомжид хилийн боомт, түүний удирдлага, чиг үүрэг, боомтод мөрдөх журмын

[30] "Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хил халдашгүй, дархан байна", Монгол Улсын Үндсэн хуулийн 4 дүгээр заалт., legalinfo.mn

талаар хэрхэн тусгасан байдалд судалгаа хийж үзлээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн нэгдүгээр бүлгийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хил халдашгүй дархан байна”, аравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улс нь олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж, энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна” гэж заасан нь НҮБ-ын дүрэмд тодорхойлсон “нутаг дэвсгэр бүрэн бүтэн байх”, “улсын хил халдашгүй дархан байх”, “олон улсын үүргээ шударгаар биелүүлэх” гэсэн тулгуур зарчимд үндэслэгдсэн Монгол Улсын хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны олон улсын харилцааг зохицуулах эрх зүйн үндэс болсон байна.

Монгол Улсын Их хурлын 2002 оны 20-р тогтоолоор баталсан “Монгол Улсын Төрөөс хилийн талаар баримтлах бодлого” (2002)-ын үндсэн чиглэл нь улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах, улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах механизмыг боловсронгуй болгох; хил хамгаалах албаны бүтэц, үйл ажиллагаа гэж тусгасан байна.

Хилийн шалган нэвтрүүлэх албаны үйл ажиллагаа нь хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг алба юм. Улсын хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа нь бүхэлдээ үндэсний аюулгүй байдлыг улсын хил болон хил орчмын нутаг дэвсгэрт хангах ажиллагаа байх тул улс орныг батлан хамгаалах арга хэмжээний нэг хэсэг болж байна. Хилийн аюулгүй байдлыг хангах гол зорилго нь хилийн орчинд Монгол улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хамгаалах гадаад, дотоодын аюул, заналаас төр, нийгэм, иргэний аюулгүй байдлыг хангах, хилийн талаар байгуулсан улсын болон олон улсын гэрээ хэлэлцээр, эрх зүйн хэм хэмжээг сахих, зэргэлдээ улстай хамтын ажиллагааг хөгжүүлэх, учирч болзошгүй аюул заналаас урьдчилан сэргийлэх, арилгах тогтолцоо бүрдүүлэхэд оршиж байна. Үүнээс үндэслэн хилийн аюулгүй байдлыг хангах үндсэн зорилтод дараах хамаарна. Үүнд:

- газар нутгийн бүрэн бүтэн байдал;
- улсын тусгаар тогтнолыг хангах;
- улсын хил, хязгаар нутагт сайн хөршийн харилцаа, энх тайвнаар зэрэгцэн оршиход чиглэгдсэн, хилийг зөрчилгүй байлгах болон улсын зарчим, бусад улс хоорондын эрх зүйн хэм хэмжээг сахиулах;
- улсын хилийн шугамын явалтыг хууль бусаар өөрчлүүлэхгүй байх;
- хилийн дэглэм, журмыг хувь хүмүүс, хуулийн этгээдүүдээр сахиулах явдал гэж тодорхойлж болох юм.

Монгол Улсын хилийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2016 онд батлагдсан бөгөөд уг хууль нь хилийн асуудлыг цогцоор нь зохицуулсан байна. Тус “хуулийн

зорилт нь Монгол Улсын хилийн халдашгүй, дархан байдлыг хангах зорилгоор хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээг хэрэгжүүлэх, хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах, улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх, улсын хил хамгаалах байгууллагын тогтолцоо, чиг үүрэг, бүрэн эрх, улсын хил хамгаалалтад иргэн, байгууллагын оролцоог тодорхойлж, хилийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон бусад харилцааг зохицуулахад оршино" (2016). Хилийн аюулгүй байдлын талаар Монгол Улсын хилийн тухай хуульд хуульчилсан нь төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх субъектүүдийг тодорхой болгож, төрийн бусад байгууллагуудын бүрэн эрхийг хуваарилахад шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх, тэдний хүчийг нэгтгэж хилийн аюулгүй байдлыг хангахад нэн чухал эрх зүйн үндэслэл болсон.

"Алсын хараа 2050" урт хугацааны хөгжлийн бодлого (2020) -ыг УИХ-аас 2020 оны 5 дугаар сард батлсан бөгөөд энэхүү урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлэх, эдийн засаг, дэд бүтэц болон төрийн бүтээмжийг сайжруулахад чиглэсэн 10 хүртэлх жилийн хугацаанд хэрэгжих дунд хугацааны зорилтот хөтөлбөр болох "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг (2021) УИХ-ын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдөр 106 дугаар тогтоолоор батлсан юм. "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг хэрэгжүүлснээр урт хугацаанд дараах үр дүнд хүрнэ гэж төлөвлөжээ. Үүнд:

- эдийн засгийн өсөлт дунджаар 6 хувьд хадгалагдаж, нэг хүнд ногдох үндэсний орлого 2 дахин нэмэгдэж, ажиллах хүчний оролцооны түвшин 65 хувьд хүрнэ.

- Боомтын хүчин чадлыг 3 дахин нэмэгдүүлж, эрчим хүчний эх үүсвэрийг 2 дахин өсгөнө.

- "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод дэвшүүлсэн эхний үе шатны зорилго, зорилт хангагдах суурь нөхцөл бүрдэнэ.

"Шинэ сэргэлтийн бодлого"-ын хүрээнд төр, хувийн хэвшил, хөрөнгө оруулагчдын идэвхтэй түншлэлд тулгуурлан Монгол Улсын хөгжлийг хязгаарлаж буй зургаан багц асуудлыг шийдвэрлэхээр зорьсон бөгөөд Боомтын сэргэлт багц асуудалд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнд:

-Боомтуудын хатуу, зөөлөн дэд бүтцийг хөгжүүлэн зорчигч, тээврийн хэрэгсэл болон ачаа барааг улсын хилээр нэвтрүүлэх хүчин чадлыг дээшлүүлж, экспортыг нэмэгдүүлнэ;

-Хилийн боомтуудыг төмөр зам болон хатуу хучилттай авто замаар үе шаттайгаар бүрэн холбон, тээвэр логистикийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн ачаа тээврийн урсгалыг сайжруулж, цаашид транзит улс болох суурь нөхцөлийг бүрдүүлнэ;

-Монгол Улсын агаарын зайн зохион байгуулалт, агаарын замын ашиглалтыг сайжруулан, дамжин өнгөрөх агаарын хөлгийн тоог

нэмэгдүүлж, агаарын тээврийн либералчлалыг үе шаттай үргэлжлүүлэх замаар ачаа тээврийн зангилаа төвийг бий болгож, мөн аялал жуулчлалын салбарыг дэмжинэ;

-Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлан эдийн засгийн чөлөөт бүс, хуурай боомтуудыг үе шаттайгаар байгуулах замаар худалдааны эргэлтийг нэмэгдүүлнэ (Шинэ сэргэлтийн бодлого, 2021).

Хилийн боомтыг хөгжүүлэх бодлого боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааг зохицуулах үүрэг бүхий орон тооны бус Боомтын сэргэлтийн Үндэсний хороо (Монгол Улсын хилийн тухай хууль, 2016) ажиллаж байна. Бодлогын хүрээнд нийт 6 багц боомтын сэргэлтийн төсөл хөтөлбөрүүд батлагдсан байна. Үүнд төмөр замыг холбох, төмөр замын сүлжээг шинэчлэн сайжруулах, шинээр төмөр зам байгуулах, хилийн боомтуудыг нэмэгдүүлэх, хилийн боомтуудын хүчин чадлыг нэмэгдүүлэх, терминалуудыг байгуулах төслүүд тус тус багтана. Ингэснээр ачаа болон зорчигч нэвтрүүлэх хүчин чадал, урсгалыг нэмэгдүүлж, экспорт, худалдааны эргэлт сайжран, аялал жуулчлалын салбарыг дэмжинэ. Мөн эдийн засгийн чөлөөт бүс, хуурай боомтуудыг үе шаттайгаар байгуулснаар тээвэр, логистикийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн цаашид “Транзит улс” болох суурь нөхцөлийг бүрдүүлэх юм.

Дээрх баримт бичгүүд батлагдан улсын төсөв, гадаад улсын зээл тусламж зэрэг хөрөнгө оруулалтаар дэмжин боомтын сэргэлтийн үйл ажиллагаанд эрчимжүүлснээр тодорхой үр дүн гарч байна. Зураг -ээр харуулав.



Зураг 1. Төсвийн орлогод Боомтын сэргэлтээс орсон орлого

хатуу хучилттай замаар холбох, онгоцны буудлуудын хүчин чадлыг

Эх сурвалж: Сангийн яам

Хилийн боомтын буюу хилийн шалган нэвтрүүлэх албаны үйл ажиллагааны талаар бие даасан хууль байхгүй ч Монгол Улсын Үндсэн хуулийг үндэслэн Монгол Улсын Хилийн тухай хууль, бусад хууль тогтоомжоор тодорхой түвшинд зохицуулсан байна. Тухайлбал, Хилийн тухай хуулийн 28 дугаар зүйлээр Хилийн боомт, түүнд мөрдөх журам (2016)-ыг зохицуулсан байна. Үүнд, хилийн боомт шинээр байгуулах, хаах, нэвтрэх хөдөлгөөнийг зогсоох асуудал, улсын хил хамгаалах байгууллагын үүрэг, хилийн боомтод мөрдөх журам, хилийн боомтод аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа зэргийг зааж өгсөн байна.

Мөн хуулийн 29 дүгээр зүйлээр Хилийн боомтын удирдлага (2016) болох Боомтын сэргэлтийн Үндэсний хороо, Хилийн боомтын захиргаа, тэдгээрийн бүрэн эрхийг зохицуулжээ. Хилийн боомтын үндэсний зөвлөлийн 2017 оны 1 дүгээр тогтоолын хавсралтаар “Хилийн боомтод мөрдөх нийтлэг журам”-ыг баталсан.

Хилийн боомтын захиргаа нь Засгийн газрын 2022 оны 142 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Хилийн боомтын захиргааны үйл ажиллагааны дүрэм”-ийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Түүнчлэн Засгийн газрын 2021 оны 137 дугаар тогтоолоор баталсан **“**Агаарын тээврийг хялбаршуулах журам” нь хилийн хяналтын байгууллагуудын үйл ажиллагааг шуурхай болгох, агаарын хөлөг хүлээж авах ажиллагааг хөнгөвчлөх зорилгоор зорчигчийн мэдээллийг цахимаар урьдчилан авах тогтолцоо бүрдүүлсэн. Тухайлбал, улсын хилээр нэвтрэх агаарын хөлгийн ачаалалтын талаарх мэдээлэл (зорчигчдын нэрсийн жагсаалт, аяллын бичиг баримтын өгөгдлүүд, ачааны дагалдах бичиг, мэдүүлэг)-ийг очих нисэх буудлын хилийн хяналтын байгууллагад урьдчилан дамжуулж, хилийн хяналтын ажиллагаанд эрсдэлийн удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх боломжийг олгох гэж журамлаж өгсөн нь хилийн хяналт шалгалтыг шуурхайлж, эрсдэлээс сэргийлэх нөхцөлийг бүрдүүлж өгчээ.

Олон улсын эрх зүйн түвшинд НҮБ-ийн тусгайлсан конвенцүүд болох “Хил, газар нутгийн маргаанаас урьдчилан сэргийлэх” (Boundary Dispute Prevention), хүний эрх, аюулгүй байдлын талаар байгуулсан 100 гаруй хэлэлцээрт Монгол Улс нэгдэн орсон. Мөн түүнчлэн хил дамнасан терроризмтой тэмцэх, агаарын тээврийн аюулгүй байдал, хууль бус цагаачлал, хүн худалдаалах, хар тамхи, мөнгө угаахтай холбогдсон олон улсын стандарт, мэдээлэл солилцоо, хамтарсан хяналт, нэгтгэсэн менежментийн бодлогыг хэрэгжүүлж байна.

Олон улсын туршлагаас харахад Европын Холбоо зэрэг бүс нутгийн болон дэлхийн ижил төстэй орнуудад хилийн нэгдсэн менежмент (Coordinated Border Management) (2011), олон улсын

мэдээллийн сан (Advanced Passenger I) (Comision Europea, 2022), шалгагчгүй автоматжуулсан технологи, Шенгений SIS[31] II систем (European Union, 2013), визийн кодекс/визийн мэдээллийн нэгдсэн сан, хууль бусаар нэвтэрсэн иргэдийг буцаах, ажил олгогчийн хариуцлага, оюуны өмчийн хяналт, чөлөөт бүс, бүсчилсэн дэглэм зэрэг төрийн бодлого, зохицуулалт голчилж байна.

Цаашид Монгол Улсын хилийн аюулгүй байдлыг олон улсын түвшинд баталгаажуулахын тулд бүс нутагт хэрэгжүүлж буй олон улсын стандарт, хил залгаа улсуудын техник технологийн дэвшлийг нэвтрүүлсэн ололт, түүнд чиглэсэн эрх зүйн механизмыг бүрдүүлэх шаардлага улам ихсэж буйн шинж харагдаж байна.

Сүүлийн жилүүдэд боомтын хөгжил, ачаа эргэлт, зорчигч урсгал огцом нэмэгдэж байгаа нь шалган нэвтрүүлэх үйл ажиллагаа, ил тод байдал, аюулгүй байдлын эрсдлийг өсгөж байна. Тухайлбал, Гашуунсухайт автозамын хилийн боомт нь Монгол Улсын нүүрсний экспортын хамгийн том гарц бөгөөд нийт экспортын 52–60 хувийг дангаар бүрдүүлдэг (Ц.Цэнд, 2024). 2024 онд Гашуунсухайт боомтоор нийт 36.5 сая тонн нүүрс экспортолсон бөгөөд энэ нь өмнөх оноос 13.2–20 хувиар өссөн үзүүлэлт юм. Монгол Улсын Үндэсний статистикийн хорооноос жил бүр гаргадаг тайланд “Монгол Улсын хилээр 2024 онд давхардсан тоогоор 7 179.2 мянган зорчигч нэвтэрсэн нь 2015 оноос 47.7 хувиар, 2020 оноос 5.3 дахин, 2023 оноос 34.6 хувиар тус тус өссөн байна. Үүнээс 3.58 сая нь орсон, 3.6 сая нь гарсан зорчигчид байна” (Монгол Улсын Үндэсний статистикийн хороо, 2025).

Улсын хилээр нэвтэрсэн нийт зорчигчдын 3 576.6 (49.8%) мянга нь улсын хилээр орсон, 3 602.6 (50.2%) мянга нь улсын хилээр гарсан зорчигчид байна. Хилээр нэвтэрсэн зорчигчдыг боомтуудаар нь авч үзвэл, нийт зорчигчдын 83.5 хувь нь Замын-Үүд, Чингис хаан, Алтанбулаг, Гашуун сухайт, Шивээ хүрэн зэрэг 5 том хилийн боомтоор нэвтэрсэн байна. Харин үлдсэн 16.5 хувь нь бусад хилийн боомтоор нэвтэрсэн байна. Дээрх үзүүлэлтийг 2020 оноос Монгол Улсад зорчсон зорчигчдын тоон харьцуулалт, тухайн үеийн нөхцөл байдал зэргийг судалж, хүснэгт 1-ээр харуулав.

[31] **SIS II (Schengen Information System II)**-нь Европын Холбоо болон Шенгений орнуудын хил хамгаалалт, аюулгүй байдлын үндсэн мэдээллийн нэгдсэн систем бөгөөд хил хамгаалалт, цагдаа, гааль, визийн байгууллагуудын хооронд мэдээлэл солилцох боломжийг олгодогоороо онцлогтой.

Он	Нийт зорчигч (мянгаар)	Өмнөх онтой харьцуулсан өсөлт (%)	Шалтгаан нөхцөл
2020	~1,316.1	–	КОВИД-19 цар тахлын улмаас зорчих хөдөлгөөн огцом буурсан
2021	~1,643.4	+24.9%	Хил нээгдэж эхэлсэн, зорчигчдын тоо бага зэрэг нэмэгдсэн
2022	~2,016.3	+22.7%	Аялал жуулчлал сэргэж эхэлсэн
2023	~2,652.9	+31.6%	Жуулчдын тоо эрс нэмэгдсэн, Замын-Үүд ба Чингис хаан хилийн боомтуудад гол ачааллыг авч байна.
2024	~3,576.0	+34.6%	Хамгийн өндөр үзүүлэлт, улсын хилээр нийт орсон зорчигчдын тоо 3.58 саяд хүрсэн

Хүснэгт 1. Монгол Улсын хилээр нэвтэрсэн зорчигчдын тоон харьцуулалт, шалтгаан нөхцөл (2020–2024 он)

Эх сурвалж. Судлаачийн боловсруулсан хувилбар. Мэдээллийг: Үндэсний статистикийн хорооны албан ёсны цахим хуудас, Статистикийн мэдээллийн нэгдсэн систем., татаж үзсэн 2025.11.14, дэлгэрэнгүйг: 1212.mn

Дээрх хүснэгтээс харахад улсын хилээр 2024 онд нэвтэрсэн зорчигчдын тоог өмнөх онуудтай харьцуулахад 2020 оноос 5.3 дахин, 2021 оноос 11.1 дахин, 2022 оноос 3.6 дахин, өмнөх оноос 34.6 хувиар тус тус өсжээ. 2020-2021 онд дэлхий дахинд КОВИД-19 цар тахал дэгдсэнтэй холбоотойгоор Монгол Улсын хилээр нэвтэрсэн зорчигчдын тоо огцом буурсан. Харин 2022 оны 2-р сараас эхлэн хилийн боомтуудыг үе шаттайгаар нээж эхэлснээр зорчигчдын тоо аажмаар нэмэгдэж эхэлжээ (2025).

Мөн дээрх тайланд Монгол Улсын хилээр 2024 онд 4 сая 30 (давхардсан тоогоор) мянга тээврийн хэрэгсэл нэвтрүүлсэн нь 2023 оноос 1 сая 49 (35.2%) мянгаар, 2020 оноос 2 сая 272 (2.3 дахин) мянгаар өсжээ. Нийт тээврийн хэрэгслийн 33.7 хувь нь Замын-Үүд, 22.1 хувь нь Гашуун сухайт, 12.0 хувь нь Шивээ хүрэн, 7.5 хувь нь Алтанбулаг, 5.1 хувь нь Сүхбаатар, 19.6 хувь нь бусад боомтоор тус тус нэвтэрсэн байна (2025).

Дээр дурдсан статистик тоон үзүүлэлт болон судалгаанаас харахад Гашуунсухайт боомт Монголын нүүрсний экспортын төв гол боомт хэвээр байж, улсын нийт экспортын тал хувиас илүүг дангаар гаргасан. Энэ нь Монгол, Хятадын нүүрсний худалдаанд стратегийн ач холбогдолтой хэвээр байгааг илэрхийлж байна.

Тэгэхээр Монгол Улсыг зорих жуулчдын тоо өссөн, экспорт, импортын эргэлт нэмэгдэж буй өнөө үед нэгэнт бий болж буй ажлын ачаалал, инженерийн дэд бүтцийн хязгаарлалт, техник технологийн шинэчлэл нь өмнө нь төсөөлж байгаагүйгээр илрэн гарч байна. Энэхүү үндэслэлийн хүрээнд

хилийн боомтуудаа өргөтгөх, шинээр барьж, байгуулах зэрэг томоохон төсөл, хөтөлбөрүүд хэрэгжиж байгааг та бид өдөр тутамдаа хэвлэл мэдээллийн хэрэгслээр харж байгаа билээ. Гэсэн хэдий ч тийм ч амар хийгдэггүй гэдгийг зарим жишээ баримтаар харж болно. Тухайлбал, Замын-Үүд хилийн боомтын ачаа, тээврийн терминалын хэсгийг 24 цагаар ажиллуулах, шинээр Ханги–Мандал, Гашуунсухайт–Ганцмод зэрэг төмөр замын хилийн боомтын хил холболт, дэд бүтцийг байгуулахад хяналт шалгалтад зарцуулах хугацааг багасгах, цахимжуулалт, улсын хилээр нэвтрэх урсгал хөдөлгөөний огцом өсөлт зэргийг зохицуулах үйл ажиллагааны менежмент зэрэг нь өнөөгийн тулгамдаж буй асуудал болж байна. Үүнийг илүү дэлгэрэнгүйгээр авч үзэхийг зорисон болно. Үүнд:

1.Хилийн боомтод мөрдөгдөх хууль тогтоомж, дүрэм, журмын харилцан уялдаа холбоо. Хилийн хяналтын байгууллагуудын бие даасан хууль тогтоомжууд хэрэглэгдэж буй ч зарим тохиолдолд хоорондын уялдаа, чиг үүргийн давхардал, дутагдал зэрэг нь ажиглагддаг. Хилийн тухай хууль, Гаалийн тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд тусгагдсан хилийн хяналтын байгууллагуудын эрх, үүргийн хүрээ, үйл ажиллагааны уялдаа эргээд бодит амьдрал дээр хүндрэлүүдийг үүсгэж, зохиомол ажлын ачаалал үүсэх ч нөхцөл байдал үүсдэг. Тухайлбал, Хил хамгаалах байгууллага, Гааль, Гадаадын иргэн, харьяатын газрын чиг үүрэг, бүрэн эрх, үйл ажиллагаа системийн төвшинд уялдаа хангахад бүтэц, тогтолцооны өөр байдал, мэдээллийн сангийн тусдаа байдал нь эцсийн дүндээ нэгдсэн стандартын хэрэгцээг үгүйлж байна.

2.Дэд бүтэц, техник технологийн хоцрогдол. Ихэнх хилийн боомтод мэдээллийн технологийн систем (E-immigration, ISM, Цахим E-Gate, биометрик бүртгэл, хадгалалт, нэгдсэн камерийн сүлжээ) суурилсан боловч саатал, алдаа, хүний оролцоо, “цахим нэг цонхны үйлчилгээний” хэрэгжилт сул хэвээр үлдэж, давхар бүртгэл, өгөгдөл зөрүү, хуурамч баримт бичиг, зөрчил давтан илрэх шалтгаан болдог. Хүйтэн өдрүүдэд цахилгаан, дулаан, усаар доголдолтой, замын дэд бүтэц сул боомт идэвхгүй болох, тээврийн түгжрэл даамжирдаг ажил хэрэгжиж байна.

3.Хүний нөөцийн дутагдалтай байдал, нийгмийн хамгааллын бодлого. Хүний нөөцийн тогтворгүй байдал, алба хаагчдын чадавхи, сургалтын тогтолцооны асуудал хилийн шалган нэвтрүүлэх албаны үйл ажиллагаанд нөлөөлөх хүчин зүйл болж байна. Гэхдээ сүүлийн 3 жил (2022-2024 он)-д Хил хамгаалах байгууллагын зүгээс бодлогын зөв менежментийг явуулсанаар алба хаагчдын цалин урамшуулал, бусад нэмэгдлүүд бодитойгоор нэмэгдсэн нь хилчдэд урам, зориг өгөх, залуу

офицеруудын хил рүү тэмүүлэх явдал нэмэгдсэн.

4.Хилийн боомтоор гарч болох хууль бус үйлдэл, хамтын ажил, байгууллагын уялдаа, мэдээллийн солилцоо. Хилийн боомтоор гарч буй баримт бичгийн хуурмаглал, хил дамнасан гэмт хэрэг, биометрик өгөгдлийн эрсдэл нэмэгдэж байгаа нь олон улсын туршлагаас сургамж авах шаардлагатайг харуулж байна. АНУ, ОХУ, БНХАУ зэрэг улсуудын жишээ нь хамтын ажиллагаа, мэдээлэл солилцоо, сургалтын шинэ аргачлал чухал болохыг нотолж байна. Боомтын сэргэлтийн үндэсний зөвлөл, хамтарсан комисс, зөвлөгөөн онолын хувьд хэрэгжиж буй ч хилийн хяналтын болон дээрх зөвлөлийн байгууллагуудын хоорондмэдээлэл солилцоо, уялдаа муу, мэдээ мэдээлэлд шуурхай дүн шинжилгээ хийх, нэгдсэн мэдээллийн систем дутагдаж байгааг нуух юун. Хилийн зөрчлийг шийдвэрлэх эрх мэдлийн зааг нь хэвээр үлдсэн, зөрчлийг таслан зогсоох, хариуцлага тооцуулахаар шүүхээр шийдвэрлүүлэх тогтолцоо нь өөрөө төвөгтэй, олон шат дамжлагатай, цаг хугацааны алдагдал ихтэй гэж ажил үүргийг гүйцэтгэж байгаа алба хаагч болон байцаагч, мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлагын үеэр хэлж байсан.

Дүгнэлт

Хилийн шалган нэвтрүүлэх албаны эрх зүйн орчин олон улсын эрх зүй, үндэсний хууль тогтоомж, бодлогын уялдаа, тогтолцооны шинэчлэлээр улам боловсронгуй болж байна. Үүний зэрэгцээ хилийн хяналтын байгууллагуудын алба хаагчдын чадавх, техник технологийн шинэчлэл, үйл ажиллагааны ил тод байдал, нэгдсэн үйлчилгээ үзүүлэх нэг цонхны үйлчилгээ зэрэг бодит үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дээр дурдсан тулгамдаж буй асуудлууд тулгарч буйг дурдах хэрэгтэй.

Тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд хууль эрх зүйн уялдаа, цахим платформын шинэчлэл, хүний нөөцийн зөв тогтолцоо, олон улсын хамтын ажиллагааг сайжруулах, техник технологийн хөгжил, нийгмийн хамгааллын үйлчилгээ зэргийг өргөтгөх шаардлагатай байна. Хилийн шалган нэвтрүүлэх албанд мөрдөгдөж буй эрх зүйн зохицуулалт нь зөвхөн өөрийн улсын ашиг сонирхол гэхээсээ илүүтэйгээр олон улсын стандарттай нийцүүлэх, бүс нутаг болон дэлхийн хамтын ажиллагаанд нэгдэж, мэдээллийн нэгдсэн урсгалыг шуурхай хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой болох юм.

Ингэснээр хилийн шалган нэвтрүүлэх албаны үйл ажиллагааны үр дүн, аюулгүй байдал, дэвшилтэд техник, технологийг нэвтрүүлэх, хилийн хяналтын байгууллагуудын үйл ажиллагаа тэр дундаа алба хаагчдын чадавх, хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах суурь болно гэж үзэж байна.

Санал

Энэхүү өгүүллийн хүрээнд хийгдсэн судалгаа, статистик тоо баримтын үндсэн дээр гаргасан

тоон чанарын үзүүлэлт, хилийн шалган нэвтрүүлэх албаны эрх зүйн орчин, үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд судлаачийн зүгээс дараах саналыг гаргасан болно. Үүнд.

1.*Хууль тогтоомжийн харилцан уялдаа, өөрчлөлт, шинэчлэлийн хүрээнд сайжруулах.*

Хилийн хяналтын байгууллагуудаас хилийн боомтод явуулж буй үйл ажиллагаа, боомтын дэд бүтэц, хөгжлийн асуудлыг зохицуулсан эрх зүйн орчныг бүрдүүлэх нэн шаардлагатай байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна. Хилийн хяналтын байгууллагууд нь өөрийн гэсэн мөрдөж ажилладаг хууль тогтоомжтой, босоо удирдлагын тогтолцоотой байгаа нь нэг зорилго, зорилтын хүрээнд үйл ажиллагаа явуулахад хүндрэл учирдаг. Тиймээс эрх зүйн нэг хуулийн зохицуулалттай болох. Боомтын сэргэлтийн үндэсний хороо, боомтын захиргаа, боомтын зөвлөл зэрэг бүх оролцогч байгууллагын эрх үүргийг шаталсан, давхардалгүй зохицуулсан хуулийг нэн тэргүүнд боловсруулж, батлуулах.

2.Цахимжуулалт, нэгдсэн менежмент.

“Цахим нэг цонхны үйлчилгээ” бүрэн хэрэгжүүлэх. Улсын хилээр нэвтрэх зорчигч, тээврийн хэрэгсэл, ачаа барааны бүртгэлийн мэдээллийн сангуудыг нэгдсэн платформ руу нэгтгэж, давхардал, зөрүүг арилгах, биометрик буюу хүний биеийн давхцахгүй өгөгдэхүүнд суурилсан автоматжуулсан шалгагчгүй техник технологийг түлхүү ашиглаж, хүний оролцоо, ачааллыг багасгах шаардлагатай. Мөн түүнчлэн хлийн хяналт, шалгалтад ашиглах багаж, сканнер, хил нэвтрэх баримт бичгийг таних, хуурмаглалыг илрүүлэх, технологи, хиймэл оюун ухааныг нэвтрүүлэх зэрэгт анхаарах.

Эх сурвалж

"Алсын хараа-2050" урт хугацааны хөгжлийн бодлого. (2020, 5 13). *Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем.* Retrieved from Улсын Их Хурлын тогтоол: https://legalinfo.mn/mn/detail/15406

Comision Europea. (2022, 12). *Comision Europea*. Retrieved from Comision Europea: https://ec.europa.eu/commission/presscorner/detail/es/qanda_22_7646

European Union. (2013, 4 18). *Publications Office of the European Union*. Retrieved from SIS II, Schengen information system: https://op.europa.eu/en/publication-detail/-/publication/65aad20a-ae7f-4d67-8655-86c99660c8f4

Inter American Development Bank. (2011). *Interoperability at the Border: Coordinated Border Management Best Practices & Case Studies.* doi:https://doi.org/10.18235/0008907

United Nations. (1945, 11 05). *Charter of the United Nations.* Retrieved from Charter of the United Nations: https://www.un.org/en/about-us/un-charter

Гаалийн тухай хууль. (2008, 5 20). *Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем.* Retrieved from Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем:

https://legalinfo.mn/mn/detail?lawId=209

Д Баярсайхан. (2018). *Эрх зүйн онол.* УБ: Соёмбо принтинг.

Монгол Улсын Үндэсний статистикийн хороо. (2025). *Монгол Улсын хилээр нэвтэрсэн зорчигч, тээврийн хэрэгсэл 2024 он танилцуулга.* Улаанбаатар.

Монгол Улсын хилийн тухай хууль. (2016, 12 28). *Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем.* Retrieved from Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: https://legalinfo.mn/mn/detail?lawId=12418

Төрөөс хилийн талаар баримтлах бодлого. (2002, 5 16). *Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем.* Retrieved from Улсын Их хурлын тогтоол: https://legalinfo.mn/mn/detail?lawId=6493

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. (2010, 7 15). *Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем.* Retrieved from Улсын их хурлын тогтоол: https://legalinfo.mn/mn/detail?lawId=6163

Ц.Цэнд. (2024, 9 11). *CNBC Mongolia*. Retrieved from Гашуунсухайт-Ганцмод боомтоор гаргасан нүүрсний хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 20 хувиар өслөө: https://www.cnbc.mn/news/h3s1

Шинэ сэргэлтийн бодлого. (2021, 12 31). *Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем.* Retrieved from Улсын Их хурлын тогтоол: https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390082532431&type=3

ЖАНЧХҮҮГИЙН ДАВААНД ЖАНЖИН ТУГАА ЦЭНГҮҮЛСЭН АЯН ЗАМЫН ТЭМДЭГЛЭЛ- №30

Хөшөө тийш зурайх ардын зам балраагүй.
Ш.Сүрэнжав.
“Жанчхүүгийн даваанаас нааш хятад шаахайн мөр бүү гарга”
Чин ван Ханддорж

Ц.ГАНБОЛД
ДХИС-ийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Хилийн аюулгүй байдал судлалын төвийн ахлах судлаач, доктор (Ph.D), профессор, хурандаа

“Хөшөө тийш зурайх ардын зам балраагүй”-г нотолсон нэгэн томоохон арга хэмжээнд оролцох том боломж олдсонд талархаад баршгүй ээ.

Дэлхийн II дайны төгсгөлд Монгол Ардын Хувьсгалт Цэрэг, Зөвлөлтийн улаан армийн хамт Зүүн хойд Хятад, Өвөр Монголыг чөлөөлсөн нь дэлхий дахины энх тайванд үнэтэй хувь нэмэр оруулсан ХХ зууны Монголын түүхийн маш том үйл явдал болсон юм.

1945 оны Чөлөөлөх дайны ялалт нь зөвхөн Монгол Улсын төдийгүй бүс нутгийн мартагдашгүй ач холбогдолтой үйл явдал байсан гэж үздэг. Энэ дайны ялалтаар 1945 онд Төв, Зүүн, Зүүн өмнөд Азийн 5 орон тусгаар тогтнолоо зарлаж байлаа. Энэ дайны ялалтын үр дүнд Монгол Улсын тусгаар тогтнолыг олон улсын тавцанд баталгаажуулж, Монгол Улс дэлхийн хамтын нийгэмлэгт гишүүнээр элсэх үүд хаалгыг нээсэн түүхэн чухал үйл явдал болсон юм.

“ ... Хятадын Ардын чөлөөлөх армид их хэмжээний олзолсон зэвсэг, 15000 агт морь бэлэглэж, тухайн үеийн ханшаар 205 сая төгрөг буюу 50 сая ам.долларыг дайнд зарцуулж байсан" /МУИС-ийн УТСОУХНУС-ийн Дэд Профессор Ж.Баттөр/.

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагч У.Хүрэлсүх БНХАУ-д болж буй Дэлхийн хоёрдугаар дайны төгсгөл, Чөлөөлөх дайны ялалтын 80 жилийн ойн арга хэмжээнд оролцон төгсгөлд нь Жанчхүүгийн даваанд орших Монгол-Зөвлөлтийг цэргийн хөшөөнд хүндэтгэл үзүүлэх бөгөөд энэ арга хэмжээнд оролцсон юм. Монгол Улсын ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагч У.Хүрэлсүхийг шадар сайд Н.Учрал, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Монгол Улсаас БНХАУ-д суугаа элчин сайд Н.Энхболд, УИХ-ын гишүүн Б.Пүрэвдорж, Хэрлэн болон Монгол Улсаас БНХАУ-д суугаа элчин сайдын яамны ажилтнууд Цэргийн атташе, хурандаа Ганбат, хилийн төлөөлөгч, хурандаа А.Эрдэнэчимэг, туслах дэд хурандаа М.Баяржаргал нар болон Монгол цэргийн нэгдсэн холбооны төлөөлөл оролцсон үйл явдал болов.

Монгол Улсын Зэвсэгт хүчин, Жанжин штабын дэргэдэх Үлгэр жишээ үлээвэр найрал хөгжим, ҮБХИС, Хил хамгаалах байгууллага, Дотоод хэргийн их сургууль, Дайн, энхийг дэмжих ажиллагаанд оролцогчдын Монголын холбоо, Монголын

үндэсний телевизийн төлөөлөл бүхий томоохон бүрэлдэхүүн мөн оролцсон билээ.

Жанчхүүгийн даваанд Маршал Х.Чойбалсан 1945 онд очсоноос хойш Монголын төрийн тэргүүн 80 жилийн дараа хүрэлцэн очиж, хүндэтгэл үзүүлж буй нь энэ арга хэмжээ юм аа.

БНХАУ-ын талаас Бэлтгэл цэргийн хэрэг эрхлэх яамны орлогч сайд, Хэбэй мужийн орлогч дарга нарын албаны хүмүүс оролцов. БНХАУ-ын ХАЧА болон төр, засгаа төлөөлсөн хүмүүс оролцсонгүй. Бэлтгэл цэргийн хэрэг эрхлэх яам нь миний ойлгосноор бол манай Цэргийн нэгдсэн холбоо юм уу даа.

Төрийн томилолт-аяллын замналын зохион байгуулалтын асуудал, менежментийг Хаан тревел гадаад аялал жуулчлалын компани, Хятад улсын Эрээн хот дахь түнш компанитайгаа хариуцсан бөгөөд аялал хариуцсан менежер-хөтөч Э.Сүндэрьяа, Б.Даш нар дээд түвшинд зохион байгуулсан, манай залуу үеийн төлөөлөл, ажил мэргэжилдээ гаршсан залуучууд байлаа. Манай бүлгийг хоёр автобус, 80 хүнийг уг нь БХЯ-ны Ерөнхий шалгагч бригадын генерал Ж.Болдбаатар удирдсан бөгөөд заримдаа ч Э.Сүндэрьяа манай дарга билүү гэж будилмаар байсан шүү.

Аян замын тэмдэглэл бол замд тохиолдсон үйл явдлыг тоочин хэлхэх бус түүхийн, танин мэдэхүйн болон судалгааны тухайн холбогдох асуудлыг тусгадаг байх ёстой хэмээн мунхагладаг болж, хандлага, бичлэгийн аясаа бяцхан өөрчилсөн болой.

Түүх сөхвөөс: Жанчхүү даваа нь /张家口堡 Zhāngjiākǒu bǎo/ Жан Цяа Коу буюу Жан овогтын байлдааны хаалга /Жан овогтны хөндий/ гэсэн утгатай. Монголын эртний түүхтэй “Үнэгэн даваа” нэрээр салшгүй холбоотой газар. 1211 оны эхээр өмнө зүгт Зүрчидийн Алтан улс руу хүлгийн жолоог залсан энэ үйл явдлыг “Монголын нууц товчоо”-ны 247 дугаар зүйлд: “Чингис хаан хонин жил /1211 он/ хятад иргэнийг эзлэхээр морилов. Фужоу/Цагаан хэрмийн ойр байгаа одоогийн Хар балгас/-ыг авч /Чуулалт хаалганаас баруун тийш байгаа/ Үнэгэн даваагаар давж Сюаньдөфу/Датун хотын баруун хойно наяны газар байгаа/-г авч, Зэв, Хуйханаг баатар хоёрыг манлай болгон илгээв. Чингис хаан гол цэргээ авч хүрч ирээд хятадыг хөөж хар хятад, зүрчид, жүйний шилдэг баатар цэргүүдийг дарж, Цавчаалыг хүртэл хятадын цэргийг хиартал хядав. Чингис хаан Шар тээгт буув. Жунду-г эзлэх ба бусад олон хот балгасыг эзлүүлэхээр цэрэг илгээв” гэжээ.

Бээжин хотоос баруун хойш /70 орчим км/ Юань гүрний сүүлчийн хаан Тогоонтөмөр хааны зарлигаар 1342- 1429 онд баригдаж дуусжээ.

Монголчууд “Хаалган хот” гэж товчилж нэрлэдэг нь баруунд “Калган” гэж нэрийддэг. Бээжингийн баруун хойно орших хүзүүвч хот Монголын Нууц Товчоо болон түүхийн бусад эх сурвалжид “Цавчаал боомт” гэж тэмдэглэгдсэн.

Энэ хаалгаар Монголын тал нутаг болон Хятад газрыг холбосон худалдааны зам дамжин өнгөрдөг байсан тул энэхүү хаалгыг тойрон худалдаа, бизнесийҥ хороолол үүсжээ. Яг л энэ цэгээс Хаалган-Их хүрээ-Маймаачныҥ худалдааны их (хятадууд бас хойд торгоны зам гэж нэрлэж байв) зам 1400 орчим км үргэлжилдэг байжээ. Хаалган хот Монголын өмнөд хилийн цэг байсан.

Жанчхүүгийн энэ цамхагт хаалганаас 1-2 км зайд эртнээс "Монгол хуарангийн гудамж" гэж нэрлэгдсэн жижиг гудам бий.

Монгол цэрэг 20 дугаар зуунд хоёрдугаар дайн хийж, 1913 оны “Таван замын байлдаан”-аар Жанчхүүгийн дабааанд тулж очсон бол 1945 оны 8 сарын 19-нд цус асгаруулсан тулалдаанаар Жанчхүүгийн дабааны бэхлэлтийг эзэлж байв.

Монгол Улсын хилээс 565 км зайд, БНХАУ-ын Хэбэй мужийн Жанчхүү хотын Жанбэй хошууны төвөөс урагш 15 км-ийн газарт орших Иеху ууланд Монгол, Зөвлөлтийн цэрэг эрст зориулсан дурсгалын цогцолбор бий. Одоогоос 80 жилийн өмнө хоёр орны цэргүүд энэ газарт Хятадын цэргийн хамтын хүчээр Японы түрэмгийллээс Хятад улсыг чөлөөлснөөр фашизмын эсрэг дэлхийн хоёрдугаар дайныг төгсгөсөн билээ.

Эрээн -Жанчхүү, Жэхэ Долнуур чиглэлд давшсан Чөлөөлөх дайны шийдвэрлэх тулалдаан Жанчхүүд болсон бөгөөд Жанчхүүгийн тулалдааныг хятадууд “Лангуогоу ажиллагаа” гэж нэрлэдэг.

Дайсны гол бэхлэлтийг сэтлэх байлдаан 1945 оны 8-р сарын 14-ний өдрөөс эхэлж, 19-21-ний өдрүүдэд ширүүн тулалдаан болсон билээ. Жанчхүүгийн чиглэлийн давших чиглэлд Японы томоохон хүч байрлаж байсан бөгөөд дайсны хамгийн том хориглолт зохион байгуулсан түшиц газар тэрхүү Жанчхүүгийн даваа байжээ.

Жанчхүүгийн дабааанд Япончууд 1935-1945 оны хугацаанд 40 мянган хятад иргэдийг дайчлан 35 км урт, 10 км гүн бэхлэлтийн бүс байгуулснаар түүнийгээ “Давагдашгүй цайз” хэмээн үзэж байсан.

Уг бэхлэлт нь олон тооны бэхэлгээт байр, их буу, пулемётын нууц галын цэг бүхий, тухайн үедээ хамгийн сүүлийн үеийн цэргийн хориглолтын техник хэрэгсэл, системээр өвч тоноглогдсон газар доогуур харилцах суваг, цэргийн байр, сум хэрэгслийн агуулахтай байсан.

Энэхүү хамгаалалтаа улам бүр төгс болгож, явган цэрэг хориглох хоёр давхар утсан тор, танк эсэргүүцэх өргөн гүн шуудуугаар тойруулж, орж болох гарц, тойрч болох жим бүрийг минажуулжээ.

Жанчхүүгийн даваа нь хойд талдаа Чуулалт хаалга орох төв замыг халхалсан японы армийн хувьд гол түшиц газар нь байсан юм. “Жанчхүүгийн давагдашгүй цайз”-ыг давах үүрэг Зөвлөлтийн 27-р мото буудлагын бригад, Монголын ардын цэргийн хурандаа Нянтайсүрэнгийн командалсан 7-р

мото механикжуулсан хуягт бригадад оногджээ.

Олон мянган хятад хүний цус хөлсийг арваад жил асгаруулж барьсан тэр цайзын талаар хамтарсан цэргийн хүчин бараг ямар ч мэдээлэлгүй байсан гэдэг.

Япончууд бэхлэлтийн зурвас руу нэвтрэх ганц гүүрийг Монгол-Зөвлөлтийн цэрэг дамжин орсны дараа дэлбэлж, хоёр орны цэргийг “Мухар шуудай”-д хийж устгах төлөвлөгөөтэй байсан нь хожим тодорхой болжээ.

Гэвч хамтарсан цэргийн хүч бэхлэлтийг сэтэлж нийт 860 гаруй япон армийн албан хаагчийг устгаж, шархдуулан олзолсон бол өөрсдөө 87 хүнээ алджээ. Тэдний 13 нь Монголын дайчин баатар эрс юм.

1.Лувсанцэрэнгийн Аюуш
*2.*Магсарын Жанчив
*3.*Б.Сахьяа
*4.*Манлайн Жүгдэр
*5.*Пэлжээн Нямаа
*6.*Гомбосүрэнгийн Дашдондог
*7.*Тувааны Самданжамц
*8.*Цэрэннадмидын Маамуу
*9.*Доон Дагва
*10.*Гүнээн Лхамрагчаа
*11.*Галсангийн Чулуунбат
*12.*Сандагийн Шагдар
*13.*Батын Пүрэв

Миномёт салааны байлдагч Д. Данзанваанчиг, байлдагч Д. Цэрэндорж нар дайсны хүнд пулемётын 2, хөнгөн пулемётын 3 цэгийг сөнөөжээ. Д. Данзанваанчиг хүнд шархадсан ч үргэлжлүүлэн тулалдсаар байсан гэдэг.

Ахлагч Дүүдэйн салаа манлайлан давшиж, дайсны хориглолтыг хамгийн түрүүнд сэтэлсэн бөгөөд пулемётын галын цэг 10 гаруйг устгасан юм.

Тулалдааны үеэр тус салааны байлдагч-хөнгөн пулемётчин Л.Аюуш урагш давшин байлдаж, хүнд шарх дараалан авч байсан боловч алхам ч ухралгүй тулалдсаар амь үрэгджээ. Түүний сум дуусахад пулемётын гол төмрөө салган авч гардан тулалдсан байсныг нүдээрээ харсан дайчид дурсдаг. Тэрбээр 11 шархдаж, сүүлчийн дусал цусаа ч эх орныхоо төлөө өргөсөн юм.

Дэлхийн дайныг туулж, хатан зориг, хатуу ширүүнийг ханатал үзсэн орос цэргүүд ч Л. Аюушийг бахдан, толгой сэгсэрч байсан гэдэг.

Холбооны тасгийн ахлах түрүүч М.Жанчив дайсны галын дор үүргээ гүйцэтгэж явахдаа хүнд шархадсан учир холбооны тасарсан хоёр үзүүрийг нийлүүлэн шүдэндээ зууж, холбоог сэргээгээд нас баржээ.

Амь үрэгдэгсдийн гэгээн дурсгалд зориулж БНХАУ нь 1945 онд Монгол - Зөвлөлтийн дайчдад зориулсан хөшөө босгосон бол 1957 онд БНХАУ-ын Төрийн зөвлөлийн шийдвэрээр хөшөөг цамхаг болгон шинэчилсэн байна.

Энэхүү дурсгалт цогцолбор нь 13 га газрыг хамарсан. 28.8 метр өндөр, 360 хавтгай дөрвөлжин метр талбайг эзлэн улаан гурван таван хошуу бүхий орой болон гурван улсын төрийн далбааг сийлсэн нь дэлхийн хүн төрөлхтний эв найрамдлыг билэгдсэн юм. Цамхгийн хананд дайнд оролцож яваад амь үрэгдсэн Оросын 53, Монголын 13 цэргийн нэрсийг

сийлсэн байсан бол шинэчлэн Монголын 56, Зөвлөлтийн 67 дайчны нэрийг мөнхжүүлжээ.

Цамхгаас цааш 100 метр явахад амь үрэгдсэн баатруудын бунхан байх бөгөөд энд зургаан Монгол, 54 Орос, нийтдээ 60 хүний шарил байна.

3 өдөр үргэлжилсэн дайны талбар болсон энэ газарт мөн музей байгуулжээ. Музейд чөлөөлөх дайны үйл явцыг харуулсан түүхэн зураг, диорам, зэвсэг хувцас хэрэгсэл зэрэг эд өлгийн зүйлсийг дэлгэн байрлуулжээ.

Ерөнхийлөгч У.Хүрэлсүх тус цогцолборт байрлах Монгол-Зөвлөлтийн дайчдын дурсгалын музейд 1945 онд Чөлөөлөх дайнд ялалт байгуулсны дараа Маршал Х.Чойбалсан Жанбэй хошуу болон Цагаан хэрэм хүрсэн, мөн Монгол-Зөвлөлтийн цэргүүдийн тухайн үеийн түүхэн гэрэл зургуудыг дурсгав.

Монгол дайчдаас ганцхан Л.Аюуш баатрын зураг байх ба зэвсэг, хувцас хэрэгсэл зэрэг эд өлгийн зүйлсийг Монголоос, Монгол цэргийн музейгээс бэлтгэн бэлэглэжээ.

Барилга байгууламж нь сүрлэг сайхан ч дотоод үзмэр, дэглэлт нэг л тиймхэн санагдсаныг нуух юун.

Энэ цогцолбор Хэбэй мужийн Соёлын өвийн тусгай хамгаалалтад хамгаалагдаж байна.

Чөлөөлөх дайнд МАХЦ-ийн талаас амь үрэгдсэн дайчдын талаар хэд хэдэн тоо баримт явдаг бөгөөд бид л эцэслэн үнэнийг тогтоох ёстой бөгөөд маргалдах мэтгэлцэх, нэгнийгээ үгүйсгэх ямар ч зорилгогүй болой.

“Нийтдээ 122 хүний хохирол амссан. Үүнээс яг дайны үеэр амиа алдсан 10 орчим цэрэг бий. Үүн дээр нэмээд шархадсан сураггүй алга болсон цэргүүдээ нэмэхээр 120 орчим болдог” гэж доктор Т.Сүхбаатар тодорхойлсон бол, доктор С.Ганболд “200 орчим хүний хохирол үзсэн” гэсэн байдаг.

МАХЦ-ийн дайны хохирол: амь үрэгдсэн офицер -4, байлдагч-53, шархадсан байлдагч-125 гэж /Российско-Монгольское военное сотрудничество (1911-1946). Сборник документов. Часть-2. Москва., 2019/. /Русский архив. Т.18(7(1). С.386)/ архивын баримтад дурьдсан байдаг.

Мөн Жанчхүүгийн даваанд амь үрэгдсэн дайчдын хувьд ч 3 өөр тоо яригддаг. Түүхч Р.Болд “11 дайчин”, түүхч Т.Сүхбаатар “12 дайчин”, харин хөшөөн дээр 13 хүний нэр бичээстэй байсан билээ.

Чөлөөлөх дайнд Хилийн цэрэг, хилчдийн оролцооны талаар хилийн цэргийн ганц нэг хүн л ярихаас манай цэргийн түүхчид ор дурсдаггүй билээ. 9 хилийн отрядаас 9 тусгай бүлэг /групп/ Монгол-Зөвлөлтийн армиудын давшилтыг хангах, байлдаанд орсон анги, нэгтгэлийн ард талд тагнуул, хорлог сүйтгэх бүлэг нэвтрэхээс хамгаалах, журам дэглэм сахиулах, хилийн ойролцоо суурьшсан Японы заставуудыг устгах, амьд хэл баривчлах, чөлөөлсөн нутгууд дээр тусгай группүүдийг томилон явуулж тэнд суурьшиж, нуугдан хоцорсон Японы зэвсэгт бүлэглэлүүд, тагнуул, хорлон сүйтгэгч нарыг илрүүлэн баривчлах буюу устгах,

чөлөөлөгдсөн нутгийн ард иргэдийн амгалан тайван байдлыг хангах, тэдний дунд БНМАУ-ын төрийн бодлогыг ойлгуулан таниулах, сурталчлах зэрэг онцгой үүргүүдийг биелүүлсэн юм.

Чөлөөлөх дайны ялалтыг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд ХХБ-ын зүгээс Хилийн 0184 дүгээр ангид байрлах Монгол-Зөвлөлтийн цэргийн бүлэглэлийн командлагч, армийн генерал А.И.Плиевийн хөшөөнд хүндэтгэл үзүүлж, орон нутагт сурталчлах, ХЦ-ийн 0168 дугаар ангийн хариуцсан хэсэгтэй залгаа БНХАУ-ын Улаанцав аймгийн төв Бат хаалга хотод орших “Чөлөөлөгч Монгол цэрэг” хөшөөнд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг хамтран зохион байгуулах нь Хилчдийн баатарлаг үйлсийг сурталчлах томоохон арга хэмжээ болно гэж үзэж байна. /Заавал 9 дүгээр сард амжуулах гэж яарах хэрэггүй, бэлтгэлээ хангаад ондоо багтаах/

Монголчууд “Чөлөөлөх дайн”, Оросууд “Манжуурын стратегийн давшилт” гэж нэрлэдэг бол Хятадууд “Чөлөөлөх дайн” гэдэг нэршилд нэн дургүй, “Дэлхийн 2 дугаар дайны төгсгөл, Японы милитаристуудыг ялсан дайн” гэх. Үнэхээр л чөлөөлсөн юм чинь нэг их эмзэглээд байх зүйлгүй мэт. Одоо л “улны” болчихсон болохоос биш...”Түүхийг ялсан нь төдийгүй хүчтэй нь бичиж байна” гэсэн Цэрэнжавын Дэмбэрэлтэй санал нэг байгаа юм.

Энэ томилолт-аялалд Хилчид, ДХИС-иа төлөөлж, ДХИС-ийн дэд бөгөөд эрдэм шинжилгээ, инновацын газрын дарга, цагдаагийн хурандаа С.Гантулга, Хилийн албаны сургуулийн штабын дарга, дэд хурандаа Х.Мөнх-Эрдэнэ, Дотоодын цэргийн тэнхимийн багш, ахмад Б. Ариунтөгс, Усан спорт, сургалтын төвийн дарга, дэд хурандаа Н.Үербаатар, Олон нийттэй харилцах төвийн найруулагч-графикч, ахлах дэслэгч Г.Энхсайхан болон миний бие, төрөл сургуулиудын 10 сонсогч оролцсон билээ.

УБ-Замын-Үүд-Эрээн-Жанчхүү хот-Жанчхүүгийн даваа гэсэн замналаар ирж, очихын 2500 км үргэлжлэх аян замын уртад бие биеэ таних, мэдэх, ойлголцох өргөн боломжийг олгосон бөгөөд Г.Энхсайханы маань нууц авьяас тодорч, олон байгууллагын төлөөлөл дунд уянгат сайхан дуу хоолойгоороо биднийхээ нүүрийг тахалж явсанд талархууштай.

Оюутан сонсогчид маань зохион байгуулалт, цаг барих, хувцаслалт зэргээрээ ижил төст сургуулийнхаа тэргүүнд нь байлаа. Генерал Ж.Болдбаатар, Танай сургуулийн сонсогч нарын сонголт маш сайн байлаа, ялангуяа монголжуу царай төрхтэйгөөрөө ялгарч байлаа хэмээн магтаж байсныг дурдахад таатай байна. Гадаад арга хэмжээнд оролцогчдод тавигдах, анхаарах л ёстой шалгуур байна шүү.

Энэ арга хэмжээг гол зохион байгуулагч, БХЯ-ны Гадаад хамтын ажиллагааны ахлах мэргэжилтэн, хошууч Э.Мөнхзаяа маань энэ их хариуцлагатай, хүндэтгэлтэй арга хэмжээний ард нэр төртэй гарахын зэрэгцээ буцах замд “дэд хурандаа”

цолоор шагнагдсан баяртай мэдээг хамт хуваалцах боломж гарсанд бид баярласан. Хүний хөдөлмөрийг тухайн үед нь үнэлэн урамшуулах нь сонсогчдод нэгийг бодогдуулж, хоёрыг ухааруулсан, амьдралын нэгэн томоохон сургууль болсон байх аа.

Жанчхүүгийн даваан дахь Монгол-Зөвлөлтийн дайчдын хөшөөнд хүндэтгэл үзүүлэх Төрийн ёслол хүндэтгэлийн өндөр дээд арга хэмжээнд оролцсон цэргийн багийн бүрэлдэхүүнийг Монгол Улсын Батлан хамгаалахын сайд Б.Батлутын тушаалаар “Бид ялав” медалиар шагнасан болохыг сонордуулахад таатай байна.

Шалганы хилийн төлөөлөгч, ХЦ-ийн 0108 дугаар ангийн захирагч, хурандаа В.Хундагаа маань бидний хөгжмийн зэвсэг, телевизийн шууд нэвтрүүлгийн тоног төхөөрөмж, ёслолын хувцас зэрэг овор ихтэй, эмзэг, нандин тээшийг улсын хилээр хялбаршуулсан журмаар нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж, цаг хугацаа, хүч хөлсөө хэмнэх боломж олгосонд цэргийн багийн зүгээс онцгойлон талархаж байгаа болно.

Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын хүний нөөцийг бэлтгэх чиг үүрэг бүхий үндэсний хэмжээний их сургуулиудын профессор багш, сонсогчдын төлөөлөл энэхүү түүхэн газар биечлэн очиж, хүндэтгэл үзүүлэх арга хэмжээнд оролцсон нь залууст цэрэг-эх оронч үзэл төлөвшүүлэх, эх түүхээ танин мэдэх, түүгээр бахархах, Монгол цэргийн суу алдрыг үргэлжлүүлэхэд ихээхэн ач холбогдолтой болсон билээ.

МОНГОЛ УЛСЫН ДОТООДЫН ЦЭРГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТ

М.МӨНХТАМИР
Дотоод хэргийн их сургуулийн Эрх зүйн магистрын хөтөлбөрийн 7011 дүгээр дамжааны магистрант, ахлах дэслэгч

Хураангуй:Дотоодын цэрэг нь тайван цагт бие даан үйл ажиллагаа явуулдаг, үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий төрөл мэргэжлийн цэрэг бөгөөд Монгол Улсын төр, цэргийн түүхтэй салшгүй холбоотой юм. Түүхэн хөгжлийн явцад Хүннү гүрнээс эхлэн 1911 оны Богд хааны зарлигаар "Дотоодыг хамгаалах шадар цэрэг", 1922 онд Жанжин Д.Сүхбаатарын санаачилгаар тасаг цэргийг бүрдүүлснээр өнөөгийн Дотоодын цэргийн үндэс суурь тавигдсан.

Дотоодын цэргийн байгууллага нь 1995 онд анхны бие даасан хуулиа өлгийдөн авч, 2014 онд татан буугдаж, 2017 онд дахин байгуулагдан хуульд заасан тусгайлсан чиг үүргийг гүйцэтгэж байна. Энэхүү судалгаа нь Дотоодын цэргийн хууль эрх зүйн хөгжил, хэрэгжилтийн явцыг харьцуулан судлах замаар байгууллагын цаашдын хөгжлийн чиглэлийг тодорхойлоход оршино.

Түлхүүр үгс: Дотоодын цэрэг, хууль, үүсэл хөгжил, хуулиар хүлээсэн чиг үүрэг, хуулийн хэрэгжилт.

Abstract: The Internal Troops constitute a specialized branch of the armed forces that operates independently in peacetime and plays a critical role in safeguarding national security. Their formation and development are inseparably intertwined with the history of the Mongolian state and its military traditions.Historically, the origins of the Internal Troops may be traced back to the Xiongnu Empire. Later, in 1911, by decree of Bogd Khan, the “Internal Protection Guard Troops” were established, and in 1922, at the initiative of Commander D. Sükhbaatar, a military detachment was organized, thereby laying the foundation for the present-day Internal Troops.The organizational framework of the Internal Troops was formalized through the adoption of their first independent law in 1995. The force was subsequently dissolved in 2014 but re-established in 2017, resuming its legally prescribed specialized functions.This study seeks to examine the legal evolution and implementation of the Internal Troops in a comparative context, with the aim of identifying strategic directions for the institution’s future development.

Keywords: Internal Troops, Legislation, Historical Development, Legal duties ,Law enforcement

Үндэслэл:Монгол Улсын Дотоодын цэргийн байгууллага нь улсын онц чухал объектын хамгаалалт, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хуулиар тогтоосон бусад үүргийг хэрэгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Тус байгууллагад тавигдах шаардлага, үүргийн цар хүрээ, үйл ажиллагааны нягтрал нь нийгмийн нөхцөл байдал, хууль эрх зүйн орчин, аюулгүй байдлын эрсдэлтэй уялдан өдөр бүр өсөн нэмэгдэж байна.Түүнчлэн Дотоодын цэргийн

хөгжлийн үе шат, эрх зүйн шинэчлэл, бүтэц зохион байгуулалт, боловсон хүчний бодлогын зохицуулалт зэрэг хүчин зүйлсийг цогцоор нь шинжлэх ухааны аргаар судалсан бүтээл ховор байгаагийн улмаас энэхүү судалгаа нь нийгэм, улс төр, хууль эрх зүйн болон аюулгүй байдлын судалгааны салбарт шинжлэх ухааны үндэслэл бүхий шинэ мэдлэгийг тогтоох шаардлагатай болж байна.

Зорилго: Дотоодын цэргийн хууль эрх зүйн хөгжлийн үе шатууд, түүний хэрэгжилтийн байдлыг судлан, байгууллагын цаашдын хөгжлийн шинжлэх ухааны үндэслэл бүхий чиглэлийг тодорхойлох.

Зорилт:

1. Дотоодын цэргийн тухай хуулиудын (1995, 2017) зорилго, зорилт, агуулгыг харьцуулан судлах
2. Хуулиудын үйл ажиллагааны зарчим, гүйцэтгэх чиг үүрэг, алба хаагчийн эрх, үүргийн өөрчлөлт, хэрэгжилтийн байдлыг судлах.
3. Алба хаагчдын хууль эрх зүйн мэдлэгийн түвшнийг үнэлж байгууллагын үйл ажиллагааны үр нөлөөг тодорхойлох
4. Судалгааны үр дүнгээр тулгамдаж буй асуудлыг тодорхойлж цаашдын хөгжлийн чиглэлд зөвлөмж боловсруулах

Үндсэн хэсэг: Дотоодын цэргийн түүхэн хөгжил

Орчин цагийн Дотоодын цэрэг нь түүхэн хөгжлийнхөө хугацаанд 1994 он хүртэл Дотоодыг хамгаалах газар, Нийгмийн аюулаас хамгаалах яамны Хилийн ба Дотоодын цэргийн удирдах газар, Улсын цагдан сэргийлэх ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газрын харьяанд, 1995 оноос Дотоодын цэргийн тухай хууль батлагдан хэрэгжиж эхэлснээр штаб, мэргэжлийн анги, тусгай салбар, салааны бүтэц, зохион байгуулалттайгаар алба-ажиллагаагаа явуулж ирсэн 104 жилийн түүхтэй, тайван цагт мэргэжлийн бие даасан үйл ажиллагаа явуулдаг Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй төрийн цэргийн байгууллага юм.

Улс орны нийгэм, эдийн засгийн байдал болон бусад хүчин зүйлийн улмаас 2014 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр Дотоодын цэргийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцож (хууль Д. ц., 2017), байгууллагыг татан буулгаж, үндсэн бүрэлдэхүүний офицер, ахлагчийг Цагдаагийн байгууллагын Олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны харьяанд, хугацаат цэргийн алба хаагчдыг Хил хамгаалах ерөнхий газарт шилжүүлсэн байна.

Дотоодын цэргийг дахин байгуулах эрх зүйн үндэслэл

Аливаа улс гүрэн өөрийн аюулгүй байдлын гадаад орчин, гео стратегийн байршил, улс орныхоо эдийн засгийн чадавх, түүхэн уламжлал зэргээс хамааран эвсэлд нэгдэх, том гүрнийг түших, төвийг сахих, гуравдагч хүчинд тулгуурлах, бүс нутгийн тогтолцоонд нэгдэх, бие даах зэргээр аюулгүй байдлаа хангах арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.

Үүний жишгээр Монгол Улсын Их Хурлын 2015 оны 85

дугаар тогтоолоор баталсан (үндэс, 2015) "Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс" баримт бичгийн долоодугаар зүйлийн 7.1-д "Монгол Улсын төрийн цэргийн байгууллага нь тайван цагт Зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллагаас бүрдэнэ", мөн 7.3-т "Тайван цагт Дотоодын цэрэг нь бие даасан үүрэг гүйцэтгэх бөгөөд бүтэц, чиг үүргийг хуулиар тогтооно" гэж тус тус заасан.

Мөн Зэвсэгт хүчний тухай хуулийн долоодугаар зүйлийн 7.2-т (тухай З. х., 2016) "Дайны байдал зарламагц дотоодын цэрэг зэвсэгт хүчний бүтцэд шилжиж, үүрэг гүйцэтгэнэ", Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6-д "Зэвсэгт хүчин, бусад цэрэг" (тухай Ү. а., 2001) гэж тус тус заасны дагуу Дотоодын цэрэг нь Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллага байхаар хуульчилсан байна.

Үүний дагуу төр засгаас Дотоодын цэргийн байгууллагыг дахин байгуулах (тогтоол, 2021) нь зүйтэй гэж үзсэний үндсэн дээр шийдвэр гаргаж, Улсын Их Хурлаас 2017 онд Дотоодын цэргийн тухай хуулийг баталж, гүйцэтгэх чиг үүрэг, эрх хэмжээг хуульчилж мөн оны арван есдүгээр сарын нэгний өдрөөс эхлэн мөрдөж, хэрэгжилтийг нь ханган ажиллаж байна.

1995, 2017 оны хуулиудын харьцуулалт

Зорилго, зорилтын харьцуулалт

1995 оны хуулийн зорилго нь Монгол Улсын Дотоодын цэргийн тогтолцоо, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршиж байсан бол 2017 оны хуулиар зорилгыг өргөжүүлэн, дотоодын цэргийн тогтолцоо, чиг үүрэг, бүрэн эрх, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино гэж тусгасан нь байгууллагын бие даасан байдлыг илүү тодорхой харуулж байна.

Хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтүүд

2003 онд Дотоодын цэргийн тухай хуульд анхны нэмэлт, өөрчлөлт оруулахдаа 14.1 дүгээр зүйлд хязгаарлагдаж байсан бол 2023 онд 31 дүгээр зүйлд "Дотоодын цэргийн байгууллага нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн цэргийн байгууллага мөн" гэж нэмсэн нь 2016 онд батлагдсан Монгол Улсын Батлан хамгаалах тухай (хууль., 2016) хуулийн найман дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт 2022 оны зургаадугаар сарын 28-ны өдөр "төрийн цэргийн байгууллын тогтолцоо нь тайван цагт зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, онцгой байдлын байгууллагаас бүрдэнэ" гэсэн нэмэлттэй холбогдон оруулжээ.

Мөн дөрөвдүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн 4.1.1 заалтад "Дотоодын цэргийн алба хаагч" гэх ойлголтыг тодруулан, цэргийн тангараг өргөж, дотоодын цэргийн

анги, байгууллагад ажиллаж байгаа цэргийн жинхэнэ алба хаагчийг хамруулах болсон нь субъектийн цар хүрээг нэмсэн хэрэг юм. Харин 4.1.2 заалтын "Дотоодын цэргийн гэрээт алба хаагч" гэсэн ойлголтыг хассан нь таван дугаар анги 17 тусгай салбарт байнгын бүрэлдэхүүний 2000 гаруй офицер, ахлагч бүрэлдэхүүнтэйгээр хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтийг хангаж байгаатай холбоотой юм.

Дөрөвдүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн 4.1.4 заалтад "Объектын хамгаалалт" гэх ойлголтыг объектын хэвийн ажиллагааг хангах, халдлагаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хамгаалж байгаа объектод нэвтрэх хүн, эд зүйл, тээврийн хэрэгслийг шалгах, хамгаалалтын бүсэд тогтоосон дэглэм, журмыг сахиулах цогц үйл ажиллагаа гэж тодорхойлсон нь тус хуулийн арван нэгдүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн 11.1.4-т заасан шаардлагатай зарим объектыг түр хугацаагаар хамгаалах чиг үүргийн хэрэгжилттэй нийцүүлсэн юм.

Долоодугаар зүйлийн 7.3 дах хэсэгт "Дотоодын цэрэг нь төрөлжсөн болон дэмжлэг үзүүлэх мэргэжлийн нэгжтэй байж болно" гэж нэмсэн нь террорист үйлдлийг таслан зогсоох 809 дүгээр ангиас гадна барилга, байгууламж, инженерийн дэд бүтэц, байгаль орчны сэргээн босголт, хамгаалах зорилго бүхий 837 дугаар тусгай салбарыг байгуулах эрх зүйн үндэс болсон.

Мөн хуулийн Есдүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт "Штаб нь дотоодын цэргийг удирдах мэргэжлийн төв байгууллага байна" гэж томьёолсон нь Монгол Улсын батлан хамгаалах тухай хуульд нийцүүлсэн өөрчлөлт болсон байх бөгөөд 9.3 дах хэсэгт Штабын даргаар Цагдаа, Дотоодын цэргийн байгууллагад 15-аас доошгүй жил ажилласан, эрх зүйч эсхүл цэргийн мэргэжилтэй, удирдах болон мэргэжлийн ажлын дадлага туршлагатай Монгол Улсын иргэнийг томилно гэж заасан нь байгууллагын тогтвортой мэргэшсэн байдлыг хангах шалгуур болсон байна.

Есдүгээр зүйлийн 9.4 дэх хэсэгт Штабын дарга нь Командлагчийг түр эзгүйд түүний эрхийн хүрээнд орлох бөгөөд гаргасан шийдвэрийнхээ хууль зүйн үр дагаврыг өөрөө хариуцна гэж тодотгосон. Мөн 9.5 дэх хэсэгт Командлагч өөрийн эрхийн зарим хэсгийг Штабын даргад тушаалаар шилжүүлж болох боловч энэ нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй гэж заасан нь удирдлагын болон хууль зүйн хариуцлагын тогтолцоог сайжруулж, тодорхой болгосон байна.

Арван хоёрдугаар зүйлийн 12.5 дах хэсэгт объектын хамгаалалтад уртасгасан цагаар үүрэг гүйцэтгэх бүрэлдэхүүний ажиллах хугацааг Командлагч тогтооно гэж заасан нь Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дох хэсгийн 8.2.2-ын хэрэгжилтийг хангасан байна.

Гучин гурван дугаар зүйлийн 33.1 дэх хэсгийн 33.1.10 дах заалтад хамгаалалтад байгаа объектын ойр

орчимд илэрсэн сэжиг бүхий хүн, тээврийн хэрэгсэлд үзлэг хийх, бичиг баримтыг шалгах, гаргасан зөрчлийг шийдвэрлэх, шаардлагатай тохиолдолд цагдаагийн байгууллагад шилжүүлэх эрхийг нэмсэн нь Зөрчлийн тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.62-т 2023 онд орсон нэмэлттэй холбоотой бөгөөд мөн зүйлийн 33.1.11 дэх заалтад хот, суурины дотор такси үйлчилгээнээс бусад нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих эрхийг нэмсэн нь байгууллагын үйл ажиллагааны шуурхай байдлыг хангах, алба хаагчдын нийгмийн баталгааг сайжруулж өгсөн байна.

Гучин гурван дугаар зүйлийн 33.3 дах хэсэгт энэ хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ Цагдаагийн албаны тухай хуулийн 22, 23, 24, 25, 26, 27, 29, 31, 32, 33, 40, 43, 44, 45 дугаар зүйлд заасан цагдаагийн алба хаагчийн тодорхой ажиллагаа явуулах журмыг мөрдөнө гэж заасан нь арван нэгдүгээр зүйлд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг тодорхойлсон байна.

Гучин зургаадугаар зүйлийн 36.3 дах хэсэгт Дотоодын цэргийн алба хаагчийн ажилласан нэг жилийг нэг жил гурван сараар тооцно гэж өөрчилсөн нь 1995 оны хуульд зөвхөн тодорхой объектын хамгаалалтад үүрэг гүйцэтгэж байгаа бүрэлдэхүүний ажилласан жилийг нэмэгдүүлэн тооцдог байсныг бүх алба хаагчид дээрх баталгаа нэгэн адил үйлчлэхээр өөрчилсөн нь эрх зүйн баталгааг нэмэгдүүлсэн болохыг харуулж байна.

Гучин зургаадугаар зүйлийн 36.7 дах хэсэгт Дотоодын цэргийн алба хаагчийг албан үүргээ гүйцэтгэж байх үед албадан саатуулах, цагдан хорих, баривчлах, албан тасалгаа, унаа болон биед нь үзлэг нэгжлэг хийх тохиолдолд тухайн алба хаагчийг шууд захирах даргад мэдэгдэнэ гэж нэмсэн нь алба хаагчийн хуулиар хүлээсэн чиг үүргээ тасралтгүй хэрэгжүүлэх эрх зүйн баталгааг хангах зорилготой байна.

Гучин найман дугаар зүйлийн 38.3 дах хэсэгт хүнсний болон эдийн хангалт, сургалтын байр, сургалт, бэлтгэл, холбоо, мэдээлэл технологийн үйл ажиллагаа, судалгаа шинжилгээ, хамгаалах болон тусгай хэрэгсэл, хөдөлмөрийн аюулгүй байдлын хувцас, техник хэрэгслийн зардлыг улсын төсөвт тусгаж санхүүжүүлнэ гэж нэмсэн нь алба хаагчдын үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх баталгааг хангах зорилготой юм.

Гучин найман дугаар зүйлийн 38.4 дах хэсэгт Улсын онц чухал объектын хамгаалалтын найдвартай аюулгүй байдлыг хангах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор хамгаалуулагч байгууллагын нэмэлт санхүүжилт авч болох бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батална гэж нэмсэн нь улсын төсөвт хүндрэл үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилготой байна.

Үйл ажиллагааны зарчмын харьцуулалт

1995 оны хуульд хууль дээдлэх, хүний эрх эрх чөлөөг хүндэтгэх, нууцыг чандлан хадгалах гэсэн гурван зарчмыг

тусгасан байсан бол үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх чиглэлд удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр баримтлах зарчмыг тодотгоогүй байсан.

2017 оны хуулиар эдгээр гурван зарчмын хажуугаар нэгдмэл төвлөрсөн удирдлагатай байх, захирах захирагдах, хамгаалалт аюулгүй байдлыг уян хатан тасралтгүй зохион байгуулах зэргийг нэмсэн нь Монгол Улсын Батлан хамгаалах тухай, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулиудад тусгасан зарчмын хэрэгжилтийг хангах зорилготой байна.

Гүйцэтгэх чиг үүргийн харьцуулалт

1995 онд батлагдсан хуулийн есдүгээр зүйлд Дотоодын цэргийн байгууллага гурван үндсэн чиг үүрэгтэй байхаар тусгасан байсан. Үүнд: улсын онц чухал объектыг хамгаалах, байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон үйлдвэрлэлийн осол, гал түймэр, хүн малын гоц халдварт өвчин гарсан үед аврах ажилд болон хорио цээрийн дэглэм сахиулахад оролцох, шаардлагатай үед зарим объектыг түр хугацаагаар хамгаалах, зорчигч ачаа тээшийг тээврийн замд харгалзан хүргэх зэрэг орж байв.

2017 оны хуульд эдгээр эрхийг өргөжүүлэн, хамгаалалтад байгаа объект бүсэд нэвтрэх хүний бичиг баримтыг шалгах, түүний бие эд зүйл тээврийн хэрэгсэл ачаа тээшинд үзлэг хийх, иргэн хуулийн этгээдэд хууль тогтоомж нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актаар тогтоосон дүрэм журмыг биелүүлэх хууль бус үйлдлээ таслан зогсоох талаар шаардлага тавих, гэмт хэрэг зөрчил үйлдсэн этгээдийг түр саатуулах түүнийг цагдаагийн байгууллага албан тушаалтанд шилжүүлэх, хамгаалж байгаа объектод халдсан хууль бусаар нэвтрэн орохыг завдсан этгээдийг мөрдөн хөөх түр хугацаагаар саатуулах цагдаагийн байгууллага албан тушаалтанд шилжүүлэх, чиг үүргээ хэвийн гүйцэтгэхэд шаардлагатай мэдээлэл авах хамгаалалтыг сайжруулахтай холбогдсон саналыг объектын захиргаа болон холбогдох байгууллагад тавих, чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор хамгаалалтад байгаа объектод өдөр шөнийн аль ч цагт чөлөөтэй нэвтрэх гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хамгаалалтын бүс дэх сэжиг бүхий тээврийн хэрэгсэл эд зүйлд үзлэг хийх, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын даргын шийдвэрээр хамгаалалтад байгаа объектод хууль бусаар нэвтэрсэн этгээдийг олж тогтоох халдлага гэнэтийн аюул ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор хамгаалалтад байгаа объектыг бүслэн хаах уг бүсэд байгаа иргэний бичиг баримтыг шалгах эд зүйлд үзлэг хийх, гэмт хэрэг зөрчлийн эд мөрийн баримт болох эд зүйлийг хуульд заасны дагуу түр хураан авах эрх бүхий байгууллага албан тушаалтанд хүлээлгэн өгөх, гэмт хэрэг зөрчил үйлдэгдсэн эсхүл аюул учирч болзошгүй тохиолдолд хамгаалалтад байгаа объектод хүн тээврийн хэрэгсэл нэвтрүүлэхийг хязгаарлах, хамгаалалтад байгаа

объектын ойр орчимд илэрсэн сэжиг бүхий хүн тээврийн хэрэгсэлд үзлэг хийх бичиг баримтыг шалгах гаргасан зөрчлийг шийдвэрлэх шаардлагатай тохиолдолд цагдаагийн байгууллагад шилжүүлэх зэрэг эрхүүдийг нэмж өгсөн байна.

Энэ нь гүйцэтгэх чиг үүргийн цар хүрээг нэмэгдүүлсэнтэй холбогдуулан эдлэх эрх, эрх зүйн баталгааг нэмэгдүүлэн тодорхойлсон хэрэг юм.

Алба хаагчийн үүргийн харьцуулалт

1995 оны хуульд Дотоодын цэргийн алба хаагч нь хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хүлээх үүргийг тусгаагүй байсан бол 2017 оны хуульд Дотоодын цэргийн алба хаагч Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн зургаадугаар зүйлд заасан нийтлэг үүргийг хүлээнэ, гэмт хэрэг зөрчилд холбогдон шалгагдаж байгаа бол энэ тухай шууд захирагдах албан тушаалтанд мэдэгдэх үүрэгтэй, хуульд зааснаас бусад тохиолдолд хувь хүн байгууллагын нууцтай холбоотой мэдээллийг хайх цуглуулах хэрэглэх тараахыг хориглоно гэж тодорхой заасан.

Энэ нь Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай, Байгууллагын нууцын тухай, Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулиудын хэрэгжилтийг хангах хууль дээдлэх зарчмыг бататгасан юм.

Алба хаагчийн эрх зүй нийгмийн баталгааны харьцуулалт

1995 оны хуульд Дотоодын цэргийн алба хаагчдын ажилласан хугацааг тооцоход зөвхөн гяндан хугацаагүй хорих салбар онцгой чанга дэглэмтэй хорих ангийн болон төв суурин газраас алслагдсан газрын объектын харуул хамгаалалтад ажилласан нэг жилийг нэг жил хоёр сараар тооцож бусад чиг үүргийн алба хаагчдыг ажилласан жилийг нэмэгдэлгүй байхаар тусгасан байсан. Мөн 1993 онд батлагдсан Цагдаагийн байгууллагын тухай хуулийн гучин долоодугаар зүйлд тусгасан баталгаагаар нэгэн адил хангагдахаар хуульчилсан байна.

2017 оны хуульд Дотоодын цэргийн алба хаагчийн ажилласан нэг жилийг нэг жил гурван сараар тооцно гэж өөрчилж бүх алба хаагчдын эрх зүйн байдлыг тэгш хангасан. Мөн Цагдаагийн албаны тухай хуулийн 83, 84, 85, 86, 87 дугаар зүйлд заасан баталгаагаар нэгэн адил үйлчлэхээр хуульчилсан. Цаашлаад Цэргийн алба хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу тэтгэвэр тогтоолгож тэтгэмж авна, алба хаагчийн хууль ёсны шаардлагыг иргэн хуулийн этгээд биелүүлэх үүрэгтэй, Дотоодын цэргийн хамгаалалтад байгаа объектын захиргаа дотоодын цэргийн алба хаагчийг албан үүргээ гүйцэтгэх нөхцөлөөр хангах үүрэгтэй, Цагдаагийн албаны тухай хуулийн 87.3, 89.2-т заасан баталгаагаар цагдаагийн алба хаагчийн нэгэн адил хангагдана, алба хаагчийг албан үүргээ

гүйцэтгэж байх үед албадан саатуулах цагдан хорих баривчлах албан тасалгаа унаа болон биед нь үзлэг нэгжлэг хийх тохиолдолд тухайн алба хаагчийг шууд захирах даргад мэдэгдэнэ гэх зэргээр нийгмийн баталгааг ихээхэн сайжруулсан байна.


Дотоодын цэргийн байгууллагын алба хаагчдын харьяаллаар авч үзвэл 60,4% Дотоодын цэргийн анги байгууллага, 39,6% Дотоодын цэргийн тусгай салбарт ажиллаж байна (1 дүгээр зураг).

Судалгааны ажлын үр дүн:




1 дүгээр зураг. Дотоодын цэргийн алба хаагчдын харьяаллыг тодорхойлсон байдал
(2025 оны байдлаар)

Дотоодын цэргийн үйл ажиллагааг зохицуулж буй хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдлэгээр нь авч үзвэл 10,2% Маш сайн мэддэг (бүх заалтыг нарийвчлан мэднэ) 53% Сайн мэддэг (үндсэн заалтуудыг мэднэ) 33,2% Дунд зэрэг (зарим заалтыг мэднэ) 3,2% Сул мэддэг 0,4% Огт мэдэхгүй алба хаагч нар байна (2 дугаар зураг).



2 дугаар зураг. Дотоодын цэргийн үйл ажиллагааг зохицуулж буй хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдлэгийг харьцуулсан байдал (2025 оны байдлаар)

Дотоодын цэргийн тухай хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан эрх зүйн актууд /Дотоодын цэргийн алба-ажиллагааны дүрэм, Дотоодын цэргийн алба хаагчийн ёс зүйн дүрэм болон бусад холбогдох хууль/-ын заалтыг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлаар нь авч үзвэл 21,5% Хүний нөөцийн хомсдол, 15% Санхүүжилтийн хүрэлцээгүй байдал, 13,8% Тоног төхөөрөмжийн дутагдал, 1,9% Хуулийн заалт тодорхой бус байдал, 5,9% Мэдлэг, ур чадварын хангалтгүй байдал, 4,4% Зохион байгуулалтын асуудал, 4,4% Сургалтын орчин, 33.1% Бусад сонголтоор байна (3 дугаар зураг).



3 дугаар зураг. Дотоодын цэргийн үйл ажиллагааг явуулахад тулгамдаж буй асуудлыг дэвшүүлсэн байдал (2025 оны байдлаа)

Дүгнэлт:

Дотоодын цэргийн байгууллага нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах, үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх, төрийн цэргийн байгууллага.

1995 оны анхны Дотоодын цэргийн тухай хуулиас эхлэн 2017 оны одоогийн хууль хүртэлх хөгжлийн явцад байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны зарчим, гүйцэтгэх чиг үүрэг, алба хаагчийн эрх үүрэг болон эрх зүйн нийгмийн баталгаа зэрэг бүхий л талаар ихээхэн өөрчлөлт, сайжруулалт хийгдсэн байна.

Үүнд:

Зорилго зорилтын хувьд: 1995 оны хууль нь зөвхөн эрх зүйн үндэс, тогтолцоог тодорхойлсон бол 2017 оны хууль нь зорилго, чиг үүрэг бүрэн эрх үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодотгож өгсөн байна.

Үйл ажиллагааны зарчмын хувьд: 1995 оны гурван зарчмаас 2017 онд зургаан зарчим болж нэмэгдсэн нь удирдлага зохион байгуулалтын тогтолцоог боловсронгуй болгосон үзүүлэлт юм.

Гүйцэтгэх чиг үүргийн хувьд: 1995 онд батлагдсан Дотоодын цэргийн тухай хуульд Дотоодын цэргийн байгууллага нь гурван үндсэн чиг үүрэгтэй байхаар 9 дүгээр зүйлд хуульчлагдсан бол, 2017 онд шинэчлэн батлагдсан уг хуульд 11 дүгээр зүйлд зургаан үндсэн чиг үүрэгтэй байхаар хуульчилж өгсөн.Үүнд:

Нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргийг таслан зогсооход дэмжлэг үзүүлэх, эрэн

хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, террорист үйлдлийг таслан зогсоох тусгай ажиллагаанд оролцох зэрэг үүргүүдийг нэмэлтээр тусгаж өгсөн байна.

Алба хаагчийн эрхийн хувьд: 1995 оны Дотоодын цэргийн тухай хууль гүйцэтгэх чиг үүрэг хязгаарлагдмал байсантай холбогдуулан эдлэх эрх мөн адил хязгаарлагдмал байсныг 2017 оны хуульд нэмэлт өөрчлөлт оруулж өгсөн нь чиг үүргийн хэрэгжилтийг илүү үр дүнтэй боловсронгуй болгож болгож өгсөн байна.

Эрх зүйн нийгмийн баталгааны хувьд: 1995 оны хуульд зөвхөн гяндан, хугацаагүй хорих салбар, онцгой, чанга дэглэмтэй хорих ангийн болон төв суурин газраас алслагдсан газрын объектын харуул хамгаалалтад ажилласан нэг жилийг нэг жил хоёр сараар тооцож, бусад чиг үүргийн алба хаагчдыг ажилласан жилийг нэмэгдэлгүй байхаар тусгаж өгсөн бол 2017 оны хуулиар бүх алба хаагчийн ажилласан нэг жилийг нэг жил гурван сараар тооцох болсон нь эрх тэгш байдлыг хангасан гол өөрчлөлт оруулсан байна.

Судалгааны ажлын үр дүн дээр үндэслэн дараах тулгамдсан асуудлыг дэвшүүлж байна.

Хүний нөөцийн хомсдол: Нийт судалгаанд хамрагдсан алба хаагчдын 21.5% нь хүний нөөцийн хомсдолыг тулгамдсан асуудлыг дэвшүүлсэн. Энэ нь байгууллагын бүтэц, зохион байгуулалтын асуудал болж чиг үүргийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байгааг харуулж байна.

Санхүүжилтийн хүрэлцээгүй байдал: Нийт судалгаанд хамрагдсан алба хаагчдын 15% нь санхүүжилтийн хүрэлцээгүй байдлыг онцолж байгаа нь Дотоодын цэргийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасан төсвийн санхүүжилтийн хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна.

Тоног төхөөрөмжийн дутагдал: Нийт судалгаанд хамрагдсан алба хаагчдын 13.8% нь тоног төхөөрөмжийн дутагдлыг дурдсан нь хамгаалалтын инженер-техникийн хэрэгсэл, тусгай хэрэгсэл зэргийг хангах асуудал шаардлагатай байгааг илтгэж байна.

Хууль эрх зүйн мэдлэгийн түвшин: Судалгаанд хамрагдсан алба хаагчдын 63.2% нь хууль эрх зүйн мэдлэгийн чадвар өндөр байгаа нь эерэг үзүүлэлт боловч 33.6% нь хууль, эрх зүйн мэдлэг дунд, 0.4% нь огт мэдэхгүй байгаа нь алба хаагчдын дунд сургалт, мэдлэг дээшлүүлэх эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх сургалтын тогтолцоог сайжруулах шаардлагатай байгааг харуулж байна.

Зохион байгуулалтын асуудал:Алба хаагчдын мэдлэг ур чадварын хангалтгүй байдал 5.9%, зохион байгуулалтын асуудал болон сургалтын орчин тус бүр 4.4%-аар илэрч байгаа нь байгууллагын дотоод үйл ажиллагааг сайжруулах шаардлагатайг илтгэж байна.

Тус судалгааны үр дүнг үндэслэн Дотоодын цэргийн байгууллагыг гадаадын улс

орнуудын ижил төстэй чиг үүрэг бүхий байгууллагуудын жишигт нийцсэн, бие даан үүрэг гүйцэтгэх чадвартай, мэргэшсэн байгууллага болгон хөгжүүлэхийн тулд:

- Эрх зүйн орчныг илүү нарийвчилсан зохицуулалттай болгох
- Бусад байгууллагаас хараат бус байх бүтэц зохион байгуулалтыг бэхжүүлэх
- Хүний нөөцийг нэмэгдүүлэх, сургалтын тогтолцоог боловсронгуй болгож алба хаагчдын мэргэшлийн дээшлүүлэх.
- Санхүүжилтийн хүрэлцээтэй байдлыг хангах механизмыг боловсронгуй болгох
- Орчин үеийн тоног төхөөрөмж, хамгаалалтын инженер-техникийн хэрэгслээр хангах
- Алба хаагчдын хууль эрх зүйн мэдлэгийг тогтмол дээшлүүлэх.
- Олон улсын туршлагыг үндэсний онцлогт нийцүүлэн хэрэглэх.

Эдгээр арга хэмжээ нь байгууллагын үйл ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлж зорилгыг хэрэгжүүлэхэд шууд чиглэсэн бөгөөд цаашдын хөгжлийн шинжлэх ухааны үндэслэлийг бататгана.

Санал:

Дотоодын цэргийн тухай хуулийг гадаадын улс орнуудыг ижил төстэй чиг бүхий байгууллагуудын алба, үйл ажиллагааг зохицуулдаг эрх зүйн баримт бичгүүдтэй харьцуулан судалсны үндсэн дээр хүний нөөц, санхүү, техник тоног төхөөрөмжийн нөөцийг сайжруулах мөн алба хаагчдын хууль эрх зүйн мэдлэг, мэргэжлийн ур чадварыг тогтмол дээшлүүлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулах шаардлагатай болох нь тогтоогдсон тул дараах саналыг гаргаж байна. Үүнд:

1. Дотоодын цэргийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дах хэсэг “Дотоодын цэрэг нь төрөлжсөн болон дэмжлэг үзүүлэх мэргэжлийн нэгжтэй байж болно” гэж заасны хэрэгжилтийг хангах зорилгоор Цагдаагийн байгууллагад нийтийн хэв журам сахиулах үйд ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үүргийг дагнан гүйцэтгэх томилгоот нэгжийг байгуулах боломжийг судалж, шийдвэрлэх.

2. Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн “Дотоодын цэргийн албаны тэнхим”-ийг Дотоод хэргийн их сургуулийн бүтцэд “Дотоодын цэргийн сургууль” болгон өргөтгөн зохион байгуулах.

3. Алба хаагчдын боловсрол, мэргэжлийн түвшнийг ахиулахад удирдлагын зүгээс анхаарч, ДХИС-ийн Сургалт, эрдэм шинжилгээний газар, мэргэжлийн сургууль, тэнхимийн эрдэмтэн судлаач, багш нартай хамтран “Дотоодын цэрэг судлал”-ын магистр, докторын болон офицер, ахлагч нарыг давтан сургах сургалтын хөтөлбөрүүдийг шинээр боловсруулах.

4. ДХИС-ийн Удирдлагын Академийн сургалтын хөтөлбөрт, Дотоодын цэргийн стратеги судлалын чиглэлээр судлах сэдвийн боловсруулалтыг хийж,

5. мэргэжлийн багшийн орон тоог шийдвэрлэн томилон ажиллуулах.

6. Гадаад орнуудыг ижил төстэй байгууллагуудтай хамтарсан сургалт, дадлагыг зохион байгуулах, урт, богино хугацааны болон мэргэшүүлэх сургалтад хамруулах.

Эх сурвалж:

тогтоол, Д. ц. (2021 оны 11 24). *https://legalinfo.mn/*. https://legalinfo.mn/: https://legalinfo.mn/mn/detail?lawId=16381557327371-ээс Гаргасан

тогтоол., Д. ц. (2014 оны 03 28). *legalinfo.mn*. legalinfo.mn: https://legalinfo.mn/mn/detail?lawId=9862-ээс Гаргасан

тухай, З. х. (2016 оны 09 01). *legalinfo.mn*. legalinfo.mn: https://legalinfo.mn/mn/detail?lawId=12123-ээс Гаргасан

тухай, Y. а. (2001 оны 12 27). *legalinfo.mn*. legalinfo.mn: https://legalinfo.mn/mn/detail?lawId=18-ээс Гаргасан

үндэс, М. у. (2015 оны 10 08). *legalinfo.mn*. legalinfo.mn: https://legalinfo.mn/mn/detail?lawId=206917&showType=1-ээс Гаргасан

хууль, Д. ц. (2017 оны 01 16). *legalinfo.mn*. legalinfo.mn: https://legalinfo.mn/mn/detail?lawId=9753-ээс Гаргасан

хууль, Д. ц. (2017 оны 02 09). *legalinfo.mn/*. legalinfo.mn/: https://legalinfo.mn/mn/detail?lawId=12474-ээс Гаргасан

хууль., М. У. (2016 оны 09 01). *legalinfo.mn*. legalinfo.mn: https://legalinfo.mn/mn/detail?lawId=12122-ээс Гаргасан

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХАД ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ

(Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны дэргэдэх ёс зүйн дэд хорооны жишээн дээр)

Г.ОДБИЛЭГ
Дотоод хэргийн их сургуулийн Эрх зүй нийгмийн ухааны сургуулийн магистрын хөтөлбөрийн 7011 дүгээр дамжааны суралцагч
dz.odbileg8989@gmail.com

Хураангуй: Монгол Улсад төрийн албаны ёс зүйн шинэчлэлийн хүрээнд 2023 онд “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль” батлагдан, 2 жил гаруй хугацаа өнгөрч байна. Уг хуулиар төрийн байгууллага бүрд Ёс зүйн дэд хороо байгуулж, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хянан шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлэхээр зохицуулсан.

Гэвч орон нутгийн түвшинд, тухайлбал дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны дэргэдэх Ёс зүйн дэд хорооны хууль, журмаар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй, тогтолцооны шинжтэй хүндрэлүүд ажиглагдаж байна.

Энэхүү өгүүллийн зорилго нь дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны дэргэдэх Ёс зүйн дэд хорооны чиг үүргийн хэрэгжилтийн өнөөгийн байдлыг судалж, практикт тулгамдаж буй асуудлыг тодорхойлон, цаашид сайжруулах санал, дүгнэлтийг боловсруулахад оршино.

Судалгаанд чанарын судалгааны аргын ярилцлагын, баримт бичгийн шинжилгээний төрлийг, тоон судалгааны аргын харьцуулалтын аргыг тус тус ашиглав.

Түлхүүр үг: Төрийн алба, Ёс зүйн дэд хороо, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба, үүрэг, хариуцлага, хэрэгжилт.

УДИРТГАЛ

Улсын Их Хурлаас 2023 онд батлагдсан Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш 2 жил гаруй хугацаа өнгөрч байгаа бөгөөд 2024 онд улсын хэмжээнд “... 4239 төрийн байгууллагад 2281 ёс зүйн дэд хороо байгуулагдсан. ...” (хороо, 2024), “... нийт 9,855 төрийн албан хаагч ёс зүйн дэд хороонд сонгогдон ажиллаж...” (хороо, 2024) байгаагаас нийслэлийн хэмжээнд 869 байгууллагын 473 ёс зүйн дэд хороо үйл ажиллагаа явуулсан.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалтад “... Ёс зүйн дэд хороо нь байгууллагын албан хаагчийн тооноос хамааран 3-7 гишүүнтэй байх бөгөөд гишүүд дотроосоо даргаа сонгоно...” (хууль, 2023) гэж, Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”-ын 2.4 дэх хэсэгт “... 40 ба түүнээс цөөн төрийн албан хаагчтай байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороо нь 3 гишүүн, 41-90 бол 5 гишүүн, 91-дээш бол 7 гишүүнтэй байна...” (журам,

2024) гэж заасны дагуу "... ёс зүйн дэд хороодын 46.7 хувь нь 3 гишүүнтэй, 40.5 хувь нь 5 гишүүнтэй, 12.8 хувь нь 7 гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж..." (хороо, 2024) байгаа бол Улаанбаатар хотод ажиллаж буй 473 Ёс зүйн дэд хорооны 24.7 хувь нь 3 гишүүнтэй, 41.0 хувь нь 5 гишүүнтэй, 34.2 хувь нь 7 гишүүнтэй байна.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн дагуу төрийн төв байгууллага, харьяа газар, төрийн болон орон нутгийн өмчит улсын үйлдвэрийн газар, төсөвт байгууллагуудын дэргэд Ёс зүйн дэд хороотой байхаар заасан ч улсын хэмжээний 4,239 төрийн байгууллагаас 2,281 буюу 53.8 хувь нь, нийслэлийн хэмжээний 869 байгууллагаас 473 буюу 54.4 хувь нь дэргэдээ Ёс зүйн дэд хороогоо байгуулж үйл ажиллагаа явуулж байна.

Байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороод нь зөрчил илрүүлэх, урьдчилан сэргийлэх, сургалт, зөвлөмж боловсруулах чиглэлээр ажиллах замаар төрийн албан хаагчдын ёс зүйг дээшлүүлэх гол институтийн үүргийг гүйцэтгэдэг.

Гэвч 2024 оны судалгаанаас харахад улсын хэмжээнд 1958, Улаанбаатар хотын хэмжээнд 396 байгууллага Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж Ёс зүйн дэд хороог байгуулах, мөн үйл ажиллагаа нь эхэлсэн 2281 Ёс зүйн дэд хороодын ажлыг чадавхжуулах, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанартай гүйцэтгэх шаардлагатай гэж харагдаж байна.

Тодруулбал орон нутгийн засаг захиргаа нь төрийн бодлого, шийдвэрийг иргэдэд хамгийн ойр түвшинд хэрэгжүүлдэг онцлогтой. Энэ утгаараа дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба нь төрийн албаны ёс зүйн соёлыг төлөвшүүлэх, иргэдийн итгэлийг хадгалахад чухал байр суурь эзэлдэг. Гэвч практикт ёс зүйн асуудлыг системтэйгээр авч үзэх бус, зөрчил гарсан тохиолдолд л анхаарах хандлага давамгайлж байна.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль батлагдсанаар ёс зүйн асуудлыг байгууллагын түвшинд шийдвэрлэх эрх зүйн орчин бүрдсэн хэдий ч хэрэгжилтийн бодит байдал нь судалгаа хийх шаардлагатай байгааг харуулж байна. Ялангуяа дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны дэргэдэх ёс зүйн дэд хороодын үйл ажиллагаа тогтмолжоогүй байгаа нь хууль хэрэгжилтийн үр нөлөөг бууруулж байна.

Иймд дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны дэргэдэх Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны өнөөгийн байдлыг судалж, эрх зүйн зохицуулалтын хэрэгжилт, практикт тулгамдаж буй асуудлыг тодорхойлон, цаашид сайжруулах санал, дүгнэлтийг боловсруулахаар энэхүү судалгааны зорилгоо тодорхойллоо.

ҮНДСЭН ХЭСЭГ

Нэг. Судалж буй асуудлын үндэслэл

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилтийг хангахад Ёс зүйн дэд хороо нь байгууллагын түвшинд ёс зүйн зөрчлийг хянан хэлэлцэх, дүгнэлт гаргах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах замаар хуулийн бодит хэрэгжилтийг хангах үндсэн үүргийг гүйцэтгэдэг.

Мөн төрийн албан хаагчдын ёс зүйн мэдлэг, хандлагыг дээшлүүлэх, шударга, хариуцлагатай төрийн албыг төлөвшүүлэхэд чухал институтийн үүрэгтэй. Гэвч өнөөгийн нөхцөл байдалд Ёс зүйн дэд хороо нь хууль ёсоор байгуулагдаагүй, үйл ажиллагаагаа төлөвлөж, тайлагнадаггүй зэргээс эхлээд ёс зүйн зөрчлийг хянан хэлэлцэх, эрх зүйн үндэслэлтэй дүгнэлт гаргах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг системтэйгээр хэрэгжүүлэхгүй байгаа нь ажиглагдаж байна. Энэ нь ёс зүйн хяналтын тогтолцоо бодит үр нөлөөгөө алдаж, Ёс зүйн дэд хороодын үйл ажиллагаа хуульд заасан чиг үүргээ бүрэн дүүрэн хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байдал үүсэх магадлалтай юм.

Иймд дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны дэргэдэх Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн, үйл ажиллагааны төлөвлөлт, тайлагнал, хуралдаан, дүгнэлт гаргалт, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, зөвлөмжийн хэрэгжилт болон гомдол, мэдээлэл хянан шийдвэрлэх үйл ажиллагаа нь хууль, журамд нийцэж буй эсэхийг судлан тогтоож, холбогдох арга хэмжээг авах нь Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжилтийг бодитоор хангах, төрийн албаны ёс зүйг бэхжүүлэх, улмаар иргэдийн төрд итгэх итгэлийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой билээ.

Энэхүү суурь судалгааг хийснээр судалгааны дараагийн бүлгүүдэд дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны дэргэдэх ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг эмпирик байдлаар шинжлэх, үнэлэх, цаашид сайжруулах санал боловсруулахад ашиглагдах аналитик хүрээг бүрдүүлнэ.

Хоёр. Судалгааны явц, үр дүн, хэлэлцэмз:

Судалгааны явц: Энэхүү судалгааны зорилго нь дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны дэргэдэх Ёс зүйн дэд хорооны чиг үүргийн хэрэгжилтийн өнөөгийн байдлыг судалж, практикт тулгамдаж буй асуудлыг тодорхойлон, цаашид сайжруулах санал, дүгнэлтийг боловсруулахад оршино.

Зорилгод хүрэхийн тулд судалгааг чанарын болон тоон судалгааны аргуудыг ашигласан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны дэргэдэх Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн, үйл ажиллагааны төлөвлөлт, тайлагнал, хуралдаан, дүгнэлт гаргалт, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, зөвлөмжийн хэрэгжилт болон гомдол, мэдээлэл хянан шийдвэрлэх үйл ажиллагаа өнөөгийн байдлыг тодорхойлох зорилтыг дэвшүүлж, хэрэгжүүллээ. Дэвшүүлсэн зорилтод хариулт авахын тулд дараах асуултын хүрээнд дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны дэргэдэх Ёс зүйн дэд хорооны баримт бичгийг судлан шинжилсэн. Үүнд:

Асуулга-1.Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны дэргэдэх Ёс зүйн дэд хорооны одоогийн бүрэлдэхүүнийг

хууль, журамд заасан шаардлагад нийцүүлэн байгуулсан эсэх?

Судалгаанд хамрагдсан 9 дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны дэргэдэх Ёс зүйн дэд хороодын томилгоо, бүрэлдэхүүн, дарга сонгох журмын хэрэгжилт нь орон нутгийн түвшинд жигд бус байгааг тогтоолоо. Нийт албан хаагчдын олонхын дэмжлэгийг авч гишүүнээр томилсон Багахангай, Баянгол, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүрэг дэд хороод, байгууллагын албан хаагчийн тоонд нийцсэн бүрэлдэхүүнтэй Багахангай, Багануур, Налайх, Сонгинохайрхан, Хан-Уул, Чингэлтэй зэрэг нийт 6 дэд хороо, Багахангай, Баянгол, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргийн дэд хорооны гишүүд дотроосоо даргаа сонгосон байхад үлдсэн нь хууль, журмыг хангаагүй бөгөөд энэ нь Дэд хорооны хараат бус байдал, дотоод засаглал, шийдвэр гаргалтын шударга байдалд эргэлзээ үүсгэж, ёс зүйн зөрчлийг хянах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үр нөлөөг сулруулах эрсдэлтэйг харуулж байна.

Хүснэгт №1

№	Дэд хорооны харьяалал	Нийт албан хаагчдын олонхын дэмжлэг авсан хүнийг Ёс зүйн дэд хорооны гишүүнээр томилсон эсэх	Ёс зүйн дэд хороо нь байгууллагын албан хаагчийн тооноос хамаарсан эсэх	Гишүүд дотроосоо даргаа сонгосон эсэх
1	Багахангай дүүрэг	Тийм	Тийм	Тийм
2	Багануур дүүрэг	Үгүй	Тийм	Үгүй
3	Баянгол дүүрэг	Тийм	Үгүй	Тийм
4	Баянзүрх дүүрэг	Үгүй	Үгүй	Үгүй
5	Налайх дүүрэг	Үгүй	Тийм	Үгүй
6	Сонгинохайрхан дүүрэг	Тийм	Тийм	Тийм
7	Сүхбаатар дүүрэг	-	-	-
8	Хан-Уул дүүрэг	Үгүй	Тийм	Үгүй
9	Чингэлтэй дүүрэг	Тийм	Тийм	Тийм

Асуулга-2.Ёс зүйн дэд хороо нь хууль, журамд заасны дагуу үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилладаг эсэх?

Судалгаанд хамрагдсан Ёс зүйн дэд хороо тус бүр үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг зохион байгуулсан эсэхийг үнэлэхэд 4 нь баталж, 4 нь батлаагүй нь тогтоогдлоо. Мөн Дэд хорооны үйл ажиллагааны явцад ил тод байдлыг хангаж ажилласан эсэхийг үнэлэхэд Дэд хороод төлөвлөгөө боловсруулалт, хэрэгжилтэд тогтмол хяналт, нээлттэй мэдээллийн тогтолцоо алдагдсан байгааг харуулж байна. Энэхүү сул тал нь Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны үр нөлөөг бууруулж, иргэд болон албан хаагчдын итгэлд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй юм.

Хүснэгт №2

№	Дэд хорооны харьяалал	Дэд хорооны үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, хэрэгжилтийг зохион байгуулсан эсэх	Ил тод байдлыг хангасан эсэх
1	Багахангай дүүрэг	Үгүй	Үгүй
2	Багануур дүүрэг	Тийм	Үгүй
3	Баянгол дүүрэг	Үгүй	Үгүй
4	Баянзүрх дүүрэг	Үгүй	Үгүй
5	Налайх дүүрэг	Тийм	Үгүй
6	Сонгинохайрхан дүүрэг	Тийм	Үгүй
7	Сүхбаатар дүүрэг	-	-
8	Хан-Уул дүүрэг	Үгүй	Үгүй
9	Чингэлтэй дүүрэг	Тийм	Үгүй

Асуулга-3.Ёс зүйн дэд хороо нь хуульд заасан хугацаанд үйл ажиллагааны тайлан, ёс зүйн зөрчилтэй холбоотой мэдээллийг бэлтгэн тайлагнаж, тайлан нь бодит байдал, үр нөлөөг хангаж чадсан эсэх?

Судалгаанд хамрагдсан Ёс зүйн дэд хороод бүгд үйл ажиллагааны тайланг Ёс зүйн хороонд хүргүүлээгүй, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой тайлан, мэдээг улирал бүр гаргаагүй бөгөөд үйл ажиллагааны явцдаа ил тод байдлыг хангаагүй нь тогтоогдсон. Энэ нь дэд хорооны тайлагнал, хяналт, мэдээллийн тогтолцооны сул байдлыг харуулж, ёс зүйн зөрчлийг хянах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үр нөлөөг бууруулж, байгууллагын дотоод засаглал, иргэдийн итгэлд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй болохыг илтгэж байна. /Хавсралт, хүснэгт №1/

Асуулга-4.Ёс зүйн дэд хороо нь хуралдаан бүрийн тэмдэглэлийг хууль, журамд нийцүүлэн тогтмол хөтөлж, албан ёсоор баталгаажуулдаг эсэх?

Судалгаанд хамрагдсан ёс зүйн дэд хороо хуралдааны тэмдэглэл хөтөлж, албан ёсоор баталгаажуулсан эсэхтэй танилцахад 4 нь хөтөлсөн бол үлдсэн 4 нь тэмдэглэл хөтлөөгүй байна. Энэ нь дэд хорооны үйл ажиллагааны баримт бичгийн бүрдүүлэлт, хяналт-шинжилгээний тогтолцоо орон нутгийн түвшинд жигд бус байгааг илтгэж байна. Хуралдааны тэмдэглэл хөтлөх, баталгаажуулахгүй байх нь хэлэлцсэн асуудал, гаргасан дүгнэлт, шийдвэрийг үнэн зөв, бүрэн бүртгэх боломжийг алдагдуулж, дэд хорооны ил тод байдал, хариуцлагад сөрөг нөлөө үзүүлж болзошгүй юм.

Хүснэгт №3

№	Дэд хорооны харьяалал	Хуралдааны тэмдэглэл хөтөлж, албажуулсан эсэх
1	Багахангай дүүрэг	Үгүй
2	Багануур дүүрэг	Тийм
3	Баянгол дүүрэг	Тийм
4	Баянзүрх дүүрэг	Үгүй
5	Налайх дүүрэг	Үгүй
6	Сонгинохайрхан дүүрэг	Тийм
7	Сүхбаатар дүүрэг	-
8	Хан-Уул дүүрэг	Үгүй
9	Чингэлтэй дүүрэг	Тийм

Асуулга-5.Ёс зүйн дэд хороо нь хэлэлцсэн ёс зүйн зөрчил бүрд хууль, журамд нийцсэн, үндэслэлтэй дүгнэлт гаргаж, албан ёсоор баталгаажуулдаг эсэх?

Судалгаанд хамрагдсан ёс зүйн дэд хороонд албан хаагчтай холбоотой гомдол, мэдээлэл ирээгүй тул ямар ч дүгнэлт гаргаагүй нь тогтоогдлоо. Энэ нь дэд хорооны дүгнэлт гаргах үйл ажиллагаа нь гомдол, мэдээллийн ирэлттэй шууд хамааралтай болохыг харуулж байна. Улмаар гомдол ирээгүй нөхцөлд дэд хорооны үйл ажиллагаа хэлбэрийн шинжтэй болж, ёс зүйн хяналт, урьдчилан сэргийлэх тогтолцооны үр нөлөө хязгаарлагдах эрсдэлтэй байна. /Хавсралт, хүснэгт №2/

Асуулга-6.Ёс зүйн дэд хороо нь ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сургалт, мэдээлэл, зөвлөмж зэрэг төлөвлөгөөт арга хэмжээг тогтмол, системтэйгээр хэрэгжүүлдэг эсэх?

Судалгаанд хамрагдсан ёс зүйн дэд хорооноос 6 буюу 75.0% нь сургалт зохион байгуулсан бол 2 нь зохион байгуулалгүй байсан нь дэд хорооны урьдчилан сэргийлэх сургалтын үйл ажиллагаа зарим байгууллагад бүрэн хэрэгжээгүйг харуулж байна. Мөн дэд хорооноос нөлөөллийн арга хэмжээ авч хэрэгжүүлсэн нь 4-д нь ажиглагдсан бөгөөд эдгээр байгууллагуудад урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үр нөлөө хангалттай байжээ. Энэхүү судалгаа нь дэд хорооны урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа нь сургалт, нөлөөллийн арга хэмжээний хэрэгжилттэй шууд хамааралтай бөгөөд зарим байгууллагад үр нөлөө нь хангалтгүй байгааг илтгэж байна.

Хүснэгт №4

№	Дэд хорооны харьяалал	Сургалт зохион байгуулсан эсэх	Нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан эсэх	Урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үр нөлөө
1	Багахангай дүүрэг	Тийм	Тийм	Хангалттай
2	Багануур дүүрэг	Үгүй	Үгүй	Тодорхойгүй
3	Баянгол дүүрэг	Тийм	Тийм	Хангалттай
4	Баянзүрх дүүрэг	Үгүй	Үгүй	Тодорхойгүй
5	Налайх дүүрэг	Тийм	Үгүй	Тодорхойгүй
6	Сонгинохайрхан дүүрэг	Тийм	Тийм	Хангалттай
7	Сүхбаатар дүүрэг	-	-	-
8	Хан-Уул дүүрэг	Тийм	Үгүй	Тодорхойгүй
9	Чингэлтэй дүүрэг	Тийм	Тийм	Хангалттай

Асуулга-7.Ёс зүйн дэд хороонь ёс зүйн зөрчил болон урьдчилан сэргийлэх үйл ажиллагаатай холбоотой зөвлөмжийг хууль, журамд нийцүүлэн тодорхой, үндэслэлтэйгээр боловсруулж, холбогдох этгээдэд албан ёсоор хүргүүлдэг эсэх?

Судалгаанд хамрагдсан Ёс зүйн дэд хороо бүгд ёс зүйн зөрчилтэй холбоотой болон урьдчилан сэргийлэх үйл ажиллагаатай холбоотой зөвлөмжийг гаргаагүй нь тогтоогдлоо. Энэ нь дэд хорооны зөвлөмж боловсруулж, хэрэгжилтэд нөлөөлөх үүрэг хэрэгжээгүйг харуулж, ёс зүйн зөрчлийг хянах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үр нөлөөг бууруулж, байгууллагын дотоод засаглал, ил тод байдалд сөрөг нөлөө үзүүлж болзошгүйг илтгэж байна. /Хавсралт, хүснэгт №3/

Асуулга-8.Ёс зүйн дэд хороонд иргэд болон байгууллагын албан хаагчдаас ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээлэл ирсэн эсэх?

Судалгаанд хамрагдсан Ёс зүйн дэд хорооноос нэг дэд хороо албан хаагчийн зөрчилтэй холбоотой гомдол мэдээллийг иргэдээс хүлээн авсан бол, байгууллагын албан хаагчдаас ямар ч гомдол, мэдээлэл ирээгүй нь тогтоогдлоо. Мөн ирсэн гомдол, мэдээллийг бүртгэн авч, хянан шийдвэрлэдэг үйл ажиллагаа бүх дэд хорооноос ажиглагдсангүй. Энэ нь дэд хорооны гомдол хүлээн авах, бүртгэх, шийдвэрлэх механизм бүрэн хэрэгжээгүйг харуулж, ёс зүйн зөрчлийг хянах, урьдчилан сэргийлэх тогтолцооны үр нөлөөг бууруулж болзошгүйг илтгэж байна. /Хавсралт, хүснэгт №4/

ТӨГСГӨЛ ХЭСЭГ

Дүгнэлт

Судалгаанд хамрагдсан Ёс зүйн дэд хороодын томилгоо, бүрэлдэхүүн, дарга сонгох журам, үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлагнал, хуралдааны тэмдэглэл, урьдчилан сэргийлэх сургалт,

нөлөөллийн арга хэмжээ, зөвлөмж, гомдол хүлээн авах болон бүртгэх механизм зэрэг бүх чиглэлээр хэрэгжилт орон нутгийн түвшинд жигд бус, зарим тохиолдолд огт хэрэгжээгүй болох нь тогтоогдлоо. Тухайлбал, нийт албан хаагчдын олонхын дэмжлэгийг авсан гишүүнээр томилсон дэд хороо тэн хагас, байгууллагын албан хаагчийн тоонд нийцсэн бүрэлдэхүүнтэй дэд хороо 6, дотроосоо даргаа сонгосон дэд хороо 4 байхад үлдсэн нь хууль, журмыг хангаагүй; үйл ажиллагааны төлөвлөгөө баталж хэрэгжүүлсэн нь 4, батлаагүй нь 4, тайланг Ёс зүйн хороонд хүргүүлээгүй, улирал бүр тайлан гаргаагүй, ил тод байдлыг хангаагүй; хуралдааны тэмдэглэл хөтөлж баталгаажуулсан нь 4, хөтлөөгүй нь 4; сургалт зохион байгуулсан нь 6, зохион байгуулалгүй нь 2; нөлөөллийн арга хэмжээ авч хэрэгжүүлсэн нь 4, зөвлөмж гаргасан нь бүгд үгүй; гомдол, мэдээллийг хүлээн авч, бүртгэн шийдвэрлэсэн нь бүх дэд хорооноос ажиглагдаагүй зэрэг ажиглалт гарсан. Эдгээр үр дүн нь дэд хорооны хараат бус байдал, дотоод засаглал, шийдвэр гаргалтын шударга байдалд эргэлзээ үүсгэж, ёс зүйн зөрчлийг хянах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үр нөлөөг бууруулж, байгууллагын ил тод байдал, иргэд болон албан хаагчдын итгэлд сөрөг нөлөө үзүүлж болзошгүйг харуулж байна. Судалгааны дүнгээс харахад, дэд хорооны үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэхийн тулд томилгоо, бүрэлдэхүүн, дарга сонголт, төлөвлөгөө, тайлан, сургалт, зөвлөмж, гомдол хүлээн авах механизм зэрэг бүхий л процессын тогтмол хэрэгжилт, ил тод байдлыг хангах шаардлагатай байна.

Харин Дэд хороогоо байгуулаагүй Сүхбаатар дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанд ёс зүйн хяналт, урьдчилан сэргийлэх тогтолцоо бүрэн байгуулагдаагүй, гомдол, мэдээллийг хүлээн авах, дүгнэлт гаргах, зөвлөмж өгөх, сургалт зохион байгуулах зэрэг үндсэн үүргүүд хэрэгжих боломжгүй байгааг харуулж, энэ нь албан хаагчдын ёс зүйн сахилга, дотоод засаглал, байгууллагын ил тод байдалд эрсдэл үүсгэж, иргэдийн итгэлд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэйг илтгэж байна.

Санал:

1.Дэд хороог хууль, журамд нийцүүлэн бүрэн байгуулах

• Бүх дүүргийн ИТХ-ын ажлын албанд ёс зүйн дэд хороо байгуулж, гишүүдийг нийт албан хаагчдын олонхын дэмжлэгээр томилж, байгууллагын албан хаагчийн тоонд тохирсон бүрэлдэхүүнтэй, дотроосоо даргаа сонгосон байдлыг хангах.

2.Үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, ил тод байдлыг тогтмол хангах

• Дэд хороо бүрэн төлөвлөгөө боловсруулж баталж, хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж, үйл ажиллагааны тайланг улирал бүр Ёс зүйн хороонд хүргүүлэх.

• Хуралдааны тэмдэглэл, дүгнэлт, зөвлөмжийг албан ёсоор

баталгаажуулж, ил тод байдлыг хангах механизмыг бүрдүүлэх.

3.Урьдчилан сэргийлэх сургалт, нөлөөллийн арга хэмжээг тогтмол зохион байгуулах

• Албан хаагчдын ёс зүйн мэдлэг, хандлагыг дээшлүүлэх сургалт, зөвлөмж, мэдээллийн арга хэмжээг тогтмол явуулж, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх.

4.Гомдол, мэдээлэл хүлээн авах, бүртгэх, шийдвэрлэх механизмыг хэрэгжүүлэх

• Иргэд болон албан хаагчдаас ирсэн ёс зүйн зөрчлийн гомдол, мэдээллийг бүртгэн авч, хянан шийдвэрлэх журам, тайлан, дүгнэлтийн тогтолцоог бүрдүүлэх.

5.Үр дүнгийн хяналт, үнэлгээг тогтмол явуулах

• Дэд хорооны үйл ажиллагааны үр нөлөөг үнэлэх тогтмол механизмыг хэрэгжүүлж, бодит үр дүнг харуулсан судалгааны тайлан гаргах, ил тод мэдээллийг нийтэд нээлттэй болгох.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Хууль тогтоомж;

-Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль. 2023 оны 05 дугаар сарын 04-ны өдөр. Улаанбаатар хот.

-Төрийн албаны тухай хууль. 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдөр. Улаанбаатар хот.

УИХ, ЗГ-ын тогтоол, бодлогын баримт бичиг;

-“Ёс зүйн хэм хэмжээ батлах тухай” Засгийн газрын 109 дүгээр тогтоол. 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдөр. Улаанбаатар хот.

-“Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын 27 дугаар тогтоол. 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр. Улаанбаатар хот.

Ном, сурах бичиг, гарын авлага;

-Монгол Улсын Ёс зүйн хороо (2024), Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн хэрэгжилт, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн нэгдсэн дүн, төлөв байдлын тайлан. Улаанбаатар хот.

Цахим эх сурвалж;

-Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль. 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдөр. Улаанбаатар хот. https://legalinfo.mn/mn/detail?lawId=16759635984401, 2025 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн хандалтаар.

Төрийн албаны тухай хууль. 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдөр. Улаанбаатар хот. https://legalinfo.mn/mn/detail/13025, 2025 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн хандалтаар.

Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай Улсын Их Хурлын тогтоол. 2024 оны https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140486321781, 2025 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн хандалтаар.

Ёс зүйн хэм хэмжээ батлах тухай Засгийн газрын 109 дүгээр тогтоол. 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдөр. Улаанбаатар хот. https://legalinfo.mn/mn/detail?lawId=171416308 2432, 2025 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн хандалтаар.

Журам батлах тухай Ёс зүйн хорооны 05 дугаар тогтоол. 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдөр. Улаанбаатар хот. https://legalinfo.mn/mn/detail?lawId=17089853686991, 2025 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн хандалтаар.

Хавсралт

Хүснэгт №1

№	Дэд хорооны харьяалал	Үйл ажиллагааны тай ланг Ёс зүйн хороонд хүргүүлсэн эсэх	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбогдох тайлан, мэдээг улирал бүр гаргасан эсэх	Ил тод байдлыг хангасан эсэх
1	Багахангай дүүрэг	Үгүй	Үгүй	Үгүй
2	Багануур дүүрэг	Үгүй	Үгүй	Үгүй
3	Баянгол дүүрэг	Үгүй	Үгүй	Үгүй
4	Баянзүрх дүүрэг	Үгүй	Үгүй	Үгүй
5	Налайх дүүрэг	Үгүй	Үгүй	Үгүй
6	Сонгинохайрхан дүүрэг	Үгүй	Үгүй	Үгүй
7	Сүхбаатар дүүрэг	-	-	-
8	Хан-Уул дүүрэг	Үгүй	Үгүй	Үгүй
9	Чингэлтэй дүүрэг	Үгүй	Үгүй	Үгүй

Хүснэгт №2

№	Дэд хорооны харьяалал	Дүгнэлт гаргасан эсэх
1	Багахангай дүүрэг	Үгүй
2	Багануур дүүрэг	Үгүй
3	Баянгол дүүрэг	Үгүй
4	Баянзүрх дүүрэг	Үгүй
5	Налайх дүүрэг	Үгүй
6	Сонгинохайрхан дүүрэг	Үгүй
7	Сүхбаатар дүүрэг	-
8	Хан-Уул дүүрэг	Үгүй
9	Чингэлтэй дүүрэг	Үгүй

Хүснэгт №3

№	Дэд хорооны харьяалал	Ёс зүйн зөрчилтэй холбоотой зөвлөмж гаргасан эсэх	Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаатай холбоотой зөвлөмж гаргасан эсэх
1	Багахангай дүүрэг	Үгүй	Үгүй

2	Баганаур дүүрэг	Үгүй	Үгүй
3	Баянгол дүүрэг	Үгүй	Үгүй
4	Баянзүрх дүүрэг	Үгүй	Үгүй
5	Налайх дүүрэг	Үгүй	Үгүй
6	Сонгинохайрхан дүүрэг	Үгүй	Үгүй
7	Сүхбаатар дүүрэг	-	-
8	Хан-Уул дүүрэг	Үгүй	Үгүй
9	Чингэлтэй дүүрэг	Үгүй	Үгүй

Хүснэгт №4

№	Дэд хорооны харьяалал	Иргэдээс гомдол, мэдээлэл ирүүлсэн эсэх	Байгууллагын албан хаагчдаас гомдол, мэдээлэл ирүүлсэн эсэх	Ирсэн гомдол, мэдээллийг бүртгэн авч, хянан шийдвэрлэдэг эсэх
1	Багахангай дүүрэг	Үгүй	Үгүй	Үгүй
2	Баганаур дүүрэг	Үгүй	Үгүй	Үгүй
3	Баянгол дүүрэг	Үгүй	Үгүй	Үгүй
4	Баянзүрх дүүрэг	Үгүй	Үгүй	Үгүй
5	Налайх дүүрэг	Тийм	Үгүй	Үгүй
6	Сонгинохайрхан дүүрэг	Үгүй	Үгүй	Үгүй
7	Сүхбаатар дүүрэг	-	-	-
8	Хан-Уул дүүрэг	Үгүй	Үгүй	Үгүй
9	Чингэлтэй дүүрэг	Үгүй	Үгүй	Үгүй

Монголын хил судлалын академи, ДХИС-ийн Хилийн албаны сургууль,
Хилийн аюулгүй байдал судлалын төв

ХИЛ СУДЛАЛ

ШИНЖЛЭХ УХААН, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУРГАЛТ, АРГА ЗҮЙ, ТАНИН МЭДЭХҮЙН УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛ



2025

03

Монголын хил судлалын академи, ДХИС-ийн Хилийн албаны сургууль,
Хилийн аюулгүй байдал судлалын төв

ХИЛ СУДЛАЛ

ШИНЖЛЭХ УХААН, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУРГАЛТ, АРГА ЗҮЙ, ТАНИН МЭДЭХҮЙН УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛ



2025

03

Монголын хил судлалын академи, ДХИС-ийн Хилийн албаны сургууль,
Хилийн аюулгүй байдал судлалын төв

ХИЛ СУДЛАЛ

ШИНЖЛЭХ УХААН, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУРГАЛТ, АРГА ЗҮЙ, ТАНИН МЭДЭХҮЙН УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛ



2025

03

Монголын хил судлалын академи, ДХИС-ийн Хилийн албаны сургууль,
Хилийн аюулгүй байдал судлалын төв

ХИЛ СУДЛАЛ

ШИНЖЛЭХ УХААН, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУРГАЛТ, АРГА ЗҮЙ, ТАНИН МЭДЭХҮЙН УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛ



2025

03

Монголын хил судлалын академи, ДХИС-ийн Хилийн албаны сургууль,
Хилийн аюулгүй байдал судлалын төв

ХИЛ СУДЛАЛ

ШИНЖЛЭХ УХААН, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУРГАЛТ, АРГА ЗҮЙ, ТАНИН МЭДЭХҮЙН УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛ



2025

03

Монголын хил судлалын академи, ДХИС-ийн Хилийн албаны сургууль,
Хилийн аюулгүй байдал судлалын төв

ХИЛ СУДЛАЛ

ШИНЖЛЭХ УХААН, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУРГАЛТ, АРГА ЗҮЙ, ТАНИН МЭДЭХҮЙН УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛ



2025

03

Монголын хил судлалын академи, ДХИС-ийн Хилийн албаны сургууль,
Хилийн аюулгүй байдал судлалын төв

ХИЛ СУДЛАЛ

ШИНЖЛЭХ УХААН, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУРГАЛТ, АРГА ЗҮЙ, ТАНИН МЭДЭХҮЙН УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛ



2025

03

Монголын хил судлалын академи, ДХИС-ийн Хилийн албаны сургууль,
Хилийн аюулгүй байдал судлалын төв

ХИЛ СУДЛАЛ

ШИНЖЛЭХ УХААН, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУРГАЛТ, АРГА ЗҮЙ, ТАНИН МЭДЭХҮЙН УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛ



2025

03

Монголын хил судлалын академи, ДХИС-ийн Хилийн албаны сургууль,
Хилийн аюулгүй байдал судлалын төв

ХИЛ СУДЛАЛ

ШИНЖЛЭХ УХААН, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУРГАЛТ, АРГА ЗҮЙ, ТАНИН МЭДЭХҮЙН УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛ



2025

03

Монголын хил судлалын академи, ДХИС-ийн Хилийн албаны сургууль,
Хилийн аюулгүй байдал судлалын төв

ХИЛ СУДЛАЛ

ШИНЖЛЭХ УХААН, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУРГАЛТ, АРГА ЗҮЙ, ТАНИН МЭДЭХҮЙН УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛ



2025

03

Монголын хил судлалын академи, ДХИС-ийн Хилийн албаны сургууль,
Хилийн аюулгүй байдал судлалын төв

ХИЛ СУДЛАЛ

ШИНЖЛЭХ УХААН, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУРГАЛТ, АРГА ЗҮЙ, ТАНИН МЭДЭХҮЙН УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛ



2025

03

Монголын хил судлалын академи, ДХИС-ийн Хилийн албаны сургууль,
Хилийн аюулгүй байдал судлалын төв

ХИЛ СУДЛАЛ

ШИНЖЛЭХ УХААН, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУРГАЛТ, АРГА ЗҮЙ, ТАНИН МЭДЭХҮЙН УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛ



2025

03

Монголын хил судлалын академи, ДХИС-ийн Хилийн албаны сургууль,
Хилийн аюулгүй байдал судлалын төв

ХИЛ СУДЛАЛ

ШИНЖЛЭХ УХААН, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУРГАЛТ, АРГА ЗҮЙ, ТАНИН МЭДЭХҮЙН УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛ



2025

03

Монголын хил судлалын академи, ДХИС-ийн Хилийн албаны сургууль,
Хилийн аюулгүй байдал судлалын төв

ХИЛ СУДЛАЛ

